МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



# ТУРШИЛТЫН СУРГУУЛИЙН ЖИШЭЭНИЙ ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2019 он

**Хянасан:**

МУБИС, Боловсрол судлалын сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхмийн эрхлэгч дэд.проф.доктор Ph.D Г.БАТЦЭНГЭЛ

**Хамтран ажилласан:**

Ерөнхий боловсролын 25 дугаар тусгай сургууль
Ерөнхий боловсролын 55 дугаар тусгай сургууль
Ерөнхий боловсролын 63 дугаар тусгай сургууль
Ерөнхий боловсролын 70 дугаар тусгай сургууль
Ерөнхий боловсролын 16 дугаар сургууль
Ерөнхий боловсролын 35 дугаар сургууль
Ерөнхий боловсролын 28 дугаар сургууль
Ерөнхий боловсролын 113 дугаар сургууль
Ерөнхий боловсролын 26 дугаар сургууль
Ерөнхий боловсролын 34 дүгээр сургууль
Ерөнхий боловсролын 79 дүгээр сургууль
Ерөнхий боловсролын 111 дүгээр сургууль
Хөвсгөл аймаг:
Ерөнхий боловсролын “Ирээдүй XXI зуун” цогцолбор сургууль
Ерөнхий боловсролын “ТИТЭМ” дунд сургууль

*Энэхүү ном нь Монгол улсын “Зохиогчийн эрхийн тухай” хуулиар баталгаажсан тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр хувилан олшруулах, түгээн тараахыг хориглоно.*

# ГАРЧИГ

**ЭХЛЭЛ**

1. Туршилтын ерөнхий боловсролын тусгай сургуулийн жишээ 5
   1-1. Ерөнхий боловсролын 25 дугаар тусгай сургууль /3 дугаар анги/ 6
   1-2 Ерөнхий боловсролын 25 дугаар тусгай сургууль /6 дугаар анги/ 16
   1-3. Ерөнхий боловсролын 55 дугаар тусгай сургууль /3 дугаар анги/ 26
   1-4. Ерөнхий боловсролын 63 дугаар тусгай сургууль /3 дугаар анги/ 35
   1-5. Ерөнхий боловсролын 70 дугаар тусгай сургууль /3 дугаар анги/ 47
   1-6. Е Ерөнхий боловсролын 70 дугаар тусгай сургууль /9 дүгээр анги/ 58

2. Туршилтын ерөнхий боловсролын ердийн сургуулийн жишээ 71
   2-1. Ерөнхий боловсролын 16 дугаар сургууль 72
   2-2. Ерөнхий боловсролын 35 дугаар сургууль 74
   2-3. Ерөнхий боловсролын 28 дугаар сургууль 75
   2-4. Ерөнхий боловсролын 113 дугаар сургууль 78
   2-5. Ерөнхий боловсролын 26 дугаар сургууль 79
   2-6. Ерөнхий боловсролын 34 дүгээр сургууль 85
   2-7. Ерөнхий боловсролын 79 дүгээр сургууль 89
   2-8. Ерөнхий боловсролын 111 дугаар сургууль 91
   2-9. Ерөнхий боловсролын “Ирээдүй XXI зуун” цогцолбор сургууль 93
   2-10. Ерөнхий боловсролын “ТИТЭМ” дунд сургууль 101

**ХАВСРАЛТ МАТЕРИАЛ**

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/155 дугаар тушаал /2018.03. 29/ 106
   - “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар” /нэгдүгээр хавсралт/ 107
   - “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал” /хоёрдугаар хавсралт/ 113

2. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн загвар /хураангуй/ 131

# ӨМНӨХ ҮГ

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн туршилтын ерөнхий боловсролын 4 тусгай сургууль ба 10 ердийн сургууль дээр төслийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жишээг эмхэтгэн танд толилуулж байна.

“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ СУРГУУЛИЙН ЖИШЭЭ” хэсгийн агуулгад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахаар сонгосон хүүхдэд чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх тохирох төлөвлөгөөг боловсруулсан агуулгыг оруулсан болно. Судалгаат хичээлийг хэрхэн явуулж байгааг жишээг видео хэрэглэгдэхүүн болгон хэвлэж хавсаргалаа. Тус гарын авлага нь хөгжлийн өөр өөр түвшин, бэрхшээлийн онцлог бүхий хүүхдэд тохирсон арга зүйг багш хэрхэн төлөвлөж ажиллахад санаа өгч тус нэмэр болж чадна гэж найдаж байна.

“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЕРДИЙН СУРГУУЛИЙН ЖИШЭЭ” хэсгийн агуулгад сургуулийн орчинг сайжруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх жишээг эмхэтгэн оруулав.

Харин хавсралт материал хэсэгт 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/155 дугаар тушаалыг хавсралтын хамтаар мөн ээлжит хичээлийн хөтөлбөрийн хураангуй загварыг оруулсан тул багш та бүхэн сургалтын үйл ажиллагаандаа авч хэрэглэнэ үү.

# 1

# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ СУРГУУЛИЙН ЖИШЭЭ






## 1-1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 25 ДУГААР ТУСГАЙ СУРГУУЛЬ (3 ДУГААР АНГИ)

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө – Бодит байдлын судалгааны хүснэгт

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Анги | [redacted] анги [redacted] бүлэг | [redacted] | | Боловсруулсан он | 2017 он 09 сар 12 өдөр |
| Овог нэр | [redacted] | Хүйс | 1.эр | Төрсөн огноо /нас/ | [redacted] |
| Эцэг эхийн нэр | [redacted] | Гэр бүлийн байдал | Аав, ээж, эгч, дүү | Нэмэлт мэдээлэл | |
| Гэрийн хаяг | [redacted] | Холбоо барих утас | [redacted] | E-mail | |
| Эрүүл мэндийн байгууллагын оноштой эсэх | Оюун ухааны бэрхшээл | Онош тавьсан ЭМ-ийн байгууллагын нэр | Эх нялхасын эрүүл мэндийн нэгдсэн төв | Сургуульд элсэн орсон нас | 6 настай |
| Оношилгоо үнэлгээ хийгдсэн эсэх | Сургуулийн комиссын үнэлгээ (нийслэлд)хийгдсэн эсэх<br><u>Тийм</u> (хугацаа 2015.08.25)<br>Салбар комиссын оношилгоо, хөгжлийн үнэлгээ хийгдсэн эсэх<br><u>Үгүй</u> | | ☑ Оюун ухааны бэрхшээл<br>□Тулах эрхтний бэрхшээл<br>□Аутизмын хүрээний эмгэг<br>□Дауны синдром<br>☑ Хэл ярианы бэрхшээл | □Суралцах бэрхшээл<br>□Сэтгэлийн хөдөлгөөн зан үйлийн эмгэг<br>□Харааны бэрхшээл<br>□Сонсголын бэрхшээл<br>□Бусад ( ) | |
| Хавсарсан бэрхшээлтэй эсэх /уналт таталт, зүрхний өвчин, арьсны өвчин г.м/ | Тийм | Гадаад, дотоодын байгууллагаар оношилгоо, үнэлгээ хийлгэж байсан эсэх | Гадаадад болон дотоодод оношилгоо, үнэлгээ хийлгэсэн үр дүн (үгүй)<br>Бусад( ) | Эрүүл мэндийн байгууллагатай холбоотой байгаа эсэх | <u>Тийм</u> /дэлгэрэнгүй бичих/<br>Эх нялхас эрүүл мэндийн төв |

| | |
|---|---|
| | 1.Төрсний дараа /0-12 сар хүртэл//Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглаж болно/<br>• Төрөхдөө тархины харвалт өгсөн<br>• Зүрхний цоорхойг Солонгос улсад нөхүүлсэн.<br>Зөөлөн тагнай сэтэрхий, Эх нялхсын эрүүл мэндийн төвд хагалгаанд орсон |
| | 2. Сургуульд орохоос өмнөх байдал /2-5 нас/<br>Цэцэрлэгт явж байсан эсэх /тийм / үгүй/ /Цэцэрлэгийн нэр: 10-р цэцэрлэг /<br>Яваагүй бол шалтгааныг бичнэ үү / / |
| Хүүхдийн хувийн онцлог, бодит байдал /дуртай зүйл- давуу тал дургүй зүйл – бүдрэлт саад г.м / | 3. Сургуульд орсон цагаас эхлэн өнөөг хүртэлх хүүхдийн байдал /тэргэнцэртэй эсэх, ганцаараа сургуульдаа ирж очдог эсэх гэх мэтийг оруулан бичих/<br>• Өөртөө үйлчлэх энгийн чадвар<br>✓ Аяганд цай болон жүүс хийж өгөхөд, бие дааж аягаа бариад асгалгүйгээр ууж чадна. Харин хоолыг халбагдаж идэж чадахгүй.<br>✓ Анги болон цайны газарт бие даан очиж чадна.<br>• Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол<br>✓ Өөрийн хэрэгцээ шаардлагаа орилон дуугарч эсвэл дохио зангаагаар илэрхийлдэг.<br>✓ Өгөгдсөн дүрсийг ихээс нь бага руу эрэмбэлж хийж чадахгүй, гарт тааралдсан дүрсээ хийдэг.<br>✓ Цифр, дүрс, өнгө ялгаж чаддаггүй.<br>• Нийгэмшихүй<br>✓ Ангийн сурагчидтайгаа жагсаалаар явж бие засах газарт очиж чадна.<br>✓ Завсарлагаанаар Төрийн дуу дуулахад нэг эгнээнд бусад хүүхдийн адил зогсож чадна.<br>✓ Найз нөхөдөөрөө хөтлүүлж явдаг болсон.<br>• Хөдөлгөөн<br>✓ Анх сургуульд орохдоо хөдөлгөөн нь удаан, заавал хөтлүүлж явдаг байсан бол одоо анги танхим болон цайны газраар чөлөөтэй явдаг болсон. |
| Хүүхдийн өөрийн хүсэл, зорилго | Өөрийн дураар тэнэж явах сонирхолтой. |
| Эцэг эхийн хүсэл, зорилго | Нийгэмших, бусадтай харилцах, өөртөө үйлчлэх чадварыг нэмэгдүүлэх |
| Багшийн хүсэл, зорилго | Өөртөө үйлчлэх чадварт суралцуулах |

## Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө ( 1 ул - 2 ул - 3 ул - 4ул )

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Анги | [redacted] анги [redacted] бүлэг | АУБ | [redacted] | Боловсруулсан огноо | 2017 он 9 сар 12 өдөр |
| Овог нэр | [redacted] | Хүйс | эр | Төрсөн огноо (Нас) | [redacted] |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Урт хугацааны зорилт | Өөртөө үйлчлэх энгийн чадвар | Бие даан гадуур хувцасаа өмсөж, товчоо товчлож сурах. | Дэмжлэгийн орчин буюу хэзээ, хаана, ямар үед | Сургууль дээр ирэх, явах үед |
| | Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | ✓ Авиан сонсгол хөгжүүлэх, эгшиг авиаг дагаж хэлэх<br>✓ А, О, У авиаг таниулах<br>✓ Юмсыг өнгө хэлбэр дүрсийг ижлээр нь олох | | Математик<br>Хэл яриа, Монгол хэл |
| | Нийгэмшихүй | Суух чадварыг 5 – 10 минут нэмэгдүүлж зөв суулгаж сургах | | Бүх хичээл дээр суух чадварыг нэмэгдүүлнэ. |

| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | Улирлын зорилт (Богино хугацааны зорилт) | Хичээлийн агуулга | Багшийн дэмжлэг, арга зүй /дэлгэрэнгүй/ | Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн орчинд | Гэрийн нөхцөлд | Боловсруулсан багш |
| **Сургуулийн амьдрал хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар** | Шүүгээнээс гадуур хувцасаа өөрөө авах | | Багшийн тусламжтай шүүгээний нүдийг нээх | | | [redacted] |

| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | | Улирлын зорилт (Богино хугацааны зорилт) | Хичээлийн агуулга | Багшийн дэмжлэг, арга зүй /дэлгэрэнгүй/ | Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургуулийн орчинд | Гэрийн нөхцөлд | Боловсруулсан багш |
| **Ганцаарчилсан сургалт явуулах хугацаа** | **Хэл засал** | Авиан сонсгол хөгжүүлэх<br>А, О, У авиаг дагаж хэлэх | Бөмбөр дээр багшийн цохилтыг дуурайн цохино.<br>А, О, У эгшигийг багшийг дагаж хэлнэ. | Бөмбөр цохиурт тоглоом бэлтгэж хэрэглэнэ.<br>А, О, У эгшигийг дагуулан хэлүүлнэ. | | | [redacted] |

| дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | | | Хичээлийн агуулга | Багшийн дэмжлэг, арга зүй / дэлгэрэнгүй/ | Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургуулийн орчинд | Гэрийн нөхцөлд | Боловсруулсан багш |
| Судлагдахуунаар | Монгол хэл | - А авиаг таниулах | А авиаг дагаж хэлэх<br>А авиаг улаан өнгөөр хэв шоблом ашиглан будуулах<br><br>А авиа үсгийг хэвэнд тохируулан хийнэ.<br><br>А авиа үсгийг баримлын шавар дээр шүрээр бүтээх<br> | Багш А авиаг үзүүлж дагуулан хэлүүлнэ.<br>А авиа үсгийг будахад нь дэмжлэг үзүүлнэ.<br>А авиа үсгийг хэвэнд тохируулан хийхэд үсгийг гарт нь бариулж дэмжлэг үзүүлнэ<br>А авиа үсгийг шүрээр бүтээхэд, нэг нэгээр нь шүрийг өгч нүхэнд хийлгэж бүтээлгэнэ. Даалгаврыг гүйцэтгэх явцдаа хүүхдэд байнга дэмжлэг үзүүлж энэ бол А авиа үсэг мөн А гэж дуудаг болохыг дагуулан дуурайлган хэлүүлнэ. | | | [redacted] |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Математик | Дүрсийн ижилийг олох | Алим, чихэр, луувангийн зургийг хараад доор нь ижлийг олж хэвэнд зөв байрлуулж тавина.  Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсийг хараад дүрснүүдийн доор ижлээр нь хэвэнд зөв байрлуулж тавина.  Дугуй дүрсийг баримлын шавар дээр шүрээр бүтээх  | Алим, чихэр, луувангийн зургийг нэг нэгээр нь сурагчид өгч ижлээр нь зөв байрлуулахад нь тусалж дэмжинэ. Дугуй, дөрөлжин, гурвалжин дүрсийг нэг нэгээр сурагчид өгч ижлээр нь зөв байрлуулахад нь тусалж дэмжинэ. Дугуй дүрсийг бүтээхэд шүрийг нэг нэгээр нь сурагчид өгч нүхэнд хийлгэж дүрсийг бүтээхэд тусална. | | | [redacted] |
| Нийгэм ахуйн баримжаа | Сууж сурах | -Багшийн зааврын дагуу ширээний ард зөв суух | -Багш алим, бөмбөгний зураг өгч өнгөөр ялган будах даалгавар өгснөөр хүүхэд бөмбөгийг будаж тодорхой хугацаанд сууна. Багш үүнийг урамшуулан магтана. | | | [redacted] |

# ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

2018оны 03 сарын 06 өдөр 2 цаг / [redacted] анги / 2-р улирал эр 6, эм 2
Хичээл заагч багш /Нэр/ [redacted] Туслах багш /Нэр/ [redacted]
Ерөнхий агуулга /Бүлэг сэдвийн нэр:
Хичээлийн нэр: Математик
Ээлжит хичээлийн сэдэв: “Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг ялгах, ижил дүрсийг олох”
Нэгж хичээлийн төлөвлөгөө /Нийт 8 цаг/ 4 - р цаг /Ээлжит хичээл/
Хичээлийн агуулга

(1) Ээлжит хичээлийн зорилго:

| ХБ-ийн хэлбэр | Ээлжит хичээлийн зорилго |
|---|---|
| Хөнгөн хэлбэрийн 2 хүүхэд | Дүрсийг нэрлэж тоо бодох |
| Хүндэвтэр хэлбэрийн 3 хүүхэд | Дүрсүүдийг ялган таних, будах, наах, бүтээх, жиших |
| Хүнд хэлбэрийн 1 хүүхэд | Дүрсийг өнгө, ижлээр нь олох |

(2) Ээлжит хичээлийн хөтөлбөр /Явц/

| Цаг төлөвлөлт | Сурагчийн үйл ажиллагаа /Ерөнхий явц/ | Хөнгөн хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга /Сурагчийн үйл ажиллагаа/ | Хүндэвтэр хүүхдийн багийн сургалтын агуулга/ Сурагчийн үйл ажиллагаа/ | Хүнд хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга /Сурагчийн үйл ажиллагаа/ | Багшийн үйл ажиллагаа/ хичээлийн явцад анхаарах зүйл | Бэлдэх зүйл /Сургалтын хэрэглэгдэхүүн, тараах өгөх материал/ |
|---|---|---|---|---|---|---|
| Сэдэлжүүлэлт<br>5 минут | Дүрс олуулах, өнгө нэрлүүлэх | 4 буланд дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрс нуусан байна. Эхний дугуй дүрсийг [redacted] нар олж ямар дүрс олсныйг багш болон бусад сурагчид хамтран ярилцана. Дараагийн гурвалжин дүрсийг [redacted] нар олж ямар дүрс олсныйг багш болон бусад сурагчид хамтран ярилцана.<br>[redacted] нар Дөрвөлжин дүрсийг олж ямар дүрс олсныг багш болон бусад сурагчид хамтран ярилцана. Жижиг дөрвөлжин дүрсийг [redacted] нар олж, хамтран ярилцана | | | Багш нь ангийнхаа 4 буланд 4 дүрс нуусан байгаа, та нар хос хосоороо нуусан дүрсийг олж багшдаа авчирч өгөөрэй.<br>Ямар ямар дүрс олсон, ямар өнгөтэй, манай ангид эдгээр дүрснүүдтэй адил ямар эд зүйл байна вэ? сурагчдаас асууж ярилцана. | Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрс  |
| Эхлэл<br>2 минут | Дугуй, дөрвөл жин, гурвалжин дүрсийг нэрлүүлж өнгийг хэлүүлнэ. | Зурагт үзүүлэнгээс байшингийн зургийг харж ямар ямар дүрснээс бүтсэн, юу юунаас байшин бүтдэг талаар багштай хамтран ярилцана. | | | Олсон 3 дүрсээр юу бүтээж болох вэ? байшин ямар ямар дүрснээс бүтсэнийг сурагчдаас асууж хамтран ярилцана.<br>Ямар ямар дүрс байгаа , том байна уу жижиг байна уу, ямар өнгөтэй байна гэх зэргээр ярилцана. | Зурагт үзүүлэн  |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Өрнөл<br><br>23минут | Дүрснүүдийн ард бичсэн даалгаварыг гүйцэтгэж байшин бүтээнэ. | Самбарт байгаа дүрснүүдээс дөрвөлжин дүрсийг авч хана бүтээх даалгавар гүйцэтгэнэ.<br>Дөрвөлжин дүрсэн дээрх илэрхийлэл бодно.<br>(11 - 5) + 7 =<br>5 + (14 - 9) =<br>Сурагчид эхний илэрхийллийг самбарт гарч гүйцэтгэнэ.<br>Байшингийнхаа ханыг бүтээчихлээ одоо байшинд юу хэрэгтэй байна вэ? Дээвэр, дээвэр буюу гурвалжин дүрсэн дээрх тоог бодно.<br><br>Дугуй дүрснийхээ ард байгаа өгүүлбэртэй бодлогыг бодно. Оюун 5 дугуй дүрс хайчилжээ. Харин Бат 7 гурвалжин дүрс хайчилжээ. Оюун, Бат 2 нийлээд хэдэн дүрс хайчилсан бэ? | Дөрвөлжин дүрсний ард байгаа дүрсийг өнгө ялгаж будна.<br><br>Гурвалжин дүрсний ард байгаа 2 гурвалжин дүрсийг наадаг цаасаар дүүргэж наана. (5 хошуу)<br><br>Том дугуй дүрсний ард байгаа 3 дугуй дүрсийг дэвтэрт давхарлан бичээд будна.<br><br>=3<br>самбарт гарч багштай хамтран дугуй дүрсийг тоолж хариуг олж наана. | Дөрвөлжин дүрсийг баримлын шавар дээр модон тоглоомоор шигтгэж бүтээнэ.<br><br>3 гурвалжин дүрсийг ижлээр нь өнгөөр нь харгалзуулан зөв байрлуулж тавина. (самбарт)<br><br>Дугуй дүрсийг утсанд хэлхэнэ. | За тэгвэл байшин бүтээцгээе.<br>Эхлээд байшингийнхаа ханыг бүтээнэ. Ханыг бүтээхийн тулд дөрвөлжин дүрсний ард бичсэн даалгаврыг гүйцэтгэнэ.<br>Сурагчдын бодсон илэрхийллийн хариуг дэлгэцэнд харуулж зөв бурууг шалгана.<br>Дараа нь байшингийнхаа дээврийг бүтээнэ. Дээврийг бүтээхийн тулд гурвалжин дүрсний ард байгаа даалгаврыг гүйцэтгэж хариуг шалгана.<br>Дараа нь дугуй дүрсээр юу хийж болох талаар сурагчдаас асууна.<br>Дээврийн цонх бүтээнэ.<br>Цонхийг бүтээхийн тулд дугуй дүрсний ард байгаа даалгаврыг хийж гүйцэтгэж хариуг шалгана.<br>Дөрвөлжин дүрсийг баримлын шавар дээр шигтгэхэд багш дөрвөлжин модон тоглоомыг нэг нэгээр нь өгч туслана.<br>3 гурвалжин дүрсийг самбарт зөв харгалзуулж байрлуулахад нь туслана.<br>Багш дугуй модон тоглоомыг нэг нэгээр нь өгч утсанд хэлхүүлнэ. |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Алжаал тайлах дасгал: Гурван тоорой хөдөлгөөнт дуу дуулна. | | | | | |
| Бататгал дүгнэлт<br><br>10 минут | Сурагчид хосоор суух. | Үлдсэн жижиг дөрвөлжин дүрсээр юу хийж болох талаар сурагчдаас асууж ярилцан байшингийнхаа цонхыг наана.<br>Багшийн асуусан асуултанд хариулж хаалгыг шидэт уутнаас гараараа мэдрэн олж байшингаа гүйцээж барьж дуусгана.<br>Сурагчид самбарт бүтээсэн байшингаа харж өөрсдөө бие даан байшин бүтээж самбарт нааж тоолно.<br><br>Гэрийн даалгавар байшин будах. | Дүрсийг хүрээн дотор байрлуулж байшинг бүтээнэ.<br> | Бидний бүтээсэн байшинд юу дутуу байгааг сурагчдаас асууна.<br>За одоо шидэт уут тоглоом тоглоно. Уутан дотор дугуй, гурвалжин, тэгш өнцөгт дүрснүүд хийсэн байна.<br>Шидэт уутнаасаа дугуй, тэгш өнцөгт, гурвалжин дүрсийг олуулж нэрлүүлнэ. Нэрлүүлсэн дүрснээсээ хаалгыг олж байшин дээрээ нааж гүйцээнэ.<br><br>Сурагчдын хийсэн байшинг самбарт нааж хамтран тоолно.<br>Өнөөдөр бид гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг таньж, дүрснүүдээрээ бүтээл хийлээ. |  |

Ээлжит хичээлийн үнэлгээ болон дараагийн хичээлд бэлдэж бичсэн багшийн тэмдэглэл

| | |
|---|---|
| <u>Мэдлэгийн ойлголт:</u><br>Тухайн сэдвээр хүүхэд болгон өөр өөрийнхөө чадварын хэмжээнд мэдлэг олж авч чадсан.<br>Сурагчид дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг таньж ялгадаг, зааж нэрлэдэг, хариулт өгдөг, бүтээл хийх зэрэг чадвар эзэмшсэн. | <u>Сонирхол-хүсэл эрмэлзэл, байр байдал:</u><br>Сурагчдад өгсөн дасгал даалгавар тэдний түвшинд тохирсон биелэгдэхүйц сонирхолтой байсан учраас сурагчдын идэвх оролцоо сайн байсан.<br>Сурагчид салангид 3 дүрсээр байшин бүтээх гэсэн заавры г ойлгоод байшин бүтээх хүсэл эрмэлзэл дүүрэн хичээлд идэвх чармайлттай оролцож байсан. |
| <u>Ур чадвар:</u><br>Хүүхэд бүртэй тулж ажиллаж, тэдний түвшинд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг ашигласан.<br>Сонгосон хүүхдийнхээ мэдлэгийн түвшинд тохирсон дасгал даалгавар, хэрэглэгдэхүүнийг зөв оновчтой сонгож хэрэглэсэн. | <u>Бодол-шийдвэр-илэрхийлэх:</u><br>Шидэт уутай даалгаврыг хичээлд хэрэглэсэн нь хүүхдүүдийн төсөөлөн бодох, мэдрэхүйг хөгжүүлэх сайн талтай байсан.<br>Даалгаврыг олон шатанд хувааж жижигрүүлсэн бол илүү сонирхолтой, үр өгөөжтэй байх байсан.<br>Сурагчдаар бүтээлгэсэн байшинг цавуугаар нааж цаг алдах биш зангуугаар шууд наалгасан бол хичээл илүү оновчтой байх байсан. |

## 1-2 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 25 ДУГААР ТУСГАЙ СУРГУУЛЬ (6 ДУГААР АНГИ)

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө – Бодит байдлын судалгаа**

| Анги | 6 анги [redacted] | Анги удирдсан багш [redacted] | | | Боловсруулсан огноо |
|---|---|---|---|---|---|
| Овог нэр | [redacted] | Хүйс | эм | Төрсөн огноо /нас/ | [redacted] |
| Эцэг эхийн нэр | [redacted] | Гэр бүлийн байдал | Ам бүл 3<br>Эмээ ахтайгаа | Нэмэлт мэдээлэл | Бүтэн өнчин. тархины зургаар 98%-ийн гэмтэлтэй гэж оношлогдсон. |
| Гэрийн хаяг | [redacted] | Холбоо барих утас | [redacted] | E-mail | |
| Эрүүл мэндийн байгууллагын оноштой эсэх | Оюун ухааны бэрхшээл | Онош тавьсан ЭМ-ийн байгууллагын нэр | Эх нялхасын мэдрэлийн эмчийн хяналтанд байдаг. | Сургуульд элсэн орсон нас | 2012оны 09 сар<br>8 нас |
| Оношилгоо үнэлгээ хийгдсэн эсэх | Сургуулийн комиссын үнэлгээ (нийслэлд) хийгдсэн эсэх<br>Тийм (хугацаа 2012 оны 08сарын 29)<br>Салбар комиссын оношилгоо, хөгжлийн үнэлгээ хийгдсэн эсэх<br>Тийм (хугацаа ) | | ✓ Оюун ухааны хөгжлийн бэрхшээл<br>✓ Хэл ярианы бэрхшээл | | ✓ Суралцах бэрхшээл<br>✓ Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэг |
| Хавсарсан бэрхшээлтэй эсэх | Таталт өгдөг | Гадаад, дотоодын байгууллагаар оношилгоо, үнэлгээ хийлгэж байсан эсэх | Гадаадад болон дотоодод оношилгоо, үнэлгээ хийлгэсэн үр дүн<br>( )<br>Бусад<br>( ) | Эрүүл мэндийн байгууллагатай холбоотой байгаа эсэх | Тийм /дэлгэрэнгүй бичих/<br>Үгүй |

| | |
|---|---|
| Хүүхдийн хувийн онцлог, бодит байдал /дуртай зүйл- давуу тал дургүй зүйл –бүдрэлт саад г.м / | 1.Төрсний дараа /0-12 сар хүртэл //Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглаж болно/<br>Огт ярихгүй, хөлд удаан орсон. Өвчлөмтгий дархлаа султай байсан. |
| | 2. Сургуульд орохоос өмнөх байдал /2-5 нас/ 3 нас хүртлээ хөлд удаан орсон. Хэлд ороогүй.<br>Цэцэрлэгт явж байсан эсэх /тийм / үгүй/ /Цэцэрлэгийн нэр: / 22-р цэцэрлэг /<br>Яваагүй бол шалтгааныг бичнэ үү / |
| | 3. Сургуульд орсон цагаас эхлэн өнөөг хүртэлх хүүхдийн байдал /тэргэнцэртэй эсэх, ганцаараа сургуульдаа ирж очдог эсэх гэх мэтийг оруулан бичих/<br>• Өөртөө үйлчлэх энгийн чадвар<br>Хоолоо өөрөө иддэг боловч зажлахгүй залгих гээд байдаг. Гутал хувцсаа өөрөө өмсдөг ч үдээсээ зангидаж сураагүй. Товчтой хувцас өмсөхдөө зөрүүлж товчлоно. Гутлаа буруу харуулж өмсөнө. Гэрийнхэн нь хичээлд нь хүргэж ирж авдаг. Ганцаараа явах чадваргүй.<br>• Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол цифр танихгүй, тоолж чадахгүй. Бие даан тоолж чадахгүй. Багшийн хэлсний дараа дагаж тоолно. Үг хэллэг хэлж ярьдаг ч үгийн утгаа мэдэхгүй. Үгийг оновчтой хэрэглэж чадахгүй.<br>• Улаан өнгө ялгана.<br>• Нийгэмшихүй<br>Хичээлдээ бие дааж явж чадахгүй, өөрийгөө илэрхийлэх чадваргүй. Зарим үед огцом уурлаж чангаар орилдог. Дохио зангаа гарын хөдөлгөөнөө ашиглан харилцаанд маш сул ордог. /Баяртай, бие засах зэргээ дохио болон зааж илэрхийлдэг.<br>• Хөдөлгөөн<br>Хөдөлгөөний эвсэл муу, орон зайн баримжаа муу. Шатаар бууж өгсөж чаддаг ч хөлөө ээлжлэн тавьж бууж өгсдөггүй. |
| Хүүхдийн өөрийн хүсэл, зорилго | Хөгжим сонсох, хөгжмийн аянд бүжиглэх дуртай |
| Эцэг эхийн хүсэл, зорилго | Манай хүүхдийн тархины үйл ажиллагаа нь 98%-ийн гэмтэлтэй гэсэн эмнэлгийн онош гарсан. Ийм учраас өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд оролцдог болгох зорилготой байна. Жишээлбэл: юм угааж сургах, гутлаа зөв харуулж өмсөж сурах, хоолыг зажилж идэж сургах, өөрийн хэрэгцээгээ илэрхийлж сургамаар байна |
| Багшийн хүсэл, зорилго | Өдөр тутмын амьдралын энгийн үйлдлийг бусдыг даган дуурайж хийж сурах. Хооллосон аяга тавгаа хурааж сурах, ангийн хүүхдүүдээ дагаж анги, кабинет, ариун цэврийн өрөөрүү явж чадна. Харин бие дааж өөрөө кабинет болон ОО- руу явж чадахгүй. Иймд ангиа өөрөө олоод ирдэг болгох зорилготой. |

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө/ 1 ул · 2 ул · 3 ул · 4ул /**

<table>
<tr><td>Анги</td><td colspan="2">[redacted] анги [redacted] бүлэг</td><td colspan="2">АУБ-ийн нэр<br>[redacted]</td><td>Боловсруулсан огноо</td><td>2017 он 09 сар 28 өдөр</td></tr>
<tr><td>Овог нэр</td><td colspan="2">[redacted]</td><td>Хүйс</td><td>2.эм</td><td>Төрсөн он сар өдөр</td><td>[redacted]</td></tr>
<tr><td rowspan="4">Урт хугацааны зорилт<br>*Зөвхөн шаардлагатай гэж үзсэн айн зорилтыг дэвшүүлнэ</td><td>Өөртөө үйлчлэх энгийн чадвар</td><td colspan="3">Гутлаа зөв харуулж өмсөж сурах. Үдээсээ зангидаж сурах, товчоо зөрүүлэлгүй товчилж сурах.</td><td rowspan="4">Дэмжлэгийн орчин буюу хаана, хэзээ</td><td rowspan="4">Биеийн тамир, нийгэм ахуйн баримжаа, гэрийн нөхцөлд<br><br>Монгол хэл<br><br>Биеийн тамир, гэрийн нөхцөлд<br><br>Эмчилгээний биеийн тамир, Биеийн тамирын хичээл дээр</td></tr>
<tr><td>Хэл яриа,танин мэдэхүй, тоо тооолол</td><td colspan="3">Зураг ашиглан үгийн утгыг таниулах./ гэр ахуйн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүн/<br>Үгийн баялгийг нэмэгдүүлэх/өдөр тутмын амьдралд хэрэглэгдэхүйц идэвхтэй үгийн нөөц/<br>Үгийн эсрэг утгыг таниулах/хэлбэр хэмжээ том-жижиг, урт-богино, өндөр нам/<br>Харандаан дэвсгэр дээрээс 1үетэй үгийг давхарлан бичих чадварыг нэмэгдүүлэх./ гарыг нь барьж/</td></tr>
<tr><td>Нийгэмшихүй</td><td colspan="3">Биеийн тамирын хувцсаа өмсөхдөө гутлаа зөв харуулж өмсөх, зөв товчлох, Мэдээлэл зүй, дуу хөгжим, биеийн тамирын заал руу болон ариун цэврийн өрөөрүү бие даан явж сурах.</td></tr>
<tr><td>Хөдөлгөөн</td><td colspan="3">Шатаар буухдаа 2 хөлөө ээлжлэн тавьж бууж сурах. Гар, хуруунуудын үйл ажиллагааг сайжруулах, гутлын үдээс зангидаж сурах</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжлэгийн орчин буюу хаана хэзээ</td><td rowspan="2">Энэ улирлын зорилт</td><td rowspan="2">Хүүхдийн үйл ажиллагаа</td><td colspan="2" rowspan="2">Багшийн дэмжлэг, арга зүй / дэлгэрэнгүй/</td><td colspan="2">Улирал бүрийн үнэлгээ</td></tr>
<tr><td>Хүүхдийн үнэлгээ</td><td>Зорилт болон арга зүйн үнэлгээ<br>Боловсруул сан багш</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол хэл | Гал тогооны хэрэгсэлүүдийг зөв нэрлэж хэлж сурах. Том-жижгийг ялгаж зааж чаддаг болох. “М”-гийгүүлэгчийг багшийн тусламжтай харандаан дэвсгэр дээрээс бичиж сурах. | Гал тогооны хэрэгслүүдийн зургийг харж нэрлэх, зэрэгцүүлэх, давхарлах зэргээр том жижгээр нь ялгуулах, дэвтэрт нь нааж өгсөн гал тогооны хэрэгслийн зургийг будах. Давхарлан хийх тоглоомыг томоос жижиг рүү өрөх. Багшийн тусламжтай “М”-гийгүүлэгчийг харандаан дэвсгэр дээрээс давхарлан бичих. | Гэр ахуйн хэрэгслийн зурган картыг нэг,нэгээр нь харуулан ярилцаж нэрлүүлнэ. Буруу хэлсэн тухай бүрт нь алдааг засч давтан хэлүүлнэ. Гал тогооны хэрэгслүүдийн зургийг дэвтэрт нь нааж будуулах, Сурагчийн гарыг барьж харандаан дэвсгэр дээрээс бичүүлнэ. Тоглоом ашиглан жижиг томыг ялгуулах / томоос жижиг рүү дахарлах тоглоом,том жижиг шоог орхиулах / | | | \Б.Шүрэнцэцэ |
| Нийгэм ахуйн баримжаа | Гутлаа зөв харуулж өмсөж сурах | Гуталд наасан зургийг дотогш нь харуулж гутлаа өмсөх, үдээсийг бодит модон үзүүлэн дээр сүвлэх, гутлын зургийг эвлүүлэх. Зурагт үзүүлэн дээр гутлын өрөөснийг зөв олж наах.   | Багш гутлын дотор талд нь зураг наах, зураг дээр гутлын өрөөснийг олуулах. Багш хүүхдийг урамшуулахдаа даалгавраа гүйцэтгэсэн тухай бүрт нь сайн байна, мундаг байна гэж хэлж, эрхий хуруугаа гозойлгох, алга таших гэх мэтээр урамшуулна. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Эмчилгээний биеийн тамир | Байранд нь өвдгийг нь өргүүлж алхуулж сургах.<br>Багшийн тусламжтай шатаар 2 хөлөө ээлжлэн тавьж алхаж сурах. | Багшийн тусламжтай баруун хөлөө өргөхдөө зүүн гараа дээш өргөх.<br>Зүүн хөлөө өргөхдөө баруун гараа өргөх дасгалыг хийх.<br>Цагираг дотор зогсож байрандаа хоёр хөлөө өргөж алхахдаа 2 гараа өргөлгүй сул тавих | Хөлөө өргөхөд нь эсрэг талын гарыг нь өргөх, байрандаа алхуулахын тулд цагираг дотор зогсоож хоёр гарыг нь хөдөлгүүлэхгүй байх. | | | [redacted] |
| Биеийн тамир | 10-15см-тэй саадыг давж алхаж сургах. | Бие дааж өвдөгөө дээш өргөх. 2 хөлөө ээлжлэн өвдгөөр нь дээш өргөх. Саадыг мэдрэх. | Багш гараас нь хөтөлж саадыг давж алхах.<br>Багш өвдгөөр нь дээш өргөж саадыг давахад нь туслах. | | | [redacted] |

# Ээлжит хичээлийн хөтөлбөр

2018оны 03 сарын 06 өдөр 11 цаг 30 минут / 6 анги / 3-р улирал эр 3, эм 6

Хичээл заагч багш /Нэр/ [redacted]

Хичээлийн нэр: Монгол хэл

1.Ерөнхий агуулга: Бүлэг сэдвийн нэр: Үгийн утга

2. Бүлэг сэдвийн төлөвлөлт /Нийт 10 цаг/ 2-р цаг /Ээлжит хичээл/

Ээлжит хичээлийн сэдэв: “Эсрэг утгатай үг ба тэмдэглэгээ”

3. Хичээлийн агуулга:

(1) Ээлжит хичээлийн зорилго: Эсрэг утгатай үгсийг олох, ярилцах, тэмдэглэгээг мэддэг болох.

| ХБ-ийн хэлбэр | Ээлжит хичээлийн зорилго |
|---|---|
| Хөнгөн хэлбэрийн 3 хүүхэд | Эсрэг утгатай үг болон тэмдэглэгээг мэддэг болох , ярилцах, эсрэг утгатай үгээр өгүүлбэр зохиох /явжээ-иржээ, том-жижиг, эрэгтэй-эмэгтэй, өгсөх-уруудах/ |
| Хүндэвтэр хэлбэрийн 4 хүүхэд | Зураг ашиглан үгийн эсрэг утгыг олох, ярилцах / явжээ-иржээ, том-жижиг, эрэгтэй-эмэгтэй, өгсөх-уруудах/, эсрэг утгатай тэмдэглэгээг мэддэг болох |
| Хүнд хэлбэрийн 2 хүүхэд | Зураг болон бодит зүйл ашиглан том жижгийг ялгуулах, будах |

(2) Ээлжит хичээлийн хөтөлбөр /Явц/

| Цаг төлөвлөлт | Сурагчийн үйл ажиллагаа /Ерөнхий явц/ | Хөнгөн хэлбэрийн хүүхдийн сургалтын агуулга | Хүндэвтэр хүүхдийн сургалтын агуулга | Хүнд хэлбэрийн хүүхдийн сургалтын агуулга | Багшийн үйл ажиллагаа/ хичээлийн явцад анхаарах зүйл | Бэлдэх зүйл /Сургалтын хэрэглэгдэхүүн тарааж өгөх материал/ |
|---|---|---|---|---|---|---|
| Сэдэлжүүлэлт<br>2 минут | “Жигмэд Тогмид хоёр” дууг сонсох | Сурагчид “Жигмэд Тогмид хоёр” дууг дэлгэцээр үзүүлж сонсоно. | | Сонгосон хүүхэд дууг сонсож сурагчдыг даган дуулна. | Сурагчдыг хос хосоор суулгана.Хүнд хэлбэрийн хүүхдийг хөнгөн хүүхэдтэй суулгана. Жигмэд Тогмид дууг сонсгоно. | “Жигмэд Тогмид хоёр” дууны бичлэг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Эхлэл<br>6 минут | Дуун дээр ярилцах | Дууны үгийг дэлгэцээс уншиж, явжээ-иржээ гэсэн эсрэг утгатай үгсийг ярилцана.<br>Хэн нь Жигмэд, хэн нь Тогмид болох хэнийх нь сав жижиг, хэнийх нь сав том байсан тухай багшийн асуултанд хариулж том-жижиг, явжээ-иржээ гэсэн эсрэг үгсийг ялгаж нэрлэх<br> | Сонгосон сурагч самбарт Тогмидын зураг дээр том хувинг Жигмэдийн зураг дээр жижиг хувинг наах. \багш тусална\<br> | Дууны үгнээс явжээ-иржээ гэсэн эсрэг утгатай үгийг уншуулж, хүүхдүүдийн нэрийг хэлүүлэх, Жигмэд Тогмид хоёрын зургийг самбарт байрлуулж Жигмэд нь ямар савтай,<br>Тогмид нь ямар савтай байсан бэ? асууж сонгосон сурагчийг самбарт гаргаж зураг дээр хувинг наалгана.<br>явжээ-иржээ, том-жижиг, гэсэн эсрэг үгийг хэлүүлэх | Жигмэд Тогмидын зураг, том жижиг хувингийн зураг, Соронз<br> |
| Өрнөл<br>23<br>минут | Эрэгтэй-эмэгтэй, өгсөх-уруудах гэсэн эсрэг утгатай үгийн утгыг ойлгох, тэмдэглэгээг мэддэг болох. | <br>тэмдэглээг харж хаана байдгийг хэлэх, өгсөх гэсэн тэмдэглэгээ гэж хариулна.<br><br>Багшийн тарааж өгсөн уулны зураг дээр өгсөх-уруудах гэсэн тэмдэглэгээний сумыг хосоороо зөв нааж самбарт байрлуулна.<br>Дэлгэцээс эсрэг утгатай үгийг уншина. | Сонгосон сурагч ширээний хосын хамт багш ийн тарааж өгсөн уулны зураг дээр сумыг байрлуулж самбарт тогтоох.<br><br>Сонгосон сурагч эмэгтэй хүүхдийн зургийг зөв тэмдэглэгээтэй хаалганы зурагны доор байрлуулах \багшийн тусламж авч болно\ | Багш тэмдэглэгээг дэлгэц дээр харуулж энэ тэмдэглэгээг харж байсан уу? Хаана, хаана байдаг вэ? юу гэсэн утгатай тэмдэглэгээ вэ? гэж асууна.<br>Уул өөд өгсөж, уулын уруу уруудаж яваа хүүхдийн зургийг дэлгэц дээр харуулж өгсөх, уруудах сумыг зөв байрлуулаарай гэдэд ширээ бүрт нэг уулны зураг 2 сум тараан өгнө. Хийж дуусcаны дараа самбарт байрлуулна.<br>**Сурагчийн үнэлгээний хуудас дээр смайл наана.** | Дэлгэц, проектор<br><br>Зурган карт<br>Өнгийн харандаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | <br>тэмдэглэгээг харж хаана, хаана байдгийг хэлнэ. Эмэгтэй, эрэгтэйг заасан тэмдэглэгээ гэж хэлж эмэгтэй хүүхдийн зурагтай тэмдэглэгээтэй газарт эмэгтэй хүүхэд орно, эрэгтэй хүүхдийн зурагтай тэмдэглэгээтэй газарт эрэгтэй хүүхэд орно гэж хэлнэ.<br>Дэлгэцээс тэмдэглэгээтэй хаалганы зураг дээр эмэгтэй, эрэгтэй хүүхдийн аль нь орохыг хэлнэ.<br>Самбар байгаа эрэгтэй,эмэгтэй тэмдэглэгээтэй хаалганы доор өөрт өгсөн эмэгтэй, эрэгтэй хүүхдийн зургийг хүүхэд бүр самбарт зөв байрлуулна.<br>Дэвтэрт хичээлийн сэдвийг бичнэ. | | Тэмдэглэгээг харуулж хаана хаана байдаг вэ? юу гэсэн утгатай тэмдэглэгээ вэ? гэж асууна. Тус зургийг самбарт тогтоож сурагч болгонд тараан өгсөн эмэгтэй, эрэгтэй хүүхдийн зургийг самбарт зөв байрлуулах<br>Сонгосон хүүхдийн зургийг багш самбарт зөв байрлуулахад туслах<br>**Сурагчийн үнэлгээний хуудас дээр смайл наана.**<br>Самбарт хичээлийн сэдвийг бичнэ.<br>“Эсрэг утгатай үг ба тэмдэглэгээ” | |
| | **Алжаал тайлах дасгал** | Дэлгэцээс зургийг харж, салхины чимээг сонсоод багшийг салхи салхиллаа гэхээр хоёр гараа дээш өргөн сс.сс..гэсэн авиаг гаргаж найгах хөдөлгөөн хийнэ.<br>бороо дусаллаа-хурууны өндгөөр ширээн дээр зөөлөн товших, бороо шируусллээ<br>хурдан чангаар товших, бороо зогслоо - зөөлөн товших<br>нар гарлаа фү..фү гэсэн авиа гаргаж хөлсөө арчих хөдөлгөөн хийнэ | | Алжаал тайлах дасгалыг дэлгэцээр зураг харуулж чимээг сонсгон дагуулан хийлгэнэ. | Дэлгэц проектор<br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эсрэг утгатай үгийг олох | Зурган карт дээрх орхисон эсрэг утгатай үгийг нөхөж бичнэ.<br>Явжээ-.........<br>........- жижиг<br>Өгсөх-....<br>.........- эрэгтэй<br> | Зургийн ард эсрэг утгатай үг бүхий зургийг олж наана.<br>Явжээ-иржээ<br>Том-жижиг<br>Өгсөх-уруудах<br>Эмэгтэй-эрэгтэй<br> | Дэвтэрт наасан жижиг хувинг цэнхэр өнгөөр ялгаж будна.<br>Том гэсэн үг дээр том, жижиг гэсэн үг дээр жижиг гэсэн үгийг багшийн тусламжтай наах.<br> | Эсрэг утгатай үг бүхий зурган картыг тараан өгч үг нөхүүлэх, зургийг зөв олуулах, жижиг хувинг будаад үгийг зөв наах<br><br>**Сурагчийн үнэлгээний хуудас дээр смайл наана.** | Дэлгэц проектор<br>Нөхөж бичих, зөв олж наах, будах даалгаврыг бэлтгэх |
| Бататгал дүгнэлт<br><br>8 минут | Эсрэг утгатай үгийн тест ажиллах,<br><br>өгүүлбэр зохиох, хуулан бичих<br><br>Хичээлээ болон хүүхдээ дүгнэх | 1. Тестийг бэлтгэсэн цаасан дээр эсгий балаар зурж ажиллах<br><br>2. Дэлгэцээс эсрэг утгатай үгийг уншаад дэвтэрт 3 үгээр өгүүлбэр зохиож дэвтэрт бичнэ.<br> | 1. Тестийг бэлтгэсэн цаасан дээр эсгий балаар зурж ажиллах<br><br> | 1.Багшийн бэлтгэсэн зурагт үзүүлэн дээр сүүдэр бүхий том, жижиг хувинг олж наана.<br><br>2.Том, жижиг алимны зураг бүхий бөглөөг зөв олж багшийн тусламжтай бөглөх | Дэлгэц дээр тестийн зургийг харуулж ажиллах заавРыг өгнө.<br>Сурагчдыг тест ажиллаж дууссаны дараа дэлгэцээр зөв хийснийг харуулж шалгаж дүгнэнэ. **Сурагчийн үнэлгээний хуудас дээр смайл наана.**<br>1-р түвшний 3 сурагчийн зохиосон нэг, нэг өгүүлбэрийг уншуулна.<br>2-р түвшний сурагчдаар дэвтэрт хуулан бичүүлнэ. | Проектор, дэлгэц,тест,<br><br><br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Алдаагаа дэлгэцээс харж засах<br><br>2.багшийн дэвтэрт бичсэн эсрэг утгатай үгсийг хуулан бичнэ. | 3.Жижиг том аяганд бөмбөлгийг багшийн тусламжтай ялгаж хийх. | Сонгосон сурагч багштай хамтран том, жижиг аяга олох, бөглөөг зөв бөглөх, жижиг хувинд жижиг бөмбөлгийг, том хувинд том бөмбөлгийг олж хийлгэх, сурагчдаар үнэлгээний хуудсыг өргүүлж дүгнэх. | <br>Жижиг том хувин жижиг том бөмбөлөг |

Ээлжит хичээлийн үнэлгээ болон дараагийн хичээлд бэлдэж бичсэн багшийн тэмдэглэл

| | |
|---|---|
| Мэдлэгийн ойлголт<br>Явжээ-иржээ,том-жижиг гэсэн эсрэг утгатай үг, өгсөх-уруудах, эрэгтэй-эмэгтэй гэсэн эсрэг утгатай үг болон тэмдэглэгээг хөнгөн болон хүндэвтэр түвшний сурагчид мэддэг болсон.Сонгосон сурагч том жижгийг ялгаж сурсан нь хичээлийн бататгал хэсэгт жижиг том аяга, бөмбөлгийг ялгаж байгаагаас харагдсан. | Сонирхол-хүсэл эрмэлзлэл,байр байдал<br>Сэдэлжүүлэх хэсэгт дуу сонсгосон нь сурагчдад сонирхолтой байсан тул дагаж дуулж байсан.<br>Мөн үнэлгээний хуудас нь өөрсдийнх нь зурагтай байсан нь сурагчдад сонирхолтой байж хуудсан дээрээ смайл наалгахын тулд даалгаврыг идэвхтэй хийж байгаа нь харагдсан. |
| Ур чадвар<br>Үгийн эсрэг утгыг таниулахдаа амьдрал дээр өдөр тутамд хэрэглэгдэхүйц үг болон тэмдэглэгээг сонгон авч утгыг нь таниулахыг зорин зураг үзүүлэн болон цахим хичээл бэлтгэн хичээлээ явуулсан нь үр дүнтэй болж чадсан. | Бодол-шийдвэр-илэрхийлэх<br>Бататгал хичээлээ сурагчдыг дагуулан сургуулийн ариун цэврийн өрөө орох, эрэгтэй,эмэгтэй тэмдэглэгээг ярилцах. Мөн сургуулийн өгсөх-уруудах тэмдэглэгээтэй шатаар өгсөж уруудаж алхуулах гэх мэтээр бодитоор бататгана. |

# 1-3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 55 ДУГААР ТУСГАЙ СУРГУУЛЬ (3 ДУГААР АНГИ)

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө – Бодит байдлын судалгаа**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Анги | [redacted] анги [redacted] | Анги удирдсан багш [redacted] | | Боловсруулсан огноо | |
| Овог нэр | [redacted] | Хүйс | 2. Эр | Төрсөн огноо /нас/ | [redacted] |
| Эцэг эхийн нэр | [redacted] | Гэр бүлийн байдал | Аав,ээж,дүү | Нэмэлт мэдээлэл | |
| Гэрийн хаяг | [redacted] | Холбоо барих утас | [redacted] | E-mail | |
| Эрүүл мэндийн байгууллагын оноштой эсэх | Дауны хам шинж | Онош тавьсан ЭМ-ийн байгууллагын нэр | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | Сургуульд элсэн орсон нас | 8 |
| Оношилгоо үнэлгээ хийгдсэн эсэх | Сургуулийн комиссын үнэлгээ (нийслэлд) хийгдсэн эсэх<br><u>Тийм</u> (хугацаа 2013 оны 08сарын 25)<br><br>Салбар комиссын оношилгоо, хөгжлийн үнэлгээ хийгдсэн эсэх<br>Үгүй | | □Оюун ухааны хөгжлийн бэрхшээл<br>□Тулах эрхтний бэрхшээл<br>□Аутизмын хүрээний эмгэг<br>☑ Дауны синдром<br>□Хэл ярианы бэрхшээл | □Суралцах бэрхшээл<br>□Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэг<br>□Харааны бэрхшээл<br>□Сонсголын бэрхшээл<br>□Бусад ( ) | |
| Хавсарсан бэрхшээлтэй эсэх | Зүрхний гажиг, хэл ярианы бэрхшээл | Гадаад, дотоодын байгууллагаар оношилгоо, үнэлгээ хийлгэж байсан эсэх | Гадаадад болон дотоодод оношилгоо, үнэлгээ хийлгэсэн үр дүн ( )<br><br>Бусад<br>( ) | Эрүүл мэндийн байгууллагатай холбоотой байгаа эсэх | Өрхийн эмнэлэг<br>Дүүргийн нэгдсэн эмнэлэг |

| | |
|---|---|
| Хүүхдийн хувийн онцлог, бодит байдал /дуртай зүйл-давуу тал дургүй зүйл –бүдрэлт саад г.м / | 0-24 сартайд Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрээс харах; Эцэг эхээс асуух;<br>• Байнга ханиад хүрнэ<br>• Хоолой өвдөнө.Эмнэлэгт байнга хэвтдэг |
| | 2 наснаас сургуульд орох хүртэлх мэдээллийг оруулна;<br>• Гэрээр хүмүүжсэн<br>• Нэлээд дураараа тогтвортой сууж сураагүй |
| | Сургуульд орсноос хойшхи хөгжлийн түвшин байдал, туслах хэрэглэгдэхүүн хэрэглэдэг эсэх /таяг, тэргэнцэр гэх мэт/<br>• **Өөртөө үйлчлэх энгийн чадвар:**<br>Хувцсаа өөрөө тайлж өмсөнө.Гутлын үдээсийг үдэж чадахгүй.Сургуулийн автобусанд өөрөө бие даан суух боловч ганцаараа сургуульдаа бие даан ганцаараа ирж чаддаггүй.Үдийн цайгаа бие даан ууж чадна. Аяга тавгаа бусдын зааврын дагуу хураана.Гадуур хувцсаа өөрөө өлгүүрт өгч өлгүүлдэг. Гараа дараалын дагуу гүйцэд угааж чаддаггүй.<br>• **Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол**<br>Хүний хэлснийг маш сайн ойлгодог. Анх сургуульд орохдоо авиа үсгийг хэлж чаддаггүй байсан.Одоо 1 үетэй үгийг гүйцэд хэлнэ. Өгүүлбэрийг холбоо үгээр хэлнэ.Өнгө ба дүрсийг ижлээр нь холбон ялгаж танина.Давхарлан бичнэ. 3 үйлдэлтэй пазл эвлүүлнэ. Ижлийг холбоно.Үсэг, тоон утгыг ойлгохгүй. Хөл бөмбөгт маш их дуртай.<br>• **Нийгэмшихүй**<br>Бусдыг даган багштайгаа мэндэлнэ. Төрийн дуулал дуулна.Сургуульдаа явах дуртай. Учир нь сургуулийн автобусанд суух маш их дуртай.Найз нөхөдтэй эвсэг.Өөрийн хийхийг хүсэхгүй зүйлийг нь хийлгэх гэж оролдоход зөрүүдлэнэ. Завсарлах болон тарах үеэр энэ байдал ажиглагддаг.<br>• **Хөдөлгөөн**<br>Гүйнэ. Тэнцвэр муу. Биеийн тамирын хичээлийн үеэр бөмбөг тоглох дуртай.Дуу дуулж бүжиглэх маш хайртай. |
| Хүүхдийн өөрийн хүсэл, зорилго | Дуу дуулах, бүжиглэх,бөмбөгөөр тоглох |
| Эцэг эхийн хүсэл, зорилго | Үсэг тоог бие даан бичиж чаддаг болох,нэрээ бичдэг болох |
| Багшийн хүсэл, зорилго | 1-5 хүртэлх тооны утгыг ойлгох,том жижиг үсгийг ялган заах,эгшиг үсэг зөв дууддаг болох |

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө ( <u>1 ул</u> · 2 ул · 3 ул · 4ул )**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Анги | [redacted] анги [redacted] | АУБ | [redacted] | Боловсруулсан огноо | 2018 он 02 сар 01өдөр |
| Овог нэр | [redacted] | Хүйс | 1.эр | Төрсөн огноо (Нас) | 2005 он 01 сар 01 өдөр (13) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Урт хугацааны зорилт | Өөртөө үйлчлэх энгийн чадвар | Хувцсаа дарааллын дагуу тайлж сурах<br>Хувцсаа эмх цэгцтэй байрлуулах<br>Гутлын үдээс үдэж сурах<br>Гарыг дарааллын дагуу зөв угаах | Дэмжлэгийн орчин буюу хэзээ, хаана, ямар үед | Сургуулийн орчинд өдөр бүр<br>Гэрийн орчинд өдөр бүр |
| | Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | Эгшиг авиаг зөв дуудах<br>Амны хайрцгаар авиаг таньдаг болох<br>Монгол хэлний үгийн нөөцийг 20-30 үгээр нэмэгдүүлэх<br>1-5 хүртэлх тооны утгыг ойлгон харгалзуулах | | Хичээлийн жилийн турш,математик, нийгэм ахуйн баримжаа, монгол хэл,хэл заслын хичээлээр |
| | Нийгэмшихүй | Анги хамт олноор хийж буй үйлдлийг хамт хийж сурах<br>Өөрийгөө эрсдлээс хамгаалах Үүнд:<br>Гэрлэн дохионы өнгийг мэдэх<br>Шатнаас үсэрч харайхгүй байх<br>Коридорт хурдтай гүйхгүй байх<br>Өөрийгөө хянаж өөрийн хийж буй зүйлд зориудын анхааралтай хандаж сурах<br>Ангийн дэг журамд суралцах<br>Зөрүүд зангийн бурууг ойлгох<br>Бусдын зүйлийг дураар авч цүнхлэхгүй байх | | Сургуулийн орчин<br>Хичээл тус бүрээр |
| | Хөдөлгөөн | Биеийн тамирын хичээл,завсарлагааны цагаар дасгал хөдөлгөөн хийж сурах<br>Үйлдлийг гүйцэд хийж сурах<br>Гарын жижиг булчинг сайжруулах дасгал хийж сурах | | |

| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | Улирлын зорилт /Богино хугацааны зорилт/ | Хүүхдийн үйл ажиллагаа | Багшийн дэмжлэг, арга зүй /дэлгэрэнгүй/ | Улирал бүрийн үнэлгээ | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүүхдийн үнэлгээ | Зорилт болон арга зүйн үнэлгээ | Үнэлгээ өгсөн хүн |
| **Сургуулийн амьдрал дахь хичээлийн бус цагийн үйл ажиллагаагаар** | -Хичээлийн завсарлагаанаар алхаж явах<br>- Ангиас гарч гүйхгүй байх<br>- 00 ороод ангидаа эргэн орж ирэх | -Сургууль дээр ирээд коридорт явах үед,<br>-үдийн цайнд явах,<br>-биеийн тамир,хөгжмийн хичээлд орох гэж явах үед<br>-,00 явах үед алхаж явах | -Гэр бүлийнхэнд нь хэлж олон нийтийн газарт алхаж явахыг хэлж өгөх<br>-Тайван алхаж явахыг хэлж багш дагуулан алхаж явах | | | |
| Засан сайжруулах, дэмжлэг үзүүлэх сургалтын цаг /Хэл засал/ | -Эгшиг авиаг зөв дуудах<br>-Амны хайрцгаар авиаг таньдаг болох<br>-Монгол хэлний үгийн нөөцийг 20-30 үгээр нэмэгдүүлэх | Эгшиг авиаг ялган сонсох<br>Амны хайрцгийг анхааралтай харах<br>Үгийг зөв тод хэлж сурах | Эгшиг авиаг ялгуулах алга ташилтын аргыг хэрэглэх<br>Амны хайрцгийг ойлгуулах дасгалыг олон удаагий давталттай хийлгэх<br>Үгийг өдөр бүр гэрийн орчинд давтуулан хэлүүлэх | | | |
| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | Энэ улирлын зорилт (Богино хугацааны зорилт) (Зөвхөн шаардлагатайг бөглөнө | Хүүхдийн үйл ажиллагаа | Багшийн дэмжлэг, арга зүй /дэлгэрэнгүй/ | Улирал бүрийн үнэлгээ | | |
| | | | | Хүүхдийн үнэлгээ | Зорилт болон арга зүйн үнэлгээ | Үнэлгээ өгсөн хүн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Судлагдахуунаар | Монгол хэл | Давхарлан бичих<br>А үсгийг таних<br>А үсгийг жижиг фоноор өөрөө бичих | Давхарлан цэвэр бичих<br>Утгыг зөв ойлгон цээжлэх<br>Зөв бичих аргад сурах | Тоглоомын арга дагуулан дуурайлгах<br>Зурган картаар цээжлүүлэх<br>Зөв бичсэн үед урамшуулах | | | |
| | Математик | 1-2 хүртэлх тооны утгыг ойлгуулах<br>Хоёр ширхэг бодит тоолж сурах<br>Ижил тоог харгалзуулж сурах<br>Хуруугаар илэрхийлэх<br>Геометрийн дүрсийг таниулах | 1-2 тоог ялган тандаг болох<br>Бодит зүйлийг тоолж сурах чадвартай болох<br>Геометрийн дүрсийг ялган таних | Бодит зүйл дээр ажиллах.<br>Дүрс зурж ажиллуулах<br>Дагуулан тоолуулах<br>Өнгөт тарааж өгөх материал ашиглах | | | |
| | Нийгэм ахуйн баримжаа | Замын хөдөлгөөний дүрэм таниулах | Гэрлэн дохионы утгыг ойлгох<br>Гэрлийн гурван өнгийг ялган холбох | Гэрлэн дохиог таниулна.<br>Зурагт үзүүлэнг ашиглан ойлгох<br>Видео кино үзүүлэх | | | |
| | Хөгжим | Хөгжимтэй дуулж сургах<br>Дууны үгийг өөрийн үгээр хэлэх | Дууг хөдөлгөөнөөр хийж дуулж сурах | Тохирсон хөдөлгөөнийг зааж өгөх<br>Бусдыг дагуулан дуулуулах | | | |
| | Дүрслэх урлаг, технологи | Шулуун зураасын дагуу хайчлах<br>Цавууг ашиглаж сурах | Хайчийг зөв барьж хайчлах<br>Цавуу ашиглан нааж сурах | Багш хайчаар зөв тэгш хайчилж харуулах<br>Нягт нямбай хийж сурах | | | |
| | Биеийн тамир | 8 тоот дасгалыг хийж сурах<br>Зөв алхаж сурах | Дасгал хөдөлгөөнийг хийж сурах<br>Алхах техникийг эзэмших | 8 тоот дасгалыг дагуулан хийх<br>Алхахдаа гар хөлийг хэрхэн тавьж буйг дагуулан сургах | | | |

“**НИЙГЭМ АХУЙН БАРИМЖАА**” ээлжит хичээлийн хөтөлбөр

**2018** оны **05** сарын **18** өдөр **2-р цаг** /10:15~10:55 / **4-р улирал** **Эр**: 7 **Эм:** 7 **Нийт:**14

**Хичээл заагч багш**: [redacted] **Туслах багш**: [redacted]

1. **Бүлэг сэдвийн нэр**: “Үйлчилгээний соёл” **Нэгж хичээлийн нэр**: Замын хөдөлгөөнд оролцоцгооё

**Ээлжит хичээлийн сэдэв** :“Замын хөдөлгөөнд зөв оролцъё”

**Нэгж хичээлийн төлөвлөгөө**: 8 цаг **3-р цаг** /Ээлжит хичээл/

2. **Хичээлийн агуулга:**

**(1) Ээлжит хичээлийн зорилго**:-Замын хөдөлгөөнд бие дааж зөв оролцох, дадал хэвшил олгох.

| ХБ-ийн хэлбэр | Ээлжит хичээлийн зорилго |
|---|---|
| **Хөнгөн -** 7 хүүхэд | Гэрлэн дохиотой, дохиогүй замыг ялган таних,замын хөдөлгөөнд бие дааж зөв оролцож сурна. |
| **Хүндэвтэр -** 4 хүүхэд | Зам хөндлөн гарахдаа гэрлэн дохио болон гарцаар зөв гарч сурна. |
| **Хүнд -** 3 хүүхэд | Улаан гэрэл ассан үед зам хөндлөн гарч болохгүй, ногоон гэрэл ассан үед зам хөндлөн гарч болно гэдгийг ойлгоно. |

| | Сурагчийн үйл ажиллагаа /Ерөнхий явц/ | Хөнгөн хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга | Хүндэвтэр хүүхдийн багийн сургалтын агуулга | Хүнд хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга | Багшийн үйл ажиллагаа /хичээлийн явцад анхаарах зүйл/ | Бэлдэх зүйл /Сургалтын хэрэглэгдэхүүн, тарааж өгөх материал/ |
|---|---|---|---|---|---|---|
| **Сэдэлжүүлэлт-7 минут** | -Мэндлэх<br><br>-Гадаах цаг агаарын байдлыг тодорхойлох, сар өдөр гарагаа мэдээлэх<br>-Ямар хичээл орохыг мэдэж хичээллэх дэгтэй танилцана. | -Багштай мэндлэх<br><br>-Өнөөдрийн цаг агаарын байдлыг ажиглаж хэлнэ.<br><br>-Хичээлийн хуваарийн дагуу нэрлэнэ.<br>-Хичээлийн дэгийг уншиж танилцана.<br>-Улаан, шар, ногоон өнгийг ажиглан дараалаар нэрлэнэ. | -Багштай мэндлэх<br><br>-Нартай болон үүлтэй байгааг ялган нэлнэ.<br><br>-Нийгэм ахуйн баримжаа хичээл орно гэдгийг давтан хэлнэ.<br>-Дэгийг сонсож танилцана. | -Бусдыгаа даган дуурайж мэндлэх<br>-Багшийн тусламжтайгаар хэлнэ.<br><br>-Зурган карт харж давтан хэлнэ.<br><br>Өнгүүдийг давтан хэлнэ. | -Хүүхдүүдтэй мэндэлнэ.<br>-Өнөөдөр хэдэн сарын хэдэн бэ?<br>-Гадаа цаг агаар ямар байна бэ?<br>-Орох хичээлийн нэр болон дэгийг танилцуулж, самбарт тавина.<br>-Цаг баримтална.<br>-Харилцан ярилцана. | <br><br>Тоон, бичмэл болон зурган, карт<br><br>-Дэлгэц, бичлэг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | - Ажиглан тайлбарлах | -Юунд хэрэглэгддэгийг хэлнэ..  | -Улаан, шар, ногоон өнгүүдийг нэрлэнэ.<br>-Гэрлэн дохионы өнгө гэдгийг мэднэ.  | 3-н өнгийн гар картнаас багшийн хэлсэн өнгийг сонгон өргөж харуулна.  | -Хичээлд идэвхтэй оролцоно.<br>-Гэрлэн дохионы 3-н өнгийг дараалан харуулна. | 3-н өнгийн гар карт  |
| **Эхлэл-10 минут** | -Дохиотой болон дохиогүй замыг ялгана,<br><br>-Нэрлэнэ, байрлуулна. | -Дохиотой замын загвар бүтээнэ.<br>-Бэлэн зам дээр гарц болон орчин үүсгэнэ.  | -Дохиогүй замын загвар бүтээнэ.<br>-Бэлэн зам дээр гарц болон орчин үүсгэнэ.  | -гэрлэн дохионы загвар дээр 3-н өнгийг байрлуулна.<br>-Самбарт гэрлэн дохионы ногоон өнгийг гүйцээн байрлуулна.  | -Даалгаврыг тайлбарлана.<br>-Сурагчдыг самбарт ажиллуулна.<br>-Сурагчдын зөв буруу хийж байгаад хяналт тавина. | Бэлэн зам, гарц, гэрэл улаан, шар, ногоон өнгө, дохио, мод хүүхэд зэргийн зураг  |
| **Эхлэл -10 минут** | -Бичлэг үзэж,зураг дээр ярилцана.<br><br>-Багшийн тавьсан асуултанд хариулна.<br><br>-Зурган картуудаас зөвийг сонгож харуулна. | -Дохиотой болон дохиогүй замын хөдөлгөөнд зөв оролцож буй бичлэг үзэж ярилцана.<br><br>-Багшийн асуултын дагуу хариултыг зурган карт ашиглан өргөж харуулна.<br>- | - Дохиотой болон дохиогүй замын хөдөлгөөнд зөв оролцож буй бичлэг үзнэ.<br><br>Бусдын дэмжлэгээр багшийн асуултын дагуу хариултыг зурган карт ашиглан өргөж харуулна. | -Дохиотой болон дохиогүй замын хөдөлгөөнд зөв оролцож буй бичлэг үзнэ.<br>-Гарц болон гэрлэн дохионы зурагнаас гэрлэн дохионы зургийг сонгож өргөнө. | -Дохиотой болон дохиогүй замаар зорчиж буй бичлэг үзүүлнэ.<br>-Бичлэгт тулгуурлан зурган картыг сонгуулан өргүүлэх<br>- Буруу өргөвөл засаж тусална. | -Зурган карт<br><br>-Дохиотой болон дохиогүй замаар зорчиж буй хүүхдийн зураг ба бичлэг бэлдэнэ.<br><br>-Бичвэр болон зурган тараах материал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | -Зөв ба буруу үйлдлийг ялган тэмдэглэнэ.<br> | Өгөгдсөн бичвэрийг уншиж зөв ба бурууг ялган тэмдэглэгээг хийнэ.<br>**1. Улаан гэрэл асвал зам хөндлөн гарна.**<br>**2. Дохиогүй замаар гарахдаа гүйж гарна.**<br>**3. Дохиогүй замаар гарахдаа машин харж гарна.**<br>**4. Ногоон гэрэл асвал зам хөндлөн гарна.** | -Өгөгдсөн зургийг ажиглан зөв ба бурууг ялган тэмдэглэгээг хийнэ.<br> |  <br>-Явж буй,зогсож буй хүүхдийн зургийг гэрлэн дохионы улаан ногоон өнгөтэй холбоно.<br> | -Туслах багш хүндэвтэр болон хүнд хүүхдийг чиглүүлж тусална.<br>-Багш даалгаврыг тайлбарлана<br>-Сурагчдын хийж буйг ажиглан чиглүүлж хүнд сурагчидтай ажиллана.<br>-Багш бичвэр ба зургийг самбарт байрлуулна.<br>-Туслах багш хүндэвтэр болон бусад хүнд сурагчдыг дэмжин ажиллана. | |
| **Амраах цаг-**<br>**3 минут** | -Гэрлэн дохио дууг дасгал хөдөлгөөнтэй хийнэ. | -Дууг, дуулж хөдөлгөөнийг зөв хийнэ. | -Дасгалыг даган дуурайж хийнэ. | -Багшийн тусламжтай дасгалыг хийж гүйцэтгэнэ. | -Багш сурагчидтай хамт дуулж, дасгалыг хийнэ.<br><br>-Туслах багш хүнд сурагчийг дагуулан дасгалыг зөв хийлгэнэ. | -“Гэрлэн дохио” дуу бичлэгээр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Өрнөл -15 минут** | -Дохиотой болон дохиогүй замын хөдөлгөөнд зөв оролцох дадлага хийнэ. | -Сурагчид ассан гэрлийн дагуу замаар зөв зорчино.<br><br>-Дохиогүй замаар зөв зорчино. | -Бусдын дэмжлэгтэй ассан гэрлийн дагуу замаар зөв зрчино.<br><br>-Дохиогүй замаар бусдын дэмжлэгтэй зөв зорчино. | -Улаан ба ногоон гэрлээр багшийн дэмжлэгтэйгээр замаар зорчино. | -Багш зохицуулагч хийнэ.<br><br>-Сурагчдын хийж буй үйлдлийг ажиглан зөвлөн тусална.<br><br>-Туслах багш буруу хийж буй болон ойлгохгүй байгаа сурагчдад туслан, дэмжлэг үзүүлнэ. | -Гэрлэн дохио<br>-Замын гарц<br>-Машины макетууд<br>-шүгэл |
| **Дүгнэлт-5 минут** | -Хичээлээ бататган дүгнэж ярилцана.<br><br>-Өөрсдийгөө үнэлнэ. | -Дохиотой болон дохиогүй замаар зам хөндлөн гарч буй зургийг ялган самбарт байрлуулан ярилцана. | -Гэрлэн дохио болон гарцаар зөв гарч байгаа зургийг ялган тавих. | -Самбарт байгаа замын загвар дээр багшийн тусламжтай ажиллана | -Багш сурагчдын хичээлээр олж авсан мэдлэгийг дүгнэн урамшуулна. | -Хичээлд ашигласан хэрэглэгдэхүүн, тараах материал, загвар<br>-Хүүхдийн өөрийн зураг<br>-Тоглоомон гэрлэн дохио |

## 1-4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 63 ДУГААР ТУСГАЙ СУРГУУЛЬ (3 ДУГААР АНГИ)

**Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр – бодит байдлын судалгааны хүснэгт**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Анги | [redacted] анги [redacted] | Анги удирдсан багш | [redacted] | Боловсруулсан огноо | 2017 он 09 сар 14 өдөр |
| Овог нэр | [redacted] | Хүйс | 2.эм | Төрсөн огноо (нас) | 2005 он 01 сар 21 өдөр 11 нас |
| Эцэг эхийн овог нэр | [redacted] | Гэр бүлийн байдал | Ам бүл 4 | Нэмэлт мэдээлэл | Аав, ээж, эгчийн хамт амьдардаг |
| Гэрийн хаяг | ХУД 15-р хороо үйлдвэр ХД 92-1 | Холбоо барих утас | 1. [redacted] | E-mail | [redacted] |
| Эрүүл мэндийн байгууллагын оноштой эсэх | Тийм (Аутизм ) | Онош тавьсан ЭМ-ийн байгууллагын нэр | Алтболд эмнэлэг Өлзийбаяр эмч | Сургуульд элсэн орсон нас | 10 нас |
| Сургуулийн үнэлгээ оношилгоо хийгдсэн эсэх | Тийм (2015.11) (Аутизм) | | | | |
| Хавсарсан бэрхшээлтэй эсэх | Тийм (Оюун ухаан, хэл яриа, майга тавхай) | Өөр бусад байгууллагаар үнэлгээ хийлгэж байсан эсэх | Тийм<br>Аутизмын холбоо мэргэжилтэн | Эрүүл мэндийн байгууллагатай холбоотой байгаа эсэх | Тийм<br>( [redacted] эмнэлэг, 15-р хорооны өрхийн эмнэлэг ) |
| Хүүхдийн байдал (дуртай зүйл, дургүй зүйл г.м) | төрсний дараа /0-12 сар хүртэл/ (Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглаж болно)<br>• түнхний дутуу хөгжил, мултралтай байсан учир 2нас хүртлээ Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн эмчийн хяналтанд байсан<br>• тархиндаа устай | | | | |
| | 2. Сургуульд орохоос өмнөх байдал /2-5 нас<br>Цэцэрлэгт явж байсан эсэх (тийм/ үгүй)<br>• Аутизмтай хүүхэд явах цэцэрлэг байхгүй байсан • багаасаа дөрөөвчтэй байсан | | | | |
| | 3. Сургуульд орсон цагаас эхлэн өнөөг хүртэлх хүүхдийн байдал (тэргэнцэртэй эсэх, ганцаараа сургуульдаа ирж очдог эсэх гэх мэтийг оролцуулна)<br>▪ Бие дааж ирж очих чадваргүй эцэг эх асран хамгаалагч нь хүргэж өгч, авдаг.<br>▪ Хүүхдүүдийн дунд ороод бухимдах, уурлах нь багассан | | | | |

| | |
|---|---|
| | ▪ Хөгжим сонсох дуртай<br>▪ Хоёр гартаа барьсан модон шоог нийлүүлэхгүй.<br>▪ Шонгоос цагирагийг салгана<br>▪ Бингоны нүхтэй хавтгайнаас модон шоог салгана<br>▪ Саванд байгаа юмыг гараараа авна<br>▪ Хэвнээс дүрсийг гаргана<br>▪ Халбага бариулахад хоолоо халбагадаж иднэ.<br>▪ Гутлаа тайлна<br>▪ Гараа хазна<br>▪ Толгойгоо гараараа болон гартаа барьсан зүйлээрээ цохино |
| Хүүхдийн өөрийн хүсэл | Хүүхэд ярихгүй харилцаанд орохгүй учир өөрөө юу сурч мэдэх хүслээ илэрхийлж хэлж чадахгүй.<br>Хөгжим сонссон үедээ болон өөрийн идэх дуртай амттанаа идэх үедээ тайван болж бага зэрэг төвлөрч багшийнхаа дэмжлэгтэйгээр хичээлээ хийх оролдлого хандлага илэрнэ. |
| Эцэг эхийн хүсэл | Ямар нэг зүйл хийгээд тогтвортой суудаг болоосой. |
| Багшийн хүсэл | Зурган картаа ашиглан өөрийн хүслээ тайван илэрхийлдэг болоосой. |

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө** （ **1 ул** ・ **2 ул** ・ **3 ул** ・ **4ул** ）

| Анги | [redacted] | АУБ | [redacted] | Боловсруулсан огноо | 2017 он 9 сар 14 өдөра | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Овог нэр | [redacted] | Хүйс | 2.эм | Төрсөн огноо (Нас) | 2005 он 01 сар 21 өдөр ( 12 нас) | | |
| Урт хугацааны зорилт | Өөртөө үйлчлэх энгийн Чадвар | Гараа угаах | | Дэмжлэгийн орчин буюу хэзээ, хаана, ямар үед | Сургуулийн орчинд | | |
| | Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | Баримлын шавраар баримлалдах  дүрсүүд таниулах | | | Монгол хэл, математик, нийгэм ахуйн баримжаа | | |
| | Нийгэмшихүй | Зурган карт ашиглан өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлдэг болох | | | Сургуулийн амьдралд бүхэлд нь | | |
| | Хөдөлгөөн | Жижиг булчингийн хөдөлгөөнийг сайжруулах | | | Гэр сургуулийн орчин, эмчилгээний биеийн тамир | | |

<table>
<tr><th colspan="2" rowspan="2">Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед</th><th rowspan="2">Улирлын зорилт</th><th rowspan="2">Хичээлийн агуулга</th><th rowspan="2">Багшийн дэмжлэг, арга зүй /дэлгэрэнгүй/</th><th colspan="3">Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл</th></tr>
<tr><th>Сургуулийн орчинд</th><th>Гэрийн нөхцөлд</th><th>Боловсруулсан багш</th></tr>
<tr><td colspan="2">Сургууль орчин ба гэрийн нөхцөл</td><td>Гараа хазах, толгойгоо цохихыг багасгах</td><td>Гараа хазах, толгойгоо цохих үйлдлийг багасгахын тулд хүүхдийн сонирхлыг татахуйц тоглоом, дасгал даалгавар гүйцэтгүүлэх</td><td>Хийх гэж буй зүйл нь ойлгомжтой байх зураг бүхий хуваарийг бэлтгэн харуулна.<br>Даалгавар, тоглоомыг сагсанд хийж бэлтгэнэ.<br>Тоглох тоглоом, хийх зүйлийн тухай харуулсан зурган картыг үзүүлнэ.<br>Зурган хуваарийн дараалын дагуу бэлтгэсэн даалгавар, тоглоомыг гарган багштайгаа хамтран хийнэ.<br>Гүйцэтгэлийн явцад болон хийж дуусcаны дараа багш алгаа ташиж урамшуулна.<br>Шаардлагатай үед PROMPT буюу тусламж үзүүлэх арга ашиглана.<br>Завгүй байлгана.</td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Ганцаарчилсан сургалтын цаг</td><td>Эмчилгээний биеийн тамир 20 минут</td><td>Анхаарлын төвлөрөлт, хуваарилалтыг тогтворжуулж сургах</td><td>Дуу болон тоглоомыг ашиглан 1-2 минутын хугацаанд сурагчийн анхаарлын төвлөрөлт, хуваарилалтыг тогтворжуулна.</td><td>Хөгжим сонсгон сурагчийг тайвшруулах<br>Тайвшруулах массаж иллэг хийх<br>Тоглоом тоглуулан нэг зүйлд анхаарлыг төвлөрүүлж сургах</td><td></td><td></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хичээл судлагдахуунаар | Монгол Хэл | Жижиг булчингийн хөдөлгөөнийг сайжруулах | Баримлын шаврыг дарж наах | Баримлын шаврыг дарж нааж буй зурагтай зурган картыг харуулна. Урьдчилан жижиглэн бэлтгэсэн баримлын шаврыг хичээлийн хөтөлбөрт тусгагдсан даалгаврын дагуу бэлтгэсэн зураг болон үсгэн дээр тавьж өгөхөд өөрөө дарах үйлдлийг хийн багшийн дэмжлэгтэйгээр даалгавраа гүйцэтгэнэ. Гүйцэтгэлийн явцад болон хийж дууссаны дараа багш алгааташиж урамшуулна. | | | | |
| | Математик | Дугуй дүрсийг таниулах | Дугуй дүрсийг тохируулан наах | Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрс бүхий бэлтгэсэн хавтгай дээрх дугуй дүрсэн дээр дугуй дүрсийг нааж буй зурган картыг харуулна. Ширээн дээр дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг зурж дээр нь зангуу наан бэлтгэсэн хавтгайг тавьж өгнө. Гарт нь зангуу наасан дугуй дүрсийг бариулан бэлтгэсэн хавтгай дээрх дугуй дүрсний зангуун дээр гарт барьсан дугуй дүрснийхээ зангууг тааруулан тавьж хооронд нь наалдуулан дугуй дүрсээ тавих үйлдлийг багшийн хамт хийнэ. Дараагийн дугуй дүрсийг гарт нь бариулж өөрөөр нь хийлгүүлэх оролдлого хийнэ. Дугуй дүрсээ бэлтгэсэн хавтгай дээрх дугуй дүрсэн дээр наахад нь сайн байна, баяр хүргэе гэж хэлэн алга ташин урамшуулна. | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ахуй засал | Гараа гар угаах дарааллын дагуу зөв угаах | Гар угаах дараалал бүхий зурган картаа харж крантаа нээн усаа гоожуулах, гараа норгох, гараа савандах үйлдлийг хийж сурах. | Бие зассаны дараа болон “Үдийн цай”-ны өмнө “Гар угаах” дараалал бүхий зурган картны ус нээх зургийг заан крантыг нээлгэн усыг гоожуулах үйлдлийг хийлгэнэ. Гараа усаар норгож буй зургийг заан харуулж гоожиж буй усаар гараа норгох. Савандаж буй зургийг заан саван гарт нь бариулж гарыг нь савандуулах үйлдлүүдийг багшийн хамт хийнэ. I улиралд дээрх 3 үйлдлийг өөрөөр нь хийлгэх оролдлогыг хийлгэн өөрөө хийж суртал нь багш хамтран хийлгэж дэмжлэг үзүүлнэ. Гар угаах дарааллын дараах зургуудыг заан багшийн хамтаар гарыг угаалгаж дуусгах ба эхний 3 үйлдлийг хийж сурсны дараа дараагийн алхамд шилжинэ. Гар угааж дууссаны дараа сайн байна гэж алгаа ташиж урамшуулан магтана. Крантаа нээж усаа гоожуулах, гараа норгох, гараа савандах үйлдлүүдийг хийж сурах хүртэл багш дэмжлэг үзүүлнэ. | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийгэм ахуйн баримжаа | Багштай хамт тоглонгоо багшийн хэлж буй зааврыг ойлгон тохирсон үйлдлийг хийж чаддаг болох | Өрдөг шоо<br>Цагираг<br>Тахиа эвлүүлэх тоглоомнуудын зурагтай зурган картаа харж багштайгаа хамтран тоглоно. | Өрдөг шоотой зурган картыг харуулан сагснаас өрдөг шоог гарган ширээн дээр тавьж өгөхөд өөрөө дээр дээрээс нь давхарлан өрнө.<br>Цагираг тоглоомтой зурган картыг харуулж тоглоомыг сагснаас авч цагирагийг шонгоос нь өөрөөр нь гаргуулах ба буцаан шонд нь углаж өрөх<br>Тахиа эвлүүлэх тоглоомын зурган картыг харуулж сагснаас тоглоомыг гарган хавтгай дээрх тахианы их бие, залаа, хөл, сүүл бүхий хэсгүүдийг багш нэрлэн нүхнээс нь гарган ширээн дээр тавина. Хамгийн том хэсэг болох тахианы их биеийг авч гарт нь өгөхөд нүхэнд нь тааруулан хийнэ. Дараа нь сүүл, залаа, хөлийг нь авч гарт нь бариулан таарах нүхэнд нь хийлгэнэ. Хийж дууссаны дараа баяр хүргэе, сайн байна гэж алга ташин урамшуулна. | | | | |

## Ээлжит хичээлийн хөтөлбөр /хураангуй/

Хичээлийн нэр: Дүрслэх урлаг

Хүүхдийн тоо: Эр 4 Эм 3 Нийт 7

Хичээл заагч багш [redacted] Туслах багш [redacted]

**1. Бүлэг сэдвийн нэр: "Дүрслэх аргад суралцах" Нэгж хичээлийн нэр: "Тэгш хэм"**

**Ээлжит хичээлийн сэдэв: "Гүзээлзгэнэ урлах"**

**Нэгж хичээлийн төлөвлөгөө**: Нийт 9 цаг **7-р цаг** /ээлжит хичээл/

**2. Ээлжит хичээлийн зорилго:**

**(1) Үндсэн зорилго**:

| ХБ-ийн хэлбэр | Ээлжит хичээлийн зорилго |
|---|---|
| Хөнгөн хэлбэрийн 3 хүүхэд | Тэгш хэмийн тухай ойлголтоо бататган усан будгаар тэгш хэмт зураг үүсгэн гүзээлзгэнэ урлах |
| Хүндэвтэр хэлбэрийн 3 хүүхэд | Бэлдэц дээр усан будгаар тэгш хэмт зураг үүсгэн гүзээлзгэнэ урлах |
| Хүнд хэлбэрийн 1 хүүхэд | Зурах, будах, хайчлах, наах үйлийг нь дэмжин усан будгаар тэгш хэмт зураг үүсгэн гүзээлзгэнэ урлах |

**(2) Ээлжит хичээлийн хөтөлбөр /Явц/**

Хичээлд хэрэглэгдэх хайч, цавуу, балын харандаа, усан будаг, бийрийг хэрэглээд тэмдэглэгээ бүхий саванд буцаан хийх. Хичээлд хэрэглэх багажаа тэмдэглэгээний дагуу зөв байрлуулах, хэрэглэж дуусаад багажаа тэмдэглэгээ бүхий газарт нь байршуулах талаар сануулан шаардлагатай сурагчдад дэмжлэг үзүүлнэ.

| | Сурагчийн үйл ажиллагаа | Хөнгөн хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга | Хүндэвтэр хүүхдийн багийн сургалтын агуулга | Хүнд хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга | Багшийн үйл ажиллагаа /хичээлийн явцад анхаарах зүйл/ | Бэлдэх зүйл |
|---|---|---|---|---|---|---|
| **Сэдэлжүүлэлт /7 минут/** | Өмнөх хичээлд үзсэн зүйлээ бататган, гүзээлзгэнэ урлах тухай мэдэж авна. | Самбарт байрлуулсан ойг ажиглан "Ой" гэж хэлэх болон ойд байгаа зүйлсийг нэрлэнэ. Мод, эрвээхийг нугалан харуулахад тэгш хэм үүсгэж буйг хэлнэ. Үүл тэгш хэм үүсгэхгүй байгааг хэлнэ.<br><br>Навчийг тоолно, өнгийг нэрлэнэ. Бичлэгээ үзэн багшийн асуултад хариулна.<br><br>Гүзээлзгэнэ урлах тухай мэдэж авна. | Бэлтгэсэн ой болон ойд байгаа зүйлсийг ажиглана, нэрлэнэ, заана. Навчийг тоолж тоог хэлэх болон хуруугаараа үзүүлнэ. Бичлэг үзнэ. Өнгийг нэрлэнэ, заана. | Туслах багшийн дэмжлэгтэйгээр ойгоо ажиглан тэгш хэмтэй зүйлс болон навчийг заана, өргөж харуулна.Бичлэг үзнэ. | Ватум цаасан дээр бэлтгэсэн ойг самбарт байрлуулан анги нийтийн дунд Энэ юу вэ? асуултыг тавина.<br>Өмнөх хичээлүүд дээр урласан бүтээлээр ойг урласан тухай хэлж сайн ажиглаарай, юу юу байгааг нэрлээрэй гэж хэлэн ажиглуулна, нэрлүүлнэ.<br>Мод, эрвээхийг нугалан харуулж тэгш хэм үүсгэж байгааг хэлж өгөн тэгш хэмийн тухай ойлголтыг сэргээн сануулна. | батум цаасан дээр ойгоо хийн бэлтгэх |

| |
|---|
| |
| Үүл, нугалахад тэгш хэм үүсч байна уу? хараарай, ажиглаарай.<br>Навчийг нэрлэхэд сурагчдаар навчийг тоолуулна, өнгийг нэрлүүлнэ.<br><br>Бичлэг тавьж өгнө.<br>Бичлэгээ анхааралтай үзээрэй. За юу болов?<br>Миша жимсээр юу хийсэн бэ?<br>Миша баавгайгаа ойдоо ирэхээс нь өмнө гүзээлзгэнэ урлан навчин доороо байрлуулъя.<br>Хүүхэд бүр гүзээлзгэнэ урлахад бүх навч маань гүзээлзгэнэтэй болох нь гэдгийг хэлж сурагчдыг зорилгожуулна.<br>Бүгдээрээ гүзээлзгэнээ урлацгаая. |
| |
| |
| |
| |
| |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тэгш хэмтэй зүйлсийг зөв нэрлэсэн, зөв заасан, асуултад зөв хариулсан, хичээлд идэвхтэй оролцсон сурагчиддаа "Сайн байна" гэж хэлэн магтаж урамшуулна. Гүзээлзгэнэ урлах заавryг тайлбарлан хэлж өгнө. Гүзээлзгэнээ урлахдаа:<br>нугалах<br>зурах<br>хайчлах<br>толболох<br>наах гэсэн дараалаар бүтээлээ урлана гэдгийг хэлж алхмуудыг самбарт байрлуулна. | |
| | | | | | | Хүүхэд бүрийн онцлогт тохирсон урьдчилан бэлтгэсэн бэлдцийг ширээний хажуу дахь сагсанд хийсэн байгааг хэлж өгнө. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Бүтээл урлах /20 минут/** | Хүүхэд бүр өөрсдийн онцлогт тохирсон даалгаврыг гүйцэтгэнэ | Багшийн өгсөн зааврын дагуу цаасаа нугалан шабломоо тавьж гүзээлзгэний жимсээ зуран хайчилна. Жимснийхээ нэг тал дээр усан будгаар толболон нөгөө тал руу нугалан харвуулж гүзээлзгэнийхээ толбыг хийнэ. Алжаал тайлах дасгал Жимсэн дээрээ ишээ нааж гүзээлзгэнээ бэлэн болгоно. | Багшийн заавар, бэлдэц дээрх тасархай зураас, тоог холбон жимсээ зурж хайчилна. Жимснийхээ нэг тал дээр усан будгаар толболон нөгөө тал руу нугалан харвуулж жимснийхээ толбыг урлана. Жимсэн дээрээ ишээ наан гүзээлзгэнээ бэлэн болгоно. | Туслах багшийн хамтаар бэлдэц дээрх тасархай зураасыг холбон жимсээ зурж хайчилна. Жимснийхээ нэг тал дээр усан будгаар толболон нөгөө тал руу нугалан харвуулж жимснийхээ толбыг урлана. Жимсэн дээрээ ишээ наан гүзээлзгэнээ бэлэн болгоно. | Хөнгөн хэлбэрийн хүүхдүүд цаасаа нугалан цаасан дээрээ шабломыг тавьж зуран хайчилж гүзээлзгэний жимсээ бэлтгээрэй. Бэлтгэсэн жимсний нэг тал дээр усан будгаар толболон нөгөө тал руу нугалж харвуулан гүзээлзгэний толбоо урлаарай. Хүндэвтэр, хүнд хэлбэрийн сурагчид бэлдэц дээрх тасархай зураас, тоог холбон зурж хайчлан гүзээлзгэний жимсээ урлаарай. Бэлтгэсэн жимсний нэг тал дээр усан будгаар толболон нөгөө тал руу нугалж харвуулан гүзээлзгэний толбоо урлаарай. Алжаал тайлах дасгалын дараа жимснийхээ ишийг наан гүзээлзгэнээ бэлэн болгох тухай тайлбарлан хэлж өгнө. | Гүзээлзгэний шаблом, иш, нугалсан цаасан дээр тасархай зураас, тоо бүхий тэмдэглэгээг хийн бэлдэцээ бэлтгэх. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүндэвтэр болон хүнд хэлбэрийн хүүхдүүдэд тусална. Хичээлийн явцад сурагчиддаа "сайн байна", "зөв байна", "мундаг байна" гэхчлэн үгийг хэлж магтан урамшуулна. гэж | |
| **Амраах /3 минут/** | Алжаал тайлах дасгал | Гүзээлзгэнэ жимс дууны аянд багшийн хийж буй хөдөлгөөнийг даган хийнэ. | | | | |
| **Дүгнэлт /7 минут /** | Өөрсдийн урласан гүзээлзгэнээ ой доторх гүзээлзгэний навчин доор наана. Гэрийн даалгавраа авна. | Ангийнхандаа урласан гүзээлзгэнээ харуулан хэрхэн хийсэн тухайгаа тайлбарлан ой доторх гүзээлзгэний навчин доор наан байрлуулна. | Урласан гүзээлзгэнээ ой доторх гүзээлзгэний навчин доор наана. | Туслах багшийн дэмжлэгтэйгээр гүзээлзгэнээ хэрхэн хийсэн тухайгаа бусаддаа танилцуулан ой доторх гүзээлзгэний навчин доор наана. | Хичээл заагч багш хүндэвтэр хүүхдүүдэд, туслах багш хүнд хүүхдүүдэд тусална. Хүүхдүүдээр өөрсдийн нь юу хийсэн тухай яриулахыг дэмжин тусална. | гэртээ: гүзээлзгэнээ будаад, хайчлаад ирээрэй. |

## 1-5. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 70 ДУГААР ТУСГАЙ СУРГУУЛЬ (3 ДУГААР АНГИ)

| Анги | [redacted] анги [redacted] бүлэг | Анги удирдсан багш | [redacted] | Боловсруулсан огноо | 2017он 09 сар 15 өдөр |
|---|---|---|---|---|---|
| Овог нэр | [redacted] | Хүйс: эр | 1.эр | Төрсөн огноо | [redacted] |
| Эцэг эхийн нэр | [redacted] | Гэр бүлийн байдал | Ээж,өвөө,эмээтэйгээ амьдардаг. | Нэмэлт мэдээлэл | |
| Гэрийн хаяг | [redacted] | Холбоо барих утас | [redacted] | E-mail | |
| Эрүүл мэндийн байгууллагын оноштой эсэх | Тийм ) байгаа | Онош тавьсан ЭМ-ийн байгууллагын нэр | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | Сургуульд элсэн орсон нас | 8 настай сургуульд орсон. |
| Сургуулийн үнэлгээ оношилгоо хийгдсэн эсэх | Тийм (огноо ) Бэрхшээлийн нэр: Оюун ухааны бэрхшээл ба сэтгэцийн өөрчлөлтэй | | | | |
| Хавсарсан бэрхшээлтэй эсэх | Тийм<br>хэл ярианы бэрхшээлтэй сэтгэцийн өөрчлөлттэй | Гадаад, дотоодын өөр бусад байгууллагаар үнэлгээ хийлгэж байсан эсэх | Үгүй | Эрүүл мэндийн байгууллагатай холбоотой байгаа эсэх | Тийм<br>Эх нялхас, Шар хадны сэтгэц холбоотой |
| Хүүхдийн байдал (дуртай зүйл, дургүй зүйл г.м ) | Төрсний дараа /0-12 сар хүртэл/ (Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглаж болно)<br>• 0-3наснаас эмнэлэгээр үзүүлж эхэлсэн.<br>• 6-7настайдаа мөлхөж эхэлсэн.<br>12 сартайдаа хөлд орж явсан. | | | | |
| | 2. Сургуульд орохоос өмнөх байдал /2-5 нас/<br>Цэцэрлэгт явж байсан эсэх (тийм) (Цэцэрлэгийн нэр:) (-р цэцэрлэгт 4 жил явсан.<br>• 1- р ангид ороод өдөр өнжүүлэхэд явж эхэлсэн ч хамт явдаг хүүхдүүд гадуурхдаг байсан учраас их дургүй байсан.<br>Дахиад өөр өдөр өнжүүлэхэд яваад тэнд явж байсан хүүхдүүд нь их сайн хандаг байсан тул их дуртай болсон.<br>Гар самбар дээр Өвөө Эмээ Ах гэдэг үгийг өөрөө бичдэг болсон. | | | | |

| | |
|---|---|
| | 3. Сургуульд орсон цагаас эхлэн өнөөг хүртэлх хүүхдийн байдал /тэргэнцэртэй эсэх, ганцаараа сургуульдаа ирж очдог эсэх гэх мэтийг оруулан бичих/<br>• Сургуулийн автобусанд сууж хичээлдээ ирдэг.<br>• Гутлаа буруу харуулж өмсдөг, сургуульдаа ганцаараа ирж, очиж чадахгүй, гараа угаахдаа дургүй, зүүн гараараа юм хийх дургүй,<br>• Дүрс ялгадаггүй, олон өнгөнөөс ногоон, шар өнгийг сонгож авч чадна гэхдээ бусад өнгийг мэдэхгүй, 1-5 хүртэл оноож, чээжээр тоолж чаддаг боловч 1,5-с өөр цифр таньдаггүй,<br>• О үсгээ танина. үсгүүдийг картаар үзүүлэхэд уншиж чадахгүй. \ном, ах ээж, ус,багш,өвөө ээж,эмээ гэх мэт ойр зуурын хэрэглээний үгсийг хэлдэг болдог болсон.<br>• Бусдын хийж буй үйл хөдлөлийг даган дуурайхдаа дунд зэрэг<br>• Ярих дургүй, ганц нэг үгээр ярьдаг, хүүхдүүдэд элэгсэг дотно халамжтай ханддаг, ангид болж байгаа замбараагүй асуудлыг зохицуулах сонирхолтой.<br>• Дүрэм журам баримтлахдаа дунд зэрэг,чадах зүйлээ чадна гэж шууд хэлдэг,бас чадахгүй зүйлээ би чадахгүй гэж нүдээ аниж байгаад хэлдэг.<br>• Дуу хөгжим, шүлэг уншихдаа дургүй.албан хүчээр дагуулж уншуулна.<br>• Маш их уйланхай, энэ нь бусад хүүхдүүдтэй харилцахдаа ямар нэгэн зүйлийг өөрийн дураар хийхгүй үед уйлдаг,бас өөрийнх нь биед бага зэрэг хүрэхэд уйлж, уйлагнадаг. Хөдөлгөөн удаавтар, алхаж гүйж чадна, жижиг булчингийн хөдөлгөөн шаардсан шоо зэргийг өрж эвлүүлэхдээ сайн. Гэрт нь очиход ээж өвөө эмээтэйгээ тохилог хувийн 2 давхар байшинд амьдардаг.Гэрт нь зочлон очиход маш сайхан зантай өөрийнхөө өрөөнд оруулж үзүүлэх, ямар нэгэн хүн гэрт нь ирэхэд зочломтгой, хүнд бэлэг өгөх дуртай ба өглөгч зантай гэж эмээ нь хэлсэн. |
| Хүүхдийн өөрийн хүсэл | Ярихдаа муу учраас юу гэж хариулахаа мэдэхгүй ч хүнтэй ярих хүсэлтэй. жоохон хүүхдийн тоглоомоор тоглох дуртай. Аливаа зүйлд өөрөө бие даан оролцох, зохицуулах сонирхолтой. |
| Эцэг эхийн хүсэл | Найз нөхөд,багш бусадтай харилцаж сургах, хичээлдээ анхааралтай суудаг болох, одоо байгаагаас илүү хөгжүүлэх / бүх талаар / |
| Багшийн хүсэл | Бусдад саад болохгүй хичээлд анхааралтай суудаг болгоно. |

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө ( 1 ул · 2 ул · 3 ул · 4ул )**

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Анги | Занги [redacted] | | АУБ | [redacted] | Боловсруулсан огноо | 2017 он 10сар 10өдөр |
| Овог нэр | [redacted] | | Хүйс: эр | 1.эр | Төрсөн огноо | [redacted] |
| Урт хугацааны зорилт | Өөртөө үйлчлэх энгийн чадвар | Бусдын тусламжгүйгээр өөрөө гутал, хувцсаа өмсдөг болох<br>Томчуудаар шаардуулалгүй хоол идэхийн өмнө , бие зассаны дараа гараа угаадаг чадвартай болгох | | | Дэмжлэгийн орчин буюу хэзээ, хаана, ямар үед | Сургууль дээр ирэх, явахдаа, нийгэм ахуйн баримжаа хичээл дээр, сургуулийн амьдралд бүхэлд нь |
| | Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | Дүрсүүдийг ялгах, нэрлэх,<br>улаан, ногоон, цэнхэр өнгөөр ялган будах, зурах<br>зураг харж нэрлэж сурах<br>шүлгийн утгыг ойлгож хөдөлгөөнөөр даган дуурайж унших<br>/ Нойрмог туулай, Эх нутгаа саналаа, Хайртай шүлгүүд /<br>1-10 хүртэл гараараа тоолж сурах<br>Цифрүүдийг өөрөө бичиж сурах / 6 7 8 / | | | | Математик<br>Хэл яриа, Монгол хэл |
| | Нийгэмшихүй | Найз нартайгаа эвтэй харьцаж хэвших<br>/ Уйлдаггүй,уурладаггүй болгох /<br>Бусадтай хамтарч хичээлээ хийж, зөв сууж сурна. | | | | Сургуулийн амьдрал бүхэлд нь, хэл яриа |
| | Хөдөлгөөн | Шүлгүүдийг хөдөлгөөнөөр даган дуурайж унших, дасгал хөдөлгөөн хийдэг болгох | | | | |
| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | Улирлын зорилт (Богино хугацааны зорилт) | Хичээлийн агуулга | Багшийн дэмжлэг, арга зүй /дэлгэрэнгүй/ | Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл | | |
| | | | | Сургуулийн орчинд | Гэрийн нөхцөлд | Боловсруулсан багш |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Сургуулийн амьдрал хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар /судлагдахууныг оруулахгүй/** | Өдрийн хоол идэхийн өмнө бие зассаны дараа гараа угаахыг заахад бэлдсэн картыг харангаа өөрөө бие дааж угааж чаддаг болох | Гэр бүл, Хүрээлэн буй орчин сэдвийн хүрээнд | Даган дуурайж, зургийг харж дараалаар угаалгана.<br><br>Гар угаах дарааллын зурагт үзүүлэнг тайлбарлан багш өөрөө биетээр угааж үзүүлнэ. | Үдийн цайнд орох үедээ багшийн дэмжлэгтэйгээр зураг харж гараа угаана. Мөн бие зассаны дараа гараа угааж хэвшүүлнэ. | Өглөө орой өдөр тогтмол угаалгана. Үүнд эмээ ээж нарын тусламжтай өглөө босоод, хичээлээсээ очоод цайгаа уухын өмнө, хичээлээ хийхийн өмнө гараа угааж хэвшүүлнэ. Багшийн бэлтгэж өгсөн зурагт үзүүлэнг өөрийн өрөө, угаалгын өрөө зэрэгт нааж байрлуулна. | М.Өнөрмаа |
| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | Энэ улирлын зорилт (Богино хугацааны зорилт) | Хичээлийн агуулга | Багшийн дэмжлэг, арга зүй / дэлгэрэнгүй/ | Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл | | |
| | | | | Сургуулийн орчинд | Гэрийн нөхцөлд | Боловсруулсан багш |
| Судлагдахуунаар — Монгол хэл | Б, П, С, Ш авиаг сонсож, зөв хэлж дуудах | Авиан сонсгол | Зурагтай бичмэл үзүүлэнг үзүүлж авиаг хэлж өгнө. Дараа нь багш 2-3 удаа хэлж сурагч даган дуурайж хэлнэ.Б П, С, Ш үсэг орсон үгтэй зураг харуулж, үгийг дагуулж хэлүүлэх дасгал хийлгэнэ. | Хичээлийн цагаар сурагчидтай хамтарч авиан дуудлагыг дагуулан хэлүүлнэ.<br><br>Б П, С Ш- авиаг хос хосоор нь давтан хэлүүлнэ.<br><br>Дээрх авиа орсон үгнүүдийг зурагт үзүүлэнгээс харуулж хэлүүлнэ. | Ээж эмээ нартайгаа хамтран авиаг хэлж, давтана.<br><br>Бичмэлээр бичсэн үсгийг өөрийн өрөөндөө нааж, өглөө орой даалгавраа хийх үедээ авиагаа давтан хэлэх дасгал хийнэ. Энэ дасгал ажлыг ээж эмээтэйгээ хамтарч хийнэ. | [redacted] |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Бичмэл үзүүлэнгээс өөрөөр нь хэлүүлнэ. | | |
| | Математик | 10хүртэл тооны бодит жишээ,хэмжээг мэдэх | Тооны бүтэц | 10 ширхэг харандаа, савх мод, шагай зэрэг бодит үзүүлэнг өрж тавиад оногдуулж тоолуулах, хийсвэрээр тоолуулна. | Математикийн хичээл дээр сурагчидтай хамт тоолуулах, 1-10 хүртэлх тооны цифрийг зурагт үзүүлэнгээс олуулна. 1-10 хүртэлх цифр бичсэн тараах материал өгч өөрөө нь хэлүүлнэ. | Гэрт байгаа эд хогшил, тавилга зэргийг тоолуулна. Хоол хүнсэнд хэрэглэж байгаа зүйлсийг нэрлүүлж, тоолуулна. Хичээл тараад хичээлдээ ирэх замд ээж эмээ нар нь хийсвэрээр тоолуулах дасгалыг хийлгэнэ. | [redacted] |
| | Нийгэм ахуйн баримжаа | Гар угаах дарааллын зурган карт ашиглан гараа угааж чаддаг болох | Гэр бүл хүрээлэн буй орчин | Гар угаах дарааллын зургийг харж угаалгана. | Багш зургийн зааврыг тайлбарлан таниулна. Багш сурагчидтай хамтарч дадлага хийнэ. Үдийн цайнд орох үед бие даалган өөрөөр нь гарыг нь угаалгах дадлага хийлгэнэ. Гар угаах дарааллын зурагт тараах материал өгч дарааллыг тоолуулж тооны хичээлтэй холбож ажиллуулна. | Гэрт нь зурагт үзүүлэнг бэлтгэж өгөн өрөөнд ба угаалгын өрөөнд наалган, ээж эмээ нарын тусламжтай гараа дарааллааар угааж хэвшүүлнэ. | [redacted] |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зураг урлал | Цаасны төрлийг нэрлэх | Дүрслэлийн хэрэгслийг ашиглах урлаг | Янз бүрийн бэлтгэсэн цааснуудыг нэрлүүлэн, зөв харгалзааг үүсгэнэ. | Биет үзүүлэн дээр цааснуудыг нэрлүүлж ялгуулах дадлага ажил хийлгэнэ.Үүнд бичгийн цаас, дэвтрийн цаас, кардон цаас, чихрийн цаас гэх мэтийн цааснуудыг ялгуулан хэлүүлнэ. | Багш зурагт тараах материал, үзүүлэн бэлтгэж өгөн ээж эмээ нарын тусламжтай ялган нэрлэх дасгал ажлыг хийнэ. | [redacted] |

## “ Монгол хэл” ний ээлжит хичээлийн хөтөлбөр

2018 оны 3 сарын 15 өдөр 9:45- эр 9 эм 6 нийт: 15

Хичээл заагч багш: [redacted]

Ерөнхий агуулга: Бүлэг сэдвийн нэр: Үйл үг

1. Нэгж хичээлийн нэр Үйлийг нэрлэсэн үг
2. Ээлжит хичээлийн нэр “Шуурга” эхээс үйлийг заасан үг ялган зурах
3. Нэгж хичээлийн төлөвлөгөө / нийт 7цаг / 2-р цаг / Ээлжит хичээл /
4. Хичээлийн агуулга

4-1. Ээлжит хичээлийн зорилго:

| **ХБ-н хэлбэр / групп/** | **Ээлжит хичээлийн зорилго:** |
|---|---|
| Хөнгөн | “ Шуурга” эхийг уншиж, утгыг өөрийн ойлгосноор ярин, эхийг дэвтэртээ хуулан бичиж, эхээс үйлийг заасан үг ялган зурж, тэмдэглэнэ.<br>/ Шуурга гэдэг үгийг зөв хэлэх дасгал хийнэ./ |
| Хүндэвтэр | “Шуурга” эхийг давхарлан бичиж, үйлийг заасан үгийг хөдөлгөөнөөр илэрхийлнэ.<br>/ Багшийн тусламжтай ш- авиаг зөв дуудах дасгал хийнэ./ |
| Хүнд | Багшийн тусламжтай үйлийг заасан үг хөдөлгөөнөөр хийж, зураг эвлүүлж наах даалгаврыг гүйцэтгэнэ.<br>/ Багшийн тусламжтай ш- авиаг зөв дуудах дасгал хийнэ / |

4-2. Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэн, хэрчмэл үзүүлэн, телевизор, дүрс бичлэг

4-3. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн явц:

| Цаг төлөв лөлт | Сурагчийн үйл ажиллагаа / ерөнхий явц / | Хөнгөн хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга | Хүндэвтэр хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга | Хүнд хэлбэрийн хүүхдийн багийн сургалтын агуулга | Багшийн үйл ажиллагаа /Хичээлийн явцад анхаарах зүйл/ | Бэлдэх зүйл /Сургалтын хэрэглэг-дэхүүн тарааж өгөх материал/ |
|---|---|---|---|---|---|---|
| Сэдэл-жүүлэлт /1 мин / | Сурагчдад: Хаврын улирлын зураг үзүүлнэ. Асуулт тавьж ярилцана. | Сурагчид: Багшийн асуултад хариулж, харилцан ярилцана. | Сурагчид: Юуны зураг байгааг хэлж, нэрлэнэ. | Сурагчид: Багшийн тусламжтай зургийг заана, үйл хөдлөлөөр хийж үзүүлнэ. | Багш: сурагчдыг хичээлд зохион байгуулж анхааруулан дөхүүлэх асуулт тавих | Хаврын улирлын зураг |
| Өмнөх мэдлэг давтах /5мин/ | Зургаар өгүүлбэр бүтээж самбарт наана. Үйл үгийг хөдөлгөөнөөр илэрхийлж, Үйлийг заасан үгийг үйл үг гэдгийг сэргээн сануулна. | Нэр дуудсан сурагчид зургийг зөв сонгон өгүүлбэр зохион хэлж, хэрчмэл үгийг зургийн ард тохируулахдаа, үйл үг гэдгийг хэлүүлж наалгана. | Нэр дуудсан сурагчдаар зургийг зөв олуулж, юуны зураг болохыг хэлүүлж, самбарт наалгана. | Шуурга шуурч буй зургийг [redacted] олуулж, шуурга гэдэг үгийг дагуулж хэлүүлэхийн тулд Ш-авиаг дараа нь шуу-үеийг хэлүүлж дараа нь бүтэн үгээр нь хэлүүлэх оролдлого хийнэ. [redacted] | Зургийн нэрийг дагуулж хэлүүлнэ. Багш: Хаврын улиралтай холбож, асуулт тавина. Одоо ямар улирал болж байна вэ гэсэн асуултыг тавина. Ш-авиаг зөв дуудах дасгал хийлгэнэ. | Хэрчмэл үг . / орж байна. шуурч байна. мандаж байна./ 3. Нар мандаж буй зураг Бороо орж буй зураг Салхи салхилж буй зурагт үзүүлэн |
| Нүдлэх цээж бичиг 2мин | Зохиосон өгүүлбэрүүдээс Бороо орж байна. өгүүлбэрээр нүдлэх цээж бичиг хийнэ. | Бороо орж байна. гэдэг өгүүлбэрийг самбараас ажигласны дараа дэвтэртээ өөрөө бичнэ./ 30секунд/ | Дэвтэрт бичсэн өгүүлбэрийг давхарлан бичнэ. | Дэвтэртээ давхарлан бичнэ. | Самбарт бичсэн өгүүлбэрийг ажигласны дараа арчиж,цээжээр бичихэд 2-3 удаа хэлж бичүүлнэ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Өрнөл хэсэг<br><br>Сэдэлжүүлэлт: 1ми<br><br>Шинэ мэдлэг 15мин | Сурагчдад шуурганы чимэээ сонсгож юуны чимээ сонссоныг ярилцана.<br>Эндээс өнөөдөр “ Шуурга” эхийг уншина, бичнэ, ярилцана, будна, мэднэ гэдэг үгүүдийг самбарт нааж уншуулж үйл үг болохыг хөдөлгөөнөөр үзүүлнэ.<br><br>Шуурга эхийг багш эхлээд уншиж өгнө, дараа нь сурагчдыг дагуулан уншуулна, мөр мөрөөр нэр цохож уншуулна. Дэвтэрт нь бичүүлнэ. Үйл үгийг улаан өнгөөр будуулна. Алжаал тайлах дасгалыг багштай хамт хийх<br>Шуурга намдлаа / тайван алхана.<br>Шуурга боллоо / Босож зогсоод гараа хөдөлгөн найгана./ | Сурагчид багшийн асуултанд хариулж ярилцана.<br>Даалгаврыг бие даан гүйцэтгэнэ. Даалгавар<br>1. Шуурга эхийг уншиж, утгыг өөрийн ойлгосноор ярина.<br>Дэвтэртээ бичнэ.<br><br>Шуурга<br>Шуурга шуурав.<br>Хавар шуурга шуурдаг.<br>Нар гарч, шуурга намдав.<br>Эхийн өгүүлбэрийг уншаад хэдэн үгээс бүтсэнийг хэлнэ.<br>2. Бие даан өөрсдөө үйлийг заасан үгийг уншиж, ялган улаан өнгөөр ялган будна. | Сурагчид даалгаврыг багшийн тусламжтай гүйцэтгэнэ.<br>Даалагвар<br>1. “Шуурга” эхийг харандаагаар дэвтэрт нь бичсэн байна.<br>/ давхарлан бичих/<br><br>2. Үйлийг заасан үгийг багшийн тусламжтай будна. | Сурагч: Бэлтгэсэн зургийг багшийн тусламжтай зургийг эвлүүлэн наана.<br>/ үйл үгийг даган хэлэх, хөдөлгөөнөөр үзүүлнэ./<br><br>Даалгавар<br>1. Шуурга эхийг давхарлан бичнэ./<br>2. Үйлийг заасан үгийг багшийн тусламжтай будна. | Багш: Шуурганы дуу чимээ сонссонд тулгуурлан өнөөдрийн хичээлийн гарчиг зорилгоо хэлнэ.<br>Даалгавар хийх заавры тайлбарлана.<br>Ш- авиаг зөв дуудах засан сайжруулах ажилд<br>Хүндэвтэр, хүнд хэлбэрийн сурагчдад даалгаврыг хийхэд тусална.<br><br>Алжаал тайлах дасгалыг хийх заавры тайлбарлан тоглоом тоглох үед Б.Мөнх-Оргилыг хажуудаа дагуулан хөдөлгөөнийг хийлгэнэ. | Шуурганы дуу чимээ / бичлэг/<br><br>Дэлгэцээр харуулах “Шуурга” эхийг бичсэн слайд<br><br>Өнгийн харандаа |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Төгсгөл хэсэг<br><br>Бататгах үе шат: 10 мин<br><br>Дүгнэлт: 5мин<br><br>Даалгаавар өгөх 1мин | Сурагчид:<br>Шороон шуурга<br>Цасан шуурганы дүрс бичлэгийг үзэж ялгааг ярилцана.<br>Самбарт наасан зургийг нэр дуудсан сурагчид авч нэрлээд өгүүлбэр зохиож хэлэн үйл үгийг самбарт бичнэ.<br>Зурган картаар өгүүлбэр зохиолгон үйл үгийг хэлүүлнэ.<br><br>Багшийн тавьсан нээлттэй асуултад өөрийн чадвараар хариулна.<br><br>Сурагчид бие биедээ баяр хүргэнэ. | Сурагчид: Дэлгэцээр бичлэг үзүүлж, ялгааг харилцан ярилцана.<br>Цасан болон шороон шуурганы зураг байрлуулсан байна.<br>2 сурагчаар өгүүлбэр зохиолгож, үйл үгийг самбарт бичүүлнэ.<br><br>Зурган картаар өгүүлбэр зохиолгон үйл үгийг хэлүүлнэ.<br><br>Дараах асуултад хариулна.<br>Шороон шуургатай үед чи яах вэ?<br><br>айна, уйлна, гүйнэ, гэртээ орно, нөмөр газар бараадна гэх мэтээр хариулж үйл хөдлөлөөр үзүүлж, үйл үг гэдгийг хэлнэ. | Сурагчид:<br>Багшийн тусламжтай харилцан ярилцана.<br>Шороон болон цасан шуурганы зургаар өгүүлбэр зохиоход дагаж хэлнэ.<br><br>Зурган картаар өгүүлбэр зохиолгон үйл үгийг хэлүүлж үйл хөдлөлөөр үзүүлнэ.<br><br>Үйлийг заасан үгийг дагаж хэлнэ.<br><br>Үйл хөдлөлөөр хийж үзүүлнэ. | Сурагчид:<br>Үйлийг заасан үгийг багш болон бусад сурагчдыг дагаж хэлнэ.<br>Үйл хөдлөлийг дууриан хийнэ.<br><br>Хүүхдээр шороон шуурганы зураг олуулж нэрийг хэлүүлнэ.<br><br>Зурган картаар өгүүлбэр зохиолгон үйл үгийг хэлүүлж үйл хөдлөлөөр хэлүүлнэ.<br><br>Үйлийг заасан үгийг дагаж хэлнэ.<br><br>Үйл хөдлөлөөр хийж үзүүлнэ. | Багш: зурагт тохирох өгүүлбэрийг зохиоход тусална.<br>Цасан шуурга, шороон шурганы ялгааг олоход тусална.<br><br>Зурган карт тараан өгнө.<br><br>Нээлттэй асуулт тавьж хичээлийг төгсгөнө.<br>Шинэ мэдээлэл өгнө.<br><br>/ Шуурга гэж маш хүчтэй салхи гарахыг хэлнэ./ | Зурагт үзүүлэн / цасан шуурга, шороон шуурга/<br><br>Дүрс бичлэг /Цасан болон шороон шуурганы /<br><br>Үйл хөдлөлтэй зурган карт |

Ээлжит хичээлийн үнэлгээ болон дараагийн хичээлд бэлдэж бичсэн багшийн тэмдэглэл

| | |
|---|---|
| Мэдлэг ойлголт:<br>"Шуурга" эхийг уншин утгыг ойлголоо.<br>Үйлийг заасан үгийг таньж ялгалаа.<br>Шуурганы тухай шинэ мэдлэгтэй боллоо.Шуурга болоход өөрийгөө хамгаална, шуурга намдахад тайвширна гэдэг ойлголттой болсон. | Сонирхол хүсэл,эрмэлзэл, хандлага:<br>Бүх сурагчид даалгавраа сайн хийж гүйцэтгэсэн.<br>"Шуурга" тоглоомыг нийт сурагчид идэвхтэй сайн сурч тоглосон, дараагийн хичээлд дахин тоглох болно. |
| Ур чадвар:<br>Эхээс үйлийг заасан үг ялган будаж, тэмдэглэлээ.<br>Бие даан дэвтэртээ цэвэр сайхан бичлээ.<br>Хичээлийн явцад сурагчдын хийсэн даалгаврыг бие биед харуулж амжилттай гүйцэтгэсэнд баяр хүргэнэ./ бие биедээ /<br>Зургийг зөв эвлүүлж, наалаа.<br>Шуурга" гэдэг үгийг зөв хэлэх, Ш- авиаг зөв дуудаж сурсан. | Бодол шийдвэрлэх,илэрхийлэх:<br>Үйлийг заасан үгийг үйл хөдөлгөөнөөр илэрхийлж чадлаа.<br>Багшийн асуултанд хариулахын тулд сайн бодож гэрийнхэнээсээ асууж хариултаа бэлтгэж ирээрэй. |

## 1-6. Е ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 70 ДУГААР ТУСГАЙ СУРГУУЛЬ (9 ДҮГЭЭР АНГИ)

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө – Бодит байдлын судалгааны хүснэгт 2017-2018 оны хичээлийн жил

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Анги | [redacted] анги [redacted] бүлэг | Анги удирдсан багш | [redacted] | Боловсруулсан огноо | [redacted] |
| Овог нэр | [redacted] | Хүйс: | эр | Төрсөн огноо (нас) | 2000 он 04 сар 17 өдө 17 |
| Эцэг эхийн нэр | [redacted] | Гэр бүлийн байдал | Эцэг эх эгчтэйгээ хамт | Нэмэлт мэдээлэл | |
| Гэрийн хаяг | [redacted] | Холбоо барих утас | 1. [redacted] | E-mail | [redacted] |
| Эрүүл мэндийн байгууллагын оноштой эсэх | Тийм ( + ) | Онош тавьсан ЭМ-ийн байгууллагын нэр | ЭХЭМҮТ | Сургуульд элсэн орсон нас | 2012.09.01 |
| Сургуулийн үнэлгээ оношилгоо хийгдсэн эсэх | Тийм (огноо 2008.12.08) (Бэрхшээлийн нэр ТМҮАӨ) ТМҮАӨ | | | | |
| Хавсарсан бэрхшээлтэй эсэх (уналт таталт, зүрхний өвчин, арьсны өвчин г.м) | Тийм<br>( багадаа уналттай байсан ) | Гадаад, дотоодын өөр бусад байгууллагаар үнэлгээ хийлгэж байсан эсэх | Тийм ( + )<br>2017-5-17, СЭМҮТ,<br>F-71 НДХ-ийн дэргэдэх ЭМХМК-ийн шийдвэр | Эрүүл мэндийн байгууллагатай холбоотой байгаа эсэх | Тийм<br>Дауны холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны гишүүн, Монголын Тусгай олимпын хорооны ТУЗ –ийн гишүүн |
| Хүүхдийн байдал (дуртай зүйл, дургүй зүйл г.м ) | 1. Төрсний дараа /0-12 сар хүртэл/ (Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглаж болно)<br>• 1 нас 8 сартайдаа халуураад таталт өгсөн. 9 нас хүртэл таталт өгсөн. Түүнээс хойш таталт өгөөгүй. Түргэн хөдөлгөөнтэй хүүхэд байсан. | | | | |
| | 2. Сургуульд орохоос өмнөх байдал /2-5 нас<br>Цэцэрлэгт явж байсан . (Цэцэрлэгийн нэр: Бичил хорооллын цэцэрлэгт Цэцэрлэгт явахдаа дуртай байсан | | | | |

| | |
|---|---|
| | 3. Сургуульд орсон цагаас эхлэн өнөөг хүртэлх хүүхдийн байдал : Өглөө аав нь хүргэж ирж, өдөр ээж нь авдаг.<br>Сургуульдаа ганцаараа ирж ,очиж чадахгүй.<br>Хөгжлийн айн түвшин 5-аар шалгаж үзэхэд:<br>• Багшийн зурж өгсөн гурвалжин, дөрвөлжин, дугуй, босоо зураасыг дуурайж зурах даалгаврыг тэгш хэм, хэмжээ зэргийг алдаатай ч зурж, дүрсийг нэрлэсэн.<br>• 4-өөс бага үсэгнээс бүтсэн үгийг ойлгох эсэх, үгийг тухайн зүйлтэй тааруулах даалгаварт ном, үзэг, харандаа, баллуур, цай, алчуур, түрийвч, оймс зэрэг үгийн утгыг ойлгож, зориулалтыг хэлсэн.<br>• Бүх үсэг, 0-10 хүртэлх тоог тоолж чаддаг эсэх: ь, ъ, ы –ээс бусад үсгээ уншиж чадна . 1-10 хүртэл тоолж,оноож хэлнэ. 10-аас цааш алдаатай тоолно, 2 оронтой цифр сайн нүдлээгүй, 11,12,13 гээд 22,13 гэх мэт буруу хэлж эхэлдэг.<br>• 1-10 хүртэлх эд юмсыг тоолно.<br>• 5 хүртэлх тооны цифрийг тийм хэмжээний эд зүйлтэй тааруулна.<br>• Урт богино зүйлээс урт, богиныг сонгуулах даалгавар гүйцэтгэнэ.<br>• Юмны шинж чанарыг халуун, хүйтэн, хатуу, зөөлөн, хүнд, хөнгөн, өндөр, нам, урт, богино, их, бага, олон цөөн гэх мэтээр ялгана:<br>• “-ны өмнө”,”-ны ард” гэсэн үгийн утгыг ойлгох: багш ширээ, ном 2-ыг бэлдэж, номыг ширээн дээр ,доор, урд, ард, тавиарай гэсэн даалгаврыг хийлгэхэд дээр доор гэсэн 2 –оос бусдыг буруу хийж гүйцэтгэв.<br>• Асуултад хариулж тухайн зүйлийн талаар тайлбарлах: Үзэг, баллуур,түлхүүр,самбарын алчуурыг бэлдэж, Энэ юу вэ? гэсэн асуултад зөв нэрлэсэн, үзгийг ашиглан юу хийдэг вэ? гэхэд хуванцар, баллуурыг яах гэж хэрэглэдэг вэ? гэхэд резинээр,түлхүүрийг яах гэж юунд хэрэглэдэг вэ? гэхэд төмрөөр, самбарын алчуурыг юунд хэрэглэдэг вэ? гэхэд даавуугаар гэж тухай зүйлийн бүтсэн эдийг нэрлэсэн.<br>• Чи хаана амьдардаг вэ?, Өчигдөр ямар хоол идсэн бэ? гэх мэт асуултад хариулна.<br>• Ямар нэг зүйл хийхдээ зөвшөөрөл авах: Бие засаж болох уу?, Бусдын эд зүйлийг үзэж болох уу? гэх мэт зүйлд зөвшөөрөл авдаг ч тогтмол биш.<br>• Ангийн багшийгаа хааяа багш аа гэхгүй Чанцалдулам аа! гэдэг. Мөн заримдаа чи гэж хэлдэг.<br>• “Май”,”Баярлалаа”,”Уучлаарай” гэх мэт үг хэрэглэх: “май”,”баярлалаа”,”уучлаарай” гэдэг үгийг хэрэглэх дадал бий болсон , хааяа sorry гэж хэлдэг.<br>• Өөрийнхөө биеийн байдлыг илэрхийлэх: өлсөж байна, даарч байна гэж бараг хэлдэггүй, нойр хүрч байна, унтмаар байна, би хичээлээ их хийлээ одоо болно шүү дээ, бие засаад ирье, шүд өвдөж байна гэх мэт хэлдэг.<br>• Хайчаар өнцөг, шулуун шугам, хагас дугуй хүрээг хайчлахдаа хайчлах шугамны хажуугаар хайчилна.<br>• Цаасыг тэгш хэмийг олж дугтуйд хийх:, дугтуйд багтаахын тулд тэгш хэмийг олохгүй олон жижиг нугалж, дугтуйд хийнэ<br>• Өнгө ялгана, 2 оронтой цифрийг заримдаа хойноос нь уншина<br>• Дарааллаар хийж гүйцэтгэх даалгаврыг дунд зэрэг хийдэг,. Жишээ нь: үсэгтэй шоо,амьтны дүрсийг солбиж хэлхэх даалгавар өгөхөд үйлдлийг удаан хийж, багшийн тусламж авдаг. Ийм даалгаврыг 5-6 минут хийгээд сонирхолгүй болдог. |

| | |
|---|---|
| | • Бусдын хийж буй зүйлийг онцгойлж ажиглахгүй, ангиа цэвэрлэх, ширээ сандлаа эмхлэх, самбар арчих гм энгийн зүйлд санаачилгаар оролцдоггүй.<br>• Бусадтай харьцахдаа хязгаарлагдмал, эхний 2-3 цагийн хичээлд оролцохдоо хэвийн,4-7-р цагийн хичээлүүдэд идэвхгүй болж, анхаарал төвлөрөх нь сулардаг, ном болон самбараас бичихдээ мөр алгасдаг, үсэг сольдог, үг орхидог, мөр шугам давуулж бичдэг, үгээ бичихдээ шугамын дундуур болон доогуур бичдэг, “ий” бичихдээ нэг шүдийг орхидог, заримдаа өгүүлбэрийг жижиг үсгээр эхэлж бичдэг,  үгийг тааж уншдаг, үгийн сүүлчийн үеийг тааж уншдаг, өөр утга төсөөтэй үгээр сольж уншдаг,хааяа үсгээ сольж уншдаг, уншсан өгүүлбэрийн утгыг бүрэн гүйцэд тайлбарлахгүй, ганц нэг үгээр хэлдэг.<br>• Өнөөдөр хэдэн сарын хэдэн болох,ямар гариг болохыг мэдэхгүй, он сар өдрийн тухай ойлголтгүй, хэдэн цагийн хичээл орохоо хэлж чадахгүй, хичээлийн хуваариас хичээл орох өдөр, хичээлүүдээ олж мэддэггүй<br>• Хичээл дээр байр сольж суухгүй, ном дэвтрээ гарган зөв суудаг, бүдүүлэг үг хэллэг бараг хэрэглэдэггүй, хааяа хэн нэгэн уурлуулах үед ширээгээ цохидог,багшийн үгэнд дуулгавартай, хэтэрхий их үглэх,олон давтан шаардуулах дургүй,хэрэв  бүдүүлэг үг хэлбэл багшийн шаардсанаар  уучлал гуйдаг. Бусад сурагчийг буруу үг хэллэг хэлэхэд дургүй, тийм тохиолдолд буруу зүйл хийснийг нь хэлэх буруутгах хандлагатай.<br>• Гэртээ ээжийн тусламжтай гурил зуураад элддэг, аяга угаана, хичээлийн хуваариа хараад хичээлээ ялгана.<br>• Морин хуур хөгжимд дуртай, биеийн ерөнхий хөгжил сайн , алхаж гүйж чадна, жудо болон зээрэнцэг түлхэх, усанд сэлэх зэрэг спортоор хичээллэдэг. 2015 онд АНУ-ын Лос-Анжелос хотод болсон тусгай олимпод оролцож, зээрэнцэг түлхэлтээр  хүрэл медаль авсан.<br>• Харин жижиг булчингийн  хөдөлгөөн шаардсан шоо  өрж эвлүүлэх,хэлхэх,товч товчлох,зүү сүвлэх,нугалах, хайчлах, жижиг зайг будах,шугам ашиглах зэрэг жижиг чимхлүүр зүйлд хөгжил муу,тэгш хэмээр нугалахгүй, заасан шугамаар хайчлахгүй,ном уншихдаа үг өгүүлбэрийг оноож заахдаа солих, алгасах, орхих байдал гаргадаг.<br>• Мөнгө ашиглах, мөнгө тоолох, бага зэргийн зүйл худалдан авч чадахгүй |
| Хүүхдийн өөрийн хүсэл | том болоод тамирчин болох, аавынхаа ажлыг хийнэ гэсэн зорилготой |
| Эцэг эхийн хүсэл | өөрийгөө илэрхийлэх,  унших,  бичих, тоо ашиглах,анлиар өөрийгөө танилцуулах, спортоор хичээллэх |
| Багшийн хүсэл | Өөрийгөө илэрхийлж, хэлэх, ярих, өөрийн тухай товч мэдээллийг бичих, уншаад юу гэсэн болохыг мэддэг болох |

## 9-р ангийн сурагч [redacted] ганцаарчилсан сургалтын жилийн төлөвлөгөө

| Анги | [redacted] анги [redacted] | | АУБ | [redacted] | Боловсруулсан огноо | 2017 он 10 сар 20 өдөр |
|---|---|---|---|---|---|---|
| Овог нэр | [redacted] | | Хүйс | эр | Төрсөн огноо | [redacted] |
| Урт хугацааны зорилт | Өөртөө үйлчлэх энгийн чадвар | ширээ сандлыг эмх цэгцтэй байрлуулах, гар угаах, | | | Дэмжлэгийн орчин буюу хэзээ, хаана, ямар үед | Монгол хэл, уран зохиолын хичээл, хичээлээс гадуур ажлын цаг, гэрт |
| | Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | Өөрийгөө танилцуулах, хариулж бичих, өгүүлбэр,үгийн утга зөв ойлгох, бичил эхийг унших | | | | |
| | Нийгэмшихүй | Хичээлийн хуваарийг харж орох хичээлээ хэлж чаддаг болох, он сар өдөр гариг хэлж сурах | | | | |
| | Хөдөлгөөн | Товчлох, жижиг зүйлийг хэлхэх, цаас нугалах,будах | | | | |

| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | Улирлын зорилт | Хичээлийн агуулга | Багшийн дэмжлэг, арга зүй /дэлгэрэнгүй/ | Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн орчинд | Гэрийн нөхцөлд | Боловсруулсан багш |
| **Сургуулийн амьдрал хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар /судлагдахууныг оруулахгүй/** | Мэндэлж сурах | 1.Өглөө, өдөр, хичээл тарах үеийн мэндчилгээ | 1.Багш,өглөө бүр сурагчидтай Өглөөний мэнд, сайхан амарсан уу? сайхан амраарай, замаар болгоомжтой гараарай гэсэн үгийг хэлж харилцах, багш болон ангийн хүүхдүүдтэй харилцааны ойрын болон дундын бүсээс харилцах, хариуг зөв хэлүүлэх,сонсох,хариу хэлэх, бурууг засах, магтах урамшуулах үйл ажиллагааг өдөр тутам хэрэглэх, Цаг агаар ямар байгааг асуух, дулаан | 1.Сайхан амарсан. Өглөөний мэнд. Аав, ээж (тэй, тай) ирсэн бэ? Гадаа цаг агаар ямар байна, Өглөөний цайгаа уусан уу? Гэрийн даалгавраа хийсэн үү? гэсэн асуултанд хариулах, ангийн бусад сурагчидтай мэндлэх, ярилцах үед багш болон сурагчдад анхаарал хандуулах, хариуг хүлээж, зөв хариулахад багш дэмжлэг | Гэрийнхээ хоолны ширээг цэвэрлэх, аяга тавгаа ширээн дээр өрөх, аяга таваг угаах, сэрээ савх зэргийг тоолон хураах, номын сангийн ном, шүүгээн дэх хувцсаа эвхэх, цамц эвхэж сурах, жижиг зүйл хэлхүүлэх, гэр бүлээрээ сайхан хоолоорой, сайхан амарсан уу? Баяртай, өдрийн мэнд, оройн мэнд гэсэн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хувцас өмссөн эсэхийг асуух,хэнтэй ирсэн, өдөр хэн авах вэ? гэдгийг асууж хариултад дүгнэлт хийнэ | өгөх,урамшуулах, гадуур хувцсыг нь өлгүүлэх, буруу бол багш хамтран зөв өлгөх | үгийг хэлүүлж сургах, өнөөдөр хэдэн бэ?, маргааш хэдэн бэ?, маргааш ямар гариг вэ? цаг хэд болж байгааг хэлэх, цаг сурах, мөнгөн дэвсгэрт нэрлэх, ялгах, 1000 төгрөгөөр хэрэгтэй зүйлээ авахад сургах, дэлгүүрийн барааны үнийг хэлүүлэх | |
| | Хичээлийн хуваарь харж сурах | 2.Ангийн булангийн хичээлийн хуваарийг харж, өдөр, хичээлийн цаг зэргийг хэлэх | 2. Ангийн буланд хичээлийн хуваарь, он сар өдөр, гариг бичиж бэлдсэн байна. Өглөө бүр аглөөний мэндийн дараа ангийн буланг ажиглуулна. Сурагчийн ажиглаад хэлэхэд зориулж,он сар,ангийн хичээлийн хуваарийг өнгө ялган харахад тодорхой болгож бэлдсэн байна Сурагчийн тухайн өдрийн хэрэгтэй зүйлээ олуулж, сургахдаа эхний үйлдлийг сургасны дараа дараагийн Б,В.Г дэх үйл ажиллагаанд шилжинэ. Багшийн асуулт: А. өнөөдөр хэдэн бэ? Б.өнөөдөр хэддэх өдөр , ямар гариг вэ? В.хэдэн цагийн хичээл орох вэ? | 2. Өдөр тутам хичээлийн эхэнд ангийн буланг ажиглана А.Өнөөдөр хэдэн сарын хэдэн болохыг олно. Багш аа, өнөөдөр .. сарын.. байна. гэж олоод хэлж сурна. Эхний даалгаврыг гүйцэтгэж чаддаг болсны дараа Б,В,Г даалгаварт шилжинэ. Хариулж чаддаг болох өгүүлбэрүүд: Б.Өнөөдөр .... өдөр. ..... гариг . В. Өнөөдөр .... цагийн хичээл орно Г. эхний цаг ... хичээл орно Дараагийн цаг .... хичээлтэй. Одоо .... хичээлрүү очно гэдгийг хараад хэлж сурна | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Г. -эхний цаг ямар хичээл орох вэ гэсэн асуултын дагуу ангийн булан дээр ажиллаж сургах, олуулах -хэлүүлж сургах, мөн хичээл эхлэхэд самбарын он сарыг уншуулах, өнөөдөр хэдэн бэ? өчигдөр хэдэн байсан бэ? маргааш хэдэн болох вэ? өнөөдөр хэддэх өдөр билээ? гэсэн асуултаар хичээл эхлэх, завсарлахад одоо ямар хичээл рүү очих вэ? дараа нь ямар ямар хичээл орох вэ? гэж асуугаад хариултыг авч дүгнэлт хийж дараагийн үйл ажиллагаанд шилжих болсон эсэхийг тодорхойлно. | | | |
| | Эмх цэгцтэй сурах | 3.Ангийн эмх цэгцийг ажиглуулж сургах, эмхлэх цэгцлэх | 3. Том жижиг эд зүйл ( ном) зөв өрж сурах, шүүгээнд байрлуулж чаддаг болгох даалгавар. А. Даваа, Мягмар, Лхагва гаригийн өглөө бүр багш урьдчилан ширээн дээр том жижиг олон янзын ном гаргаж тавьсан байна. | 3. Том жижиг эд зүйл ( ном) зөв өрж сурах, шүүгээнд байрлуулах А. Даваа, Мягмар, Лхагва гаригийн өглөө ширээн дээр байгаа том жижиг номуудыг эмхлэн хурааж , номын шүүгээнд хийнэ. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Б. Багш урьдчилан сандал ширээг байрнаас нь хөдөлгөсөн байна. Мөн ширээ болон сандлын тавих хэмжээг заасан зураасыг шалан дээр наасан байна. [redacted] бусадтай хамтран эсвэл ганцаараа ширээ сандлыг эгнээгээр байрлуулах,ширээ болон сандлыг нэг шугамд байгаа эсэхийг ажиглуулж, хамтран эсвэл бие даалган хийлгэх, зөв гүйцэтгэл бүрд урамшуулах | Номын нэр, толгой хэсгийг зөв харуулан номын санд хийнэ. [redacted] ширээ , сандлыг зураасын дагуу бусадтай хамтран эсвэл ганцаараа эгнээнд байрлуулна, Нэг шугамд байгаа эсэхийг ажиглана, зөв буруу өөрөө ажиглана,зөв байрлуулна. | | |

| Дэмжлэгийн орчин буюу хэзээ хаана, ямар үед | | Улирлын зорилт (Богино хугацааны зорилт) | Хичээлийн агуулга | Багшийн дэмжлэг, арга зүй / дэлгэрэнгүй/ | Арга зүйн чиглэл, үнэлгээ, засан сайжруулах цаашид анхаарах зүйл | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургуулийн орчинд | Гэрийн нөхцөлд | Боловсруулсан багш |
| Судлагдахуунаар | монгол хэл | Богино хугацааны зорилт: Харилцан яриа, хэрэгтэй зүйлийг бичих | **1.Харилцан ярих өгүүлбэр нь:**<br><br>2. Бичиж сурах хэрэгтэй үг, өгүүлбэр | 1.Хүнтэй болон багштай ярихын өмнө ярилцагч хүнийхээ нүд рүү хараад, тайван байдалтай зогсох дасгал хийх, Харилцагч хүнийхээ асуултыг анхааралтай сонсож сургах, бусад руу тогтуун харах, үг, өгүүлбэрийг зөв тод хэлүүлэх, өгүүлбэрийг зөв ойлгон, яарч сандрахгүй тайван хариу хэлүүлэх дасгал бэлдэх байдлыг зааж сургах<br>**<u>Багшийн асуух өгүүлбэр нь:</u>**<br>Чамайг хэний хэн гэдэг вэ? Чи хэдэн онд төрсөн бэ?<br>Хэддүгээр ангид сурдаг вэ? Гэрийн хаягаа хэлээрэй.<br>Чөлөөт цагаараа юу хийх дуртай вэ?<br>***Бичүүлж сургах өгүүлбэр нь:***<br>Намайг [redacted] гэдэг.<br>Би [redacted] төрсөн.<br>гэрийн хаяг:Эмнэлэг Цайны газар Автобусны буудал Орох Гарах Дэлгүүр 101,102,103, 108 Цагдаа Туслаарай Хүйс<br>РД [redacted] байна Би хоол идмээр байна Улаанбаатар хот, Мах, Сүү, Анги, Өндөг, Эмийн сан, Халуун цай уумаар байна Би чадахгүй байна. Намайг гэрт хүргэж өгнө үү? Халуун байна, Гэрийн түлхүүр, Баяр хүргэе, Эрэгтэй хүн, Эмэгтэй хүн, Монгол улс, Даарч байна, Шүд өвдөж байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **<u>Хичээлийн үе дэх багшийн ажиллах аргазүй</u>**<br>*өдөр тутам явцын үнэлгээ хийнэ.<br>*цөөн минутын чээж бичиг хийлгэнэ. алдаагаа өөрөөр нь олуулж сургана. харьцуулах<br>*бичил эхийг уншуулна.<br>*уншсан үг, өгүүлбэрийн утгыг яриулна.<br>*бичил өгүүлбэр  хуулуулна, сонсголоор бичүүлнэ.<br>*доогуур зурсан болон онцолсон үгийг бичүүлнэ,<br>*урт эгшигтэй үг олуулж,доогуур нь зуруулна.<br>*доогуур зурсан үгээ түүж бичүүлнэ.<br>*3 ба 4 үсэгтэй үгийг олж доогуур нь зуруулна.<br>*цэгийн оронд үсэг нөхөж бичүүлнэ.<br>*үгийн үсгийг тоолуулж тоог бичүүлнэ. зуруулна.<br>*цэгийн оронд үсэг нөхөж бичүүлнэ.<br>*үгийн үсгийг тоолуулж тоог бичүүлнэ.<br>*дармалаас хуулж бичүүлнэ.<br>*зураг хараад юу байгааг хэлүүлнэ.<br>*зураг дээрхийг юунд хэрэглэдэг болохыг хэлүүлнэ.<br>*хүрээнд багшийн зааснаар жигд будуулна.<br>*өнгөө өөрөөр нь сонгуулж будуулна.<br>*хайч хэрэглэж сургах<br>*шугам барьж сургана, шугамдуулна.<br>* шугамын дагуу хайчлуулна. | | 1.эцэг эх нь юу хэрэгтэй байгаа, юу таалагдахгүй байгаа, Яагаад?, Чи юу хүсэж байна,юу хэрэгтэй байна,...зүйлээс алийг нь авмаар байна гэх зэрэг сэдвээрр тогтмол харилцан ярих, хариултыг нь тэмдэглэх, багштай хамтран сурагчийн ахицыг үнэлэх, дараагийн үйл ажиллагааг төлөвлөхөд хэрэглэх,багшийн зөвлөснөөр асуулт тавьж бүтэн хариулт авах.<br>Багшийн өгсөн асуух өгүүлбэр, унших,бичих үг, өгүүлбэр, зурах, будах, ялгах, хайчлах, нугалах, шугамдах даалгаврыг хийнэ. | |

## Монгол хэлний хичээлийн агуулга

2018 оны 3 сар 15 өдөр 3 цаг Боловсруулсан [redacted]

Эрэгтэй 6 хүүхэд, эмэгтэй 2 хүүхэд, нийт 8 хүүхэд

1. Ерөнхий агуулга бүлэг сэдвийн нэр: Байгаль нийгэм 14цаг
2. Нэгж хичээл: "Би монгол хүн"шүлэг Ээлжит хичээл: Ч.Чимэд "Би монгол хүн" шүлэг 1-р хэсэг
3. Нэгж хичээлийн төлөвлөгөө нийт цаг : 74цаг "Би монгол хүн" шүлэг 3 цаг
4. Хичээлийн агуулга

4-1. Үндсэн зорилго

| групп | Ээлжит хичээлийн зорилго |
|---|---|
| Хөнгөн хүүхэд 5 | 1.Ухааран уншиж, сонсоно. 2. Монгол ахуйтай танилцана. 3.Боргилсон,манан,өршөөлт ээж, элэг зүрх минь догдлох гэсэн үгийн утгыг мэднэ. |
| Хүндэвтэр хүүхэд 3 | |

4-2. Ээлжит хичээлийн хөтөлбөр /Явц/

| Цаг төлөвлөлт | Хөнгөн хэлбэрийн Сурагчийн үйл ажиллагаа/ | Хүндэвтэр хүүхдийн / ажиллагаа/ | Багшийн үйл ажиллагаа /хичээлийн явцад анхаарах зүйл/ | Бэлдэх зүйл /Сургалтын хэрэглэгдэхүүн,тарааж өгөх материал/ |
|---|---|---|---|---|
| Эхлэл | 1. [redacted] он сар өдрийг бүтээнэ.<br>2. Сурагчид гэрийн даалгавар сэргээн санах | | 1. Сар өдрийг [redacted] асууна, [redacted] бүтээлгэнэ. ...сарын.. гэсэн үгийн үгийн цэгийн оронд самбарын доорх 1-10 хүртэлх цифрээс сонгон нөхөх, 1 ба 5 –ын цифр ашиглан 15 гэсэн өдрийг бүтээх , багш дэмжлэг өгөх<br>2. Гэрийн даалгавар сэргээн санах. Гэрийн даалгаварт өгсөн “Би хаана төрөө вэ?” шүлгийн 1-р бадгийг багш дагуулан хамтран унших, [redacted] дэмжлэг үзүүлэн ганцаарчлан уншуулах | Самбарт ....сарын гэсэн үг, самбарын доор 1-10 ын цифр наасан байна. |

| | | | |
|---|---|---|---|
| сэдэлжүүлэлт | 1. 2 минут 15 секунд уртын дууны аялгуу клип үзүүлж, сонсоно<br>2. Бичлэг сонсоно | 2 минут 15 секунд уртын дууны клип үзүүлнэ. Бичлэгийн өмнө анхааруулах чиглүүлэг нь: дууны ая, дүрслэлийг сайн анхаарч сонсох: Бичлэг үзээд ямар сэтгэгдэл төрөв,юу үзэж харж, сонсов гэдэг асуултаар бүх хүүхдээс асууж багш нэгтгэн өнөөдрийн хичээлийн сэдвийг товч гаргана. Хичээлийн сэдэв Ч.Чимэд Би монгол хүн шүлэг үзнэ гээд самбарт гарчиг бичнэ. Монголын орчин үеийн уран зохиолын нэрт төлөөлөгч гэдгийг хэлнэ.<br>Бид одоо нэг уран уншлагын бичлэг сонсоно. гээд нэртэй уран уншигч жүжигчин уншсан гэдгийг хэлэх, бичлэг сонсохдоо анхаарлаа төвлөрүүлэх, эмх цэгцтэй, чимээгүй сууж бичлэгт юуны тухай өгүүлж байгаа болон ямар утгатай, ямар үг хэллэгтэй болохыг сайн анхаараарай гэсэн чиглүүлэг өгнө. | Монгол ардын уртын дууны гурван минутын клип<br>30 секундын уран уншлагын бичлэг. |
| өрнөл хэсэг | 1. Зорилгыг самбараас харж унших,тайлбарыг сонсох, зорилгоо ойлгох<br>2. Хэвлэсэн шүлгээ хараны уншлагаар унших | Бичлэг сонссоны дараа хичээлийн зорилгыг багш уншиж, хамтран унших, ямар зорилго тавьсан болох, өнөөдөр юу юу мэдэх зорилго тавьсныг тайлбарлаад ширээний баруун гар талдаа байгаа цаасыг эргүүлэн харна уу ? хараны уншлагаар уншаад саяын сонссон шүлэг мөн үү? гэдгийг сурагчдаар хэлүүлнэ. [redacted] унших дэмжлэг өгнө.<br>Багш сурагчдаас : Шүлгээ илүү сайн ойлгосон эсэхийг асууж ярилцана | Самбарын зүүн дээд өнцөгт хичээлийн зорилгыг наана.<br>Сурагчийн ширээн дээр баруун гар талд нь шүлгийн эхний 16 мөрийг хэвлэн тавьсан байна |
| | Багшийн уншихыг сонсохдоо хэвлэмэл эхтэй тулган харнаа. | Бичмэл үзүүлэнг харуулж, ямар бичлэгээр бичсэн байгааг асуух, ширээ бүрд өгөх,хичээнгүй бичгийн тухай тайлбарлана. Ажиллах чиглүүлэг: Энэ бичмэл шүлэг өнөөдрийн үзсэн шүлгийн аль хэсэг байна, олоод самбарт дараалллаар нь наана. Хэрэв олж чадахгүй бол ширээн дээрх дармал шүлгээсээ тохируулан харж олоорой дараа нь дарааллаар самбарт наана.гэж хэлнэ. Самбарт дарааллын дагуу наалгаад самбараас багшийн уншилтыг анхаарч сонсоно. | самбарын бичмэл үзүүлэн, ширээн дээрх шүлэг |

| | | | |
|---|---|---|---|
| | Шинэ үгийг сонсох, самбараас харах | Ойлгохгүй шинэ үгийг асууж, төлөвлөсөн 4 шинэ үгийг самбарт наана. Шинэ үгээ уншуулна. Самбарт шинэ үгээ наана. Боргилсон, манан, өршөөлт ээж, элэг зүрх минь догдолж гэсэн үгүүдийн утгыг тайлбарлах, шүлгийн хаана байгааг асуун боргилсон гэдэг үгийг тайлбарлахдаа аргалын тухай ойлголт өгч, утаа гарган тайлбар хийнэ. Манан, өршөөлт ээж, элэг зүрх догдлох гэсэн үйиг тус бүрд нь тайлбарлах, мананг байгалийн өвөрмөц үзэгдэл, манан гарахаар сайн хараарай, өршөөлт ээжийг тайлбарлахдаа ээжийг ямар ээж гэж хэлдэг тухай ачлалт ээж, өрлөг ээж, сайхан ээж гэх мэт холбоо үгүүдийг сурагчдаар хэлүүлэх, элэг зүрх минь догдлох гэсэн үгийн шилжсэн утгыг тайлбарлаж ойлгуулна. Шинэ үгийн тайлбар хийхдээ сурагчдаар яриулах, сонсох зөв болгон залруулахад анхаарна. | Самбарт 4 шинэ үг |
| | Дэвтэрт он сар, гарчиг бичнэ. Самбараас нуусан үгийг олно. Сагсны хэрчмэл үгээс сонгох, зөв гэж үзсэн үгээ өргөж харуулна. | Сурагчдад он сар гарчиг бичих, сагсанд байгаа 4 үгийг гаргах, унших , түүнээс харж шинэ үгээ дэвтэрт бичих, [redacted] шинэ үгийг дэвтэртээ хүснэгтэд тохируулж наах чиглүүлэг өгнө. Багшийн дэмжлэгээр [redacted] хамтран наах.Сурагчдыг бичиж байх зуур багш самбарт байгаа шинэ үгээ авч,бичмэл үзүүлэн дэх шинэ үгийг цаасаар нууна. Сурагчдыг бичиж дууссаны дараа хуулсан үгээ доош нь харуулж тавих зааврыг өгнө. Самбарын үзүүлэн рүү харуулаад юу өөрчлөгдсөнийг асууж, нуусан үгийг хэлүүлэх, доош нь харуулсан үгээ ашиглаж болохыг анхааруулна. Үг бүрийг олуулж, дээш өргөн зөв эсэхийг самбарын нуусан цаасаа хуулж тохируулна. | сагсанд шинэ үгийг бичсэн хэрчмэл үзүүлэн |

| | | | |
|---|---|---|---|
| Бататгал хэсэг | Багштай хамт унших, багшийн тайлбарыг сонсоно. 1-р хэсгийг [redacted], 2-р хэсгийг [redacted], 3-р хэсгийг [redacted], 4-р хэсгийг [redacted] уншина | a. Багш сурагчдыг дагуулан уншуулах<br>b. Тайлбарт уншлага хийх, мөр бүрийг утгачлан тайлбар өгнө. Энэ шүлэгт юу өгүүлснийг нэгтгэн тайлбарлана..<br>c. Ганцаарчилсан уншлага 1-р хэсгийг [redacted], 2-р хэсгийг [redacted], 3-р хэсгийг [redacted], 4-р хэсгийг [redacted] нараар уншуулна. | Самбарын бичмэл үзүүлэн |
| | сагсан дахь дүрсийг эвлүүлэн шар цаасан дээр босоогоор нааж, нэрээ бичин самбарт наана. | Ширээн дээрх шар цаасан дээр дүрс эвлүүлээд наах, нэрээ бичих чиглэл өгөх: Цаасны босоо байрлалд дүрсээ бүтээгээд доор нь нэрээ бичээд самбарт наах, юу бүтээв, өнөөдрийн хичээлтэй юугаараа холбоотой байгааг олж тайлбарлуулна. Гэр гэсэн хэсэг хаана байгааг шүлгээс олуулах, ямар гэрт төрсөн гэж байна, зуны амралтаар хөдөө явахдаа гэр барихыг сайн хараарай | Сагсанд хийсэн эвлүүлэх гэрийн дүрс, наах цаас, цавуу, үзэг |
| Дүгнэлт | Өнөөдрийн хичээлээр юу үзэж мэдэв, юу сонсов, ямар шинэ үгтэй танилцав гэдийг яриулах, хамтран бүтээсэн зүйл юу байв гэдгийг дүгнэх. Зорилгоо асууж, нэгтгэн дүгнэнэ. Ойлгоогүй зүйл байгаа эсэхийг асууж ,сурагч бүрийн оролцоог үнэлсэн үнэлгээ хийнэ.Урамшуулах үнэлгээг үе шат бүхэнд хийнэ. | | |
| Гэрийн даалгавар | Шүлгээ эцэг эхтэйгээ хамтран уран унших дасгал хийгээрэй, Хичээнгүй сайхан бичиж ирээрэй гэсэн даалгавар өгнө. | | |

# 2

# ТУРШИЛТЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЕРДИЙН СУРГУУЛИЙН ЖИШЭЭ

2017-2018 оны хичээлийн жилд туршилтын ерөнхий боловсролын сургуулиуд дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. Төслийн зүгээс эдгээр үйл ажиллагааны үр дүнг жишээ болгон сургууль тус бүрээр нь танилцуулж байна.





## 2-1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 16 ДУГААР СУРГУУЛЬ

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | 1-12 дугаар ангийн 13 суралцагч |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Сургуулийн орчинд тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдад тохирсон “Хүүхэд хөгжлийн өрөө” тохижуулахаар шийдвэрлэн төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2017 оны хичээлийн жилийн 2-р улиралд багтаан тохижуулж дуусгалаа . |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Ширээ<br>Сандал<br>Буйдан<br>Тавиур<br>Хүүхдэд зориулсан ширээ,сандал<br>Агаар чийгшүүлэгч<br>Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл<br>Хөлтэй самбар<br>Зураг болон бичгийн хэрэгсэл<br>Хувцасны тавиур |









| | |
|---|---|
|   |  |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” |   <br>Манай сургуульд "Хүүхэд хөгжлийн өрөө"-тэй болсноор<br>1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжих,суралцах таатай орчин бүрдсэн.<br>2. Дэмжлэг шаардлагатай сурагчдийн анги удирдсан багш нар хүүхэд хөгжлийн өрөөнд мэргэжлийн багш, тусгай хэрэгцээт мэргэжлээр сурч буй оюутан нартай хамтран сургалт үйл ажиллагаа явуулснаар сурлагын ахиц тод харагдаж байна.<br>3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах хандлага нь нийт багш, сурагчид эцэг эхчүүдэд эерэг болсон. Боломжоороо тусалдаг болсон.<br>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдрүү чиглэсэн үйл ажиллагаа маш их нэмэгдсэн. |
| Цаашид хэлэлцэх асуудал | • Хүүхдийн чадварыг одоо байгаа түвшнээс ахиулах<br>• Эцэг эхийн зүгээс оролцоо тусламжийг нэмэгдүүлэх<br>• Анги удирдсан багшийн анхаарал, дэмжлэгийг нэмэгдүүлэх |

## 2-2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 35 ДУГААР СУРГУУЛЬ

<table>
<tr><td>Сонгосон хүүхэд</td><td>5-р анги эрэгтэй хүүхэд</td></tr>
<tr><td>Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/</td><td>Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх. Үүнд:<br>1. Орчин бүрдүүлсэн.<br>2. Хичээл тарсны дараа гэрийн даалгавар хийлгэн, давтлага явуулж байгаа.<br>3. Тусгай мэргэжлийн багш нар болон сайн дурын оюутнуудтай хамтран ажиллаж байна.<br>4. Төслийн багийн боловсруулсан шалгах хуудас дээр хамтран ажилласан.</td></tr>
<tr><td>Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн</td><td>Зурган карт, эвлүүлдэг хэрэглэгдэхүүн, жижиг самбар, сурагчийн ширээ сандал, том үсгийн ном. Тухайн хэрэглэгдэхүүн нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа.</td></tr>
<tr><td colspan="2">







</td></tr>
<tr><td>Үр дүн “Хүүхдийн байр байдал”</td><td>Өөртөө итгэлтэй болсон,эцэг эхтэй хамтран ажиллах бэрхшээл багассан.Хүүхдүүд залхуурахгүй суралцах сонирхол нэмэгдсэн.<br> </td></tr>
</table>

## 2-3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 28 ДУГААР СУРГУУЛЬ

| Сонгосон хүүхэд | [redacted] |
|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | **Хэл засалч багштай хамтарч ажиллах:** 70-р сургуулийн хэл засалч багш нартай 1 сар хамтарч ажилласан.<br>**Оношилгоо хийх:** Суралцахуйн оношилгоог МУБИС-н тусгай тусгай хэрэгцээт боловсролын багшийн /цаашид ТХББ/ ангийн багш оюутан нартай хамтарч авч ганцаарчилсан төлөвлөгөөг гаргаж ажиллаж байгаад хүүхдийнхээ чадвараас хамаарч дахин хөтөлбөр хийсэн. Оношилгоогоор хүүхэд нь улаан шар 2 өнгө мэддэг, тоо мэдэхгүй, орон зайн баримжаа муу, дүрс мэдэхгүй, анхаарал тогтворгүй байсан. Оношилгооноос үүдэн ганцаарчилсан хөтөлбөр боловсруулж ажиллаад явцын дунд дахин өөрчилж 1 сэдвийг 2-3 цаг үзэх шаардлага гарсан.<br>**Хөтөлбөр арга зүйн зөвлөмж авах:** МУБИС-н тусгай хэрэгцээт боловсролын багшийн ангийн багш оюутан нартай хамтарч авч ганцаарчилсан төлөвлөгөөг гаргаж хүүхдийн суралцах үйлд дор бүр нь дүгнэлт гарган дараагийн хичээлд юуг анхаарах талаар ярилцаж хичээлээ бэлдэж шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллалаа.<br>**Хүүхэд хөгжлийн төв байгуулах:** Тус төв нь Япон улсын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл ”-н хүрээнд нээгдсэн төв юм.<br>Төв нээгдсэн үеэсээ тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай 2 хүүхдэд МУБИС-ийн 2 оюутан, 70-р сургуулийн хэл заслын багш нартай хамтран дэмжих сургалтыг зохион байгуулж явууллаа. Тохируулгат орчинг бүрдүүлж, ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу гарын авлага боловсруулж сургалтандаа хэрэглэж байна.<br>Хүүхдийн хичээлд шаардлагатай бүх хэрэглэгдэхүүнийг төвдөө хэвлэж гаргаж байсан нь маш их ажлыг хөнгөвчлөхийн зэрэгцээ багш сурагчтай ажиллах цаг их гарч байлаа. Тусгайгийн оюутан багш нарын хүүхэдтэй ажиллах арга зүйд маш их ач тусаа өгсөн ажил болсон. Хүүхэд хөгжлийн төвд хүүхдийн гарын жижиг булчинг сайжруулах дасгал, биеийн тамрын хөдөлгөөнт дасгал, өнгө, тоо, хайч зөв барих дадлага, зурах бичих дадлага, дуу заах зэрэг нийгэм ахуйн баримжаа олгох хичээл болон стандарт хичээлийн хөтөлбөр дагуу сургалтыг явууллаа.<br>Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг багш сурагчдад таниулах сурталчилах зорилгоор БГД-ийн багш нарт сургалт явууллаа. Хөвсгөл аймаг болон Багануур дүүргийн багш нарт төслийн хүрээнд нээгдсэн хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг танилцуулж туршлага солилцов. Төвийг хариуцаж ажиллаж байгаа багшийн хувьд сургалтад хамрагдаж өөрийгөө хөгжүүлж байна. |

<table>
<tr><td>Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн</td><td>Өнгөт принтер<br>сурагч ширээ сандал<br>Ламинатор<br>Эсгий бал<br>Өнгийн цаас<br>Эвлүүлдэг тоглоом</td><td>Бичгийн цаас<br>Өнгийн харандаа<br>Буддаг ном<br>Цавуу<br>Скоч<br>Хайч</td><td>Сурах бичиг бөмбөг<br>Шатар эвлүүлдэг<br>Гудас<br>Компьютер багшийн ном</td></tr>
<tr><td>Үр дүн “Хүүхдийн байр байдал”</td><td colspan="3">- Өнгө ялган будах нь сайжирсан. Улаан, ногоон, цэнхэр, хар, цагаан, бор, шар өнгийг ялгаж таньдаг болсон.<br>-- дүрсийг ялган таниж хэлдэг болсон. Дүрсийг ялгаж байгаа ч хэлж чадахгүй байна. Дугуй зурлагыг бичихдээ /дарж бичих, хэв тавиж бичүүлэх, зөв хэсгийг олж дугуйлах / өмнөх байдлаас эрс сайжирсан.<br>- Багш зурлагыг дэвтэрт дарж бичихгүйгээр заавар өгч улаан балаар 2,3 удаа бичиж өгөөд цааш үргэлжлүүлж өөрөө бичих даалгавар өгөхөд мөр хоорондын зайг харгалзахгүй бичдэг байсан бол одоо орон зайн баримжаа сайжирч харалдаа зай орхин сайн бичиж байна. Зурлагыг дарж бичихдээ гар нь зүгширсэн./шулуун зураас/<br>- 1,2 –н тоог зөв нэрлэж бичиж сурсан.<br>- Том жижиг, урт богино, өндөр нам гэсэн ойлголттой болсон.<br>- Хайч зөв барьж зураасын дагуу хайчлах нь сайжирсан.<br>- Тогтвортой суух хугацаа нэмэгдсэн.<br>- Хичээл хийх гэсэн хүсэлтэй, шаардуулахгүй хийх болсон.</td></tr>
<tr><td>Цаашид хэлэлцэх асуудал</td><td colspan="3">Цагаар тогтмол ажиллах Хэл заслын багшийн дэмжлэг нэн чухал байна.<br>Цаашид оюутан багштай үргэлжлүүлэн ажиллах хүсэлтэй байна.</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
|  |  |  |
| Хүүхэд хөгжлийн төв: Өмнө | Хүүхэд хөгжлийн төв: Дараа | Хүүхэд хөгжлийн төв дэх хэрэглэгдэхүүн |

| | | |
|---|---|---|
|  |  |  |
| Хүүхэд хөгжлийн төвийн өнөөгийн байдал | Хүүхэд хөгжлийн төвийн өнөөгийн байдал | Хүүхэд хөгжлийн төвийн өнөөгийн байдал |
|  |  |  |
| Хэрэглэгдэхүүн | Хичээлийн үед | Хичээлийн үед |

## 2-4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 113 ДУГААР СУРГУУЛЬ

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | 5 анги эмэгтэй сурагч<br>4 анги эрэгтэй сурагч |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Биеийн жин өндөрт тохирсон хана, шатны бариулыг 8м урттай 8ширхэгийг хийсэн.<br>Бүх анги танхим, цайны газар, ариун цэврийн өрөөнүүд, номын сан, урлаг зал, биеийн тамирын заал болон бусад өрөөнүүдэд 48 ширхэг хаяг хийсэн. |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Тусгай хэрэгцээт боловсролын математик, монгол хэлний сурах бичиг, буддаг ном, карт, зурагтай ном, гарын доорх материалаар бүтээл хийлгэх ажлуудыг хийсэн. |
|  |   |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Биеийн тамирын хичээлд тохирсон хэрэглэгдэхүүн дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулснаар хөдөлгөөн сайжирсан. Ганцаарчилсэн төлөвлөгөөг [redacted] ангийн сурагч [redacted] тохируулан боловсруулж, судалгаат хичээлийг үе шаттай хийснээр сурагч өнгө ялгаж таньдаг, ярианы чадвар сайжирч бусад сурагчидтай хамтарч ажиллахад ахиц гарсан. |
| Цаашид хэлэлцэх асуудал | 1. Зориулалтын сурах бичгээр хангуулах<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багшид БСШУСЯ-наас нэмэгдэл хөлс өгөх эрх зүйн баримт бичиг гаргуулах<br>Тусгай кабинеттай болох |

## 2-5. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 26 ДУГААР СУРГУУЛЬ

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | • Дэмжлэгт анги<br>Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр суралцаж буй 2а ангийн сурагч [redacted] |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал” | “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд тус сургуульд сургалтын тохируулгат орчин бүрдүүлж ажиллалаа. Үүнд:<br>• Сургуулийн гадна талбайн зам засах<br>• Сургуулийн үүдэнд налуу зам хийх<br>• Коридорт бариул хийх<br>• Ариун цэврийн өрөөнд угаалтуур, суултуур хийх<br>• Дэмжлэгт ангийн шалны хулдаас солих<br>• Анги танхимыг бэлтгэх<br>Тус хөтөлбөрийн хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилд дараах ажлуудыг зохион явууллаа.<br>• 2018 оны 2-р сарын 01-ний өдрөөс эхлэн тус сургууль дээр хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг тэгш хамруулан сургах зорилготойгоор “Дэмжлэгт бүлэг” нээгдэн сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн явуулж ажиллахад сургуулийн захиргаа удирдлага, арга зүйгээр ханган сургалтын тохируулгат орчин бүрдүүлж, хамтран ажиллалаа. Тус бүлэг нээгдсэнээр Улаанбаатар хотоос алслагдсан захын хорооны тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай сурагчдыг тэгш хамран сургах нөхцөл боломжоор хангасан эцэг эхчүүд болон сурагчдын сэтгэл зүйд эерэгээр нөлөөлсөн, хандлагыг өөрчилсөн үр дүнтэй ажил болсон нь тус хорооны Иргэдийн Нийтийн Хурал болон 13-р хорооны Ажлын албанд үнэлэгдэн “Хүүхдэд ээлтэй шилдэг хамт олон” байгууллагаар шалгарсан. Энэхүү амжилт нь “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” –ийн баг, БСШУСЯ, 63-р сургуулийн хамт олны дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагааны үр дүн гэж дүгнэж байна.<br>• Тус сургуулийн төслийн багийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчилж, 2017-2018 оны хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөө болон тохируулгат орчинг хэрхэн бүрдүүлэх талаар төсөл хэлэлцэж ажлын хэсгийн анхын хуралдааныг хийв.<br>• Энэ хичээлийн жилийн хугацаанд Жайка төслийн багийн гишүүд нэгж дээр 5-6 удаа ирж ажил хэргийн уулзалт болон сургалт зөвлөгөөнийг хийж, багш, удирдлагуудыг аргазүйгээр хангаан чиглүүлж ажилласан.<br>• 63-р сургуулийн сургалтын менежер н.Мөнхцэцэг, холбогдох багш нарт “Сургалтын тохируулгат орчны бүрдүүлэлт”, “Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй”, “Зан төлөвийн өөрчлөлттэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, Токио Гакугэй Их Сургуулийн багш Оотомо Киёоши оюуны бэрхшээл, аутизмын хүрээний эмгэг, анхаарал төвлөрөл, хэт хөдөлгөөний эмгэг, суралцах бэрхшээлийн талаар тус тус сургалт явууллаа. |

| | |
|---|---|
| | • Багш А.Эрдэнэтуяа нь ангийн сурагчид [redacted] /аутизм оноштой/ зориулан ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2 жилийн туршид хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд сургалтын хөтөлбөрийг засан сайжруулж боловсруулахад төслийн багийн хамт олон арга зүйн дэмжлэг үзүүлж засан сайжруулсаар ирлээ.<br>• Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээл явуулдаг А.Эрдэнэтуяа багшийн хичээлд Японы Их Сургуулийн багш Нэмүто сууж зөвлөгөө өгсөн ба багшийн сургах арга зүй, анги зохион байгуулалт, ялангуяа сонгогдсон хүүхэд маань багш, сурагчийн дэмжлэгтэйгээр хичээлдээ сайн оролцож, өмнө ирж байсан үеийнхээс чадвар нь ахисан байгааг үнэлэн цаашид хүүхдийг өөрийг нь бие даалгаж сургах, ахицыг тэмдэглэх, чадахгүй байгаа зүйлийг хичээлүүд дээр нь оруулж өгвөл дадал суух бөгөөд хялбар хэрэглэгдэхүүн сонговол бусдын дэмжлэгийг авалгүйгээр бие даан хийж сурах гэх мэт зөвлөгөөнүүдийг өглөө.<br>• Бага ангийн сургалтын менежер Э.Болорцэцэг НБГ-аас зохион явуулсан “Унших бэрхшээл, түүний ойлголтууд”, “Бичих бэрхшээл, түүний ойлголтууд” сэдэвт сургалтуудад хамрагдан хөгжлийн бэрхшээлээс суралцахуйн бэрхшээлийг ялгах, унших, бичих бэрхшээлийг даван туулах арга замын талаарх мэдээллийг бага ангийн багш нарт өгсөн.<br>• Сургалтын тохируулгат орчныг бүрдүүлэх санамж бичигт гарын үсэг зурж, төлөвлөлтийн дагуу сургалтын орчныг бүрдүүлэн ажилласан ба санхүүгийн 2 сая төгрөгний тайлан гүйцэтгэлийг заавар зөвлөмжийн дагуу гаргаж Жайка төслийн багт хүргүүлсэн.<br>• Сургуулын захирлын 2018 оны 5-р сарын 01-ний өдрийн А/2 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй “Дэмжлэгийн баг”-ийг байгууллаа.<br>• Дэмжлэгийн зөвлөл 2 удаа хуралдсан ба 1-р хуралдаанаар зөвлөлийн ажлын төлөвлөгөө, 2-р хуралдаанаар зөвлөлийн гишүүдийг үүрэгжүүлэн сургуулийн зүгээс ердийн ангид суралцаж байгаа дэмжлэг шаардлагатай сурагчдын жагсаалтыг гарган ганцаарчилсан төлөвлөгөө шаардлагатай хүүхдийг хэлэлцэж сонгосны үндсэн дээр хөтөлбөрөө загварын дагуу боловсруулах тал дээр А.Эрдэнэтуяа багш арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. |

| | |
|---|---|
| | • Танин мэдэхүйн үйл явцын өөрчлөлтөөс болж, ЕБС-ийн тухайн ангийн стандарт, хөтөлбөрийг эзэмших чадамжгүй нийт 21 сурагчаас танхимд 15 сурагч суралцаж, 6 сурагч хөдөлгөөнт, засан сайжруулах сургалтанд хамрагдлаа. Хичээлийн үргэлжлэх хугацаа 30 минутаар 6 цагийн хичээл орно. Монгол хэл-5ц, Унших-3ц, Математик-5ц, Хөгжим-2ц, Дүрслэх урлаг-2ц, Биеийн тамир-2ц, Заслын хичээл: Хэл засал-3ц, Хөдөлгөөн засал-3ц, Сэтгэл засал-3ц, Ахуй засал-3ц<br>• Сурагчдыг судлахад хэлний бэрхшээлтэй, ээрүү, шулга, дуу хоолойн өөрчлөлттэй сурагч 10, асуултанд хариулж ярьж чаддаггүй сурагч 12, авиан дуудлагын бэрхшээлтэй 15 сурагч байв. Нийт 15 сурагч нь авиа үсгээ таньдаггүй үндсэн 7 эгшгээс өөрийг мэдэхгүй 10-ын дотор нэмэгдүүлэн хорогдуулох үйлдэл ойлгодоггүй, орон зайн баримжаа алдагдсан, хөдөлгөөний эвсэл суугаагүй, хэл ярианы чадвар сул, сонсох чадваргүй, анхаарлын тогтворжилт, төвлөрөлт, шилжилт байхгүй гэх мэтчилэн танин мэдэх процессын өөрчлөлтөнд орсон байв<br>• 2017-2018 оны хичээлийн жилийн сүүлийн хагаст нийт сурагчид 35 авиа үсгээ бүрэн нүдэлсэн, үеүдийг цээжилсэн, үе холбон унших аргад суралцсан, ямар нэгэн дүрс зурган дээр хамтран ажиллаж задлан шинжлэн, нэгтгэн дүгнэж сурах үйл ажиллагаанд чадваржиж байгаа<br>• Нийгмийн ажилтан Д.Оюунтунгалаг холбогдох газруудад уламжлан дэмжлэгт бүлгийн сурагч [redacted] тэргэнцэртэй болголоо.<br>• Дэмжлэгт бүлгийн сурагчдад сургуулийн унаагаар үйлчлэн хүүхэд нэг бүрийг гэрийн гаднаас авч тарахад хүргэж өгдөг.<br>• 63-р сургуулиас багшлах боловсон хүчнээр ханган мэргэжлийн 2 багшийг цалинжуулан ажиллуулж удирдлага арга зүйн зөвлөгөө өгч ажиллахаас гадна сурагчдын “Үдийн цай”-г өдрийн 2400 төгрөгөөр тооцон олгож сурагчид маань 1,2-р хоол, халуун цай, шүүсээр үйлчлүүлж байна.<br>• Сурагч [redacted] 7 хоногийн хугацаанд ангийн дарга, үдийн цайны жижүүрийг 14 хоногт 1 удаа хийлгүүлж байсан нь бусдаас суралцах, бусадтай хамтран ажиллах, өөрийгөө нээх, илэрхийлэх чадварыг ахиулахад тус дэм болсон.<br>• [redacted] унших чадварыг ахиулахын тулд багш Иргэний боловсролын сурах бичгээс өөрийнх нь сонирхсон сэдвийг сонгуулан уншуулж, 1-2 өгүүлбэрийг хуулан бичүүлж, тухайн өгүүлбэрийг дэлгэрүүлэн яриулж байсан нь бичих, ярих чадварт ахиц гарахад нөлөөлсөн. Дараа нь багш унших эх, бичих өгүүлбэрийг сонгож өгдөг болсон. Хүүхэд багшийн оноож өгсөн өгүүлбэрийг олохын тулд эхийг гүйцэд уншиж байсан нь ном унших сонирхлыг төрүүлж, номын санд карт нээлгэн 4 номыг бие даан уншсан.<br>• БСШУСЯ, ХНХЯ, Жайка-гаас хамтран гаргасан 2018 оны цаг тооны хуанлид дэмжлэг ангийн сурагч [redacted] “Миний амьдрал-Миний гэр бүл” сэдэвт зураг хэвлэгдсэн. |

| | |
|---|---|
| | Захирал О.Одонтуул нь 2018 оны 1-р сард тус төслийн санхүүжилтээр Япон улсад сургалтад хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгэмд тэгш хамруулан сурч боловсрох, хөдөлмөрлөх, тэдний авьяасыг нээн хөгжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэг туслaмж, төрийн бодлого, орон нутгийн бодлого зохицуулалт гэх мэт олон зүйлийг суралцан мэдлэг, чадвараа дээшлүүлэв. |
| Ашигласан худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүнүүд:<br>1. Заслын хичээлд ашиглах хэрэглэгдэхүүнүүд /6ш/<br>2. Сургалтын хэрэглэгдэхүүнүүд /бичгийн цаас, дэвтэр, бал, өнгийн цаас, ламинаторын цаас, цавуу, будгийн харандаа, пламастр, скоч, хавтас/<br>3. Ардын аман зохиолын цуврал<br>4. Танин мэдэхүйн гарын авлага<br>5. IQ-ийн ном<br>6. Буддаг номууд<br>7. Монгол ардын үлгэрийн цуврал ном<br>8. Үелж уншихад сургах номууд<br>9. Сэтгэхүй танин мэдэхүй хөгжүүлэх гарын авлагууд<br>10. Зурагт танин мэдэхүйн номууд<br>Дэмжлэгт ангийн сурагчид хэрэглэхээс гадна ганцаарчилсан сургалтын хөтөлбөр ба ердийн ангид суралцаж байгаа суралцахуйн хоцрогдолтой сурагчид дээрх гарын авлага болон багш нарын хийсэн сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг сургалтанд ашиглаж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн ажлыг хөнгөвчлөхөөс гадна хүүхдүүдэд сонирхолтой байв. |

| | | |
|---|---|---|
|  |  |  |
| ажлын явц | ажлын явц | ажлын явц |
|  |  |  |
| ажлын явц | Налуу зам хийсэн байдал | Дэмжлэгт ангид суултуур, шийдвэрлэж өгсөн |

| Дэмжлэгт ангид суултуур, угаалтуурыг шийдвэрлэж өгсөн | Коридорт хийсэн ханын бариул | Дэмжлэгт ангид суултуур, угаалтуурыг шийдвэрлэж өгсөн |
|---|---|---|
|  |  |  |
| Ангийн сургалтын орчинг бүрдүүлэлт | Заслын хичээлд зориулж толь байрлуулсан | Заслын хичээлийн хэрэглэгдэхүүн |
|  |  |  |
| хичээлийн хуваарь | Толь байрлуулсан | Буддаг номнууд |
|  |  |  |

<table>
<tr><td colspan="3">Хэрэглэгдэхүүн</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="3">Багш нарын хийсэн сургалтын хэрэглэгдэхүүн</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Үр дүн “Хүүхдийн байр байдал”</td><td colspan="2">
<ul>
<li>Сурагч [redacted] нь ганцаар ажилладаг, бүрэг, зожиг байсан бол бусадтай хамтран ажиллаж, мэдэхгүй зүйлээ бусдаас асуудаг болсон. Тоо бодохдоо муу байсан нь тоолох хэрэгслийг ашигласнаас амар хялбар бодох аргад суралцаж тодорхой ахиц гарсан. Бичих чадварын хувьд хангалтгүй муу байсан бол алдаагүй цэвэр сайхан, элементээр бичиж эхэлсэн. Өөрийгөө илэрхийлэх, ярих чадварт тодорхой ахиц гарч бусад сурагчдын адил нээлттэй болж өөрчлөгдөж байна. Урлагийн хичээл дээр хайч, цавуу, багаж хэрэгсэлтэй ажиллаж сурсан ба бие даан хийсэн бүтээлүүд нь гарсан.</li>
<li>Дэмжлэгт ангийн сурагчид ганцаарчилсан хичээлээр өнгө ялгадаг, дүрс зургийг нэрлэн үйл явдлыг ярьж чаддаг, богино үгүүдийг өөрөө бүтээн бичиж чаддаг болсон.</li>
<li>Дультраа сурагчид: [redacted], [redacted], [redacted] нар нь богино өгүүлбэрээр ярьж сурсан.Сурагчид хүүхдийн дуу 15, шүлэг 2, үлгэр 2-ыг багаараа хамтран бүтээж хийж сурсан.</li>
</ul>
</td></tr>
</table>

## 2-6. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 34 ДҮГЭЭР СУРГУУЛЬ

| Сонгосон хүүхэд | [redacted], [redacted] | |
|---|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | 1. Эвлүүлдэг хэрэглэгдэхүүн дээр үе үсэг, нэг үетэй богино үг зэргийг бичиж эвлүүлж үе, үгийг давтамжтайгаар хэлж ойлгодог болоход туслах<br>2. Хичээлийн явцад хэрэглэгдэх зүйлийг нь сагс, ширээнд нь байрлуулж зөвхөн түүнийг нь хийлгэж дуусгах<br>3. Ангид тайвширч, анхаарал төвлөрөх булан бий болгож өөрийн дураар тоглох, дуу сонсох гэх мэт өөрийнхөөрөө байж чадах тайвширах орчин бий болгох<br>4. Монгол гэрт сэтгэл засал болон тайвшируулах морин хуурын ая, үлгэр, туйл гэх мэт (монгол наадгай, CD, оньсон тоглоом, төрөл бүрийн аяз, үлгэр)<br>5. Зурган картууд бэлдэх, ярьдаг цагаан толгой гэх мэт олон удаагийн давталттай хэрэглэгдэхүүнийг ашиглах<br>6. Үндсэн өнгийн дүрстэй эвлүүлдэг хэрэглэгдэхүүн<br>7. Коридорт зориулалтын тууш бариултай болох<br>8. Суултуур хөлийн гишгүүр<br>9. Зөөврийн сургалтын хэрэглэгдэхүүн<br>10. Тохирох дугуйлан секцэд хамруулах оролцоог нэмэгдүүлэх, бүтээсэн зүйлийг нь суртачилах, түгээн дэлгэрүүлэх<br>11. Ангийг нэгдүгээр давхарт зөөж налуу хавтан орц гарцыг зохицуулсан | |
| Ашигласан худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | 1. Дэлхийн сонгодог зохиол CD, DVD<br>2. Багшийн ном<br>3. А-Я хүртэл карт<br>4. Хүүхдийн дууны цомирлог<br>5. Миний хүүхэд насны дурсамж<br>6. Хөөмий<br>7. Хүүхдийн дууны цоморлиг<br>8. Аригийн голын Алунгоо кино CD<br>9. Оньсон тоглоом | 10. 3D PUZZLE<br>11. Эвлүүлдэг зураг<br>12. Шидэт тоо /соронзтой/<br>13. Эв долоо<br>14. Монгол ахуйн эд хэрэглэл карт<br>15. Миний анхны компьютер<br>16. Ярьдаг цагаан толгой<br>17. DVD удирдлага |

<table>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="3">№ 1 Эвлүүлдэг хэрэглэгдэхүүн дээр үе үсэг, нэг үетэй богино үг зэргийг бичиж эвлүүлж үе, үгийг давтамжтайгаар хэлж ойлгодог болоход туслах</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="3">№2 Хичээлийн явцад хэрэглэгдэх зүйлийг нь сагс, ширээнд нь байрлуулж зөвхөн түүнийг нь хийлгэж дуусгах</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="3">№3 Ангид тайвширч, анхаарал төвлөрөх булан бий болгож өөрийн дураар тоглох, дуу сонсох гэх мэт өөрийнхөөрөө байж чадах тайвширах орчин бий болгох</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="3">№4 Монгол гэрт сэтгэл засал болон тайвшируулах морин хуурын ая, үлгэр, туйл гэх мэт (монгол наадгай, CD, оньсон тоглоом, төрөл бүрийн аяз, үлгэр)</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="3">№ 5 Тохирох дугуйлан секцэд хичээллүүлэх оролцоог нэмэгдүүлэх, бүтээсэн зүйлийг нь сурталчлах, түгээн дэлгэрүүлэх</td></tr>
<tr><td></td><td colspan="2"></td></tr>
<tr><td colspan="3">№6 Үндсэн өнгийн дүрстэй эвлүүлдэг хэрэглэгдэхүүн</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
</table>

| | |
|---|---|
| № 7 Зурган картууд бэлдэх, ярьдаг цагаан толгой гэх мэт олон удаагийн давталттай хэрэглэгдэхүүнийг ашиглах(зурган карт, ярьдаг цагаан толгой) | |
|   | |
| № 8.Коридорт зориулалтын тууш бариултай болох<br>№ 9Суултуур хөлийн гишгүүр | |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | • Сургалтын хэрэглэгдэхүүнийг 1-5-р ангийн суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй багш нар авч сургалтадаа хэрэглэж байна.<br>• Үндсэн долоон өнгийг маш сайн ялгадаг.<br>• Өөрт хэрэгцээтэй зүйлсийг сагснаас сонгон авч хэрэглэж сурах<br>• Үндсэн дүрсүүдийг маш сайн нэрлэдэг.<br>• Тэдгээр дүрсээр янз бүрийн амьтан, эд зүйлс бүтээдэг<br>• Одоо 3 оронтой тоог аравт задлахгүй нэмж, хасаж байна.<br>• Соронзтой тоглоомоор өөрийн дуртай, чадах зүйлийг хийдэг.<br>• Хүрд чээжлэж 1-5 хүртэлх хүрдийг тогтоосон, 6-10 хүртэлх хүрдийг цээжлэн нүдэлж байна.<br>• Эгшиг үсгийг нүдлэн эхний гийгүүлэгч үсгийг нүдлэн тогтоох үйлд суралцаж үе уншиж байна.<br>• Сэтгэхүй хөгжүүлэх дасгал даалгавар гүйцэтгэхдээ сайн<br>• Хөөмий, аяз, хүүхдийн дуу сонсож тайван орчинд тоглож наадах<br>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг одоогоор суралцахуйн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн болон бусад 114 хүүхэд хичээл сургалтдаа хэрэглэсэн байна. |
| Цаашид хэлэлцэх асуудал | • Эцэг эхчүүдийг сургалтад хамруулах, чадваржуулах<br>• Багшийг чадваржуулах, арга туршлагаасаа байнгын зааж зөвлөх<br>• Зорилтот бүлэг болон суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж ирсэн арга туршлага, бусад багшийн хичээлд суух<br>• 1000 дотор нэмэх, хасах үйлдэл хийх<br>• Бүх үеийг нүдлэн тогтоох, унших<br>• Хэл заслын сургалтанд хамруулах<br>• Зуны амралтаар хичээлийн хоцрогдлыг багасгах эсвэл өөрийгөө хөгжүүлэх сургалтанд хамрагдах |

## 2-7. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 79 ДҮГЭЭР СУРГУУЛЬ

| Сонгосон хүүхэд | Эрэгтэй сурагч А Эрэгтэй сурагч Б |
|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | 1. Тус сургуулийн 2 сурагчийг төсөлд хамруулан хүүхэд хөгжлийн Төв байгуулан төслийн хөрөнгө оруулалтын 2 сая төгрөгөөр хэрэглэгдэхүүн авч тохижуулсан<br>2. Мөн 7 хоногийн 1,3,5 дахь өдрүүдэд МУБИС-ийн 2 оюутан багш ирж хичээл орохоос өмнө 2 цагийн турш хамтран ажилладаг болсон.<br>1. Зурган карт, эвлүүлдэг хэрэглэгдэхүүн, гар самбар, хөлтэй самбартай болох. Хичээл тарсны дараа давтлага хийх.<br>2. Зурган номнууд<br>3. Зөвлөн туслах сургалт зөвлөгөө авах<br>4. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө<br>5. Мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах<br>6. Янз бүрийн тооллын материал авах |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Зурган карт-5ш, Том үсэгтэй ном-2ш, Хайлтын ном-2ш, Цагаан толгойн карт-6ш, Өнгөт принтер-1ш, Танин мэдэхүйн цуврал-10ш, Тоон карт-4ш, Зурган карт /Багц/-10ш, Сэтгэхүй хөгжүүлэх тоглоом-2ш, Хуруун хүүхэлдэй /багц/-10ш, Эвлүүлдэг хэрэглэгдэхүүн-1ш, Хүүхэд хувцасладаг тоглоом-2ш, Хавтгайн соронз-5ш |

| | |
|---|---|
|  |  |
|  |  |

| | |
|---|---|
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | **Сурагч Өсөхбаярын бодит байдал:** Хувцасаа буруу харуулж өмсдөг. Жишээ нь: хоёр гутал, цамцаа зөрүүлж товчилдог, ярьж байгаа үг нь ойлгодоггүй үргэлжилсэн үгтэй, гучин таван үсгийг мэддэг боловч холбож уншиж чаддаггүй, хуваах үйлдэл чаддаггүй, сурлагын хоцрогдолтой сурагч байсан. Ангийнхнаасаа ичдэг. **Гарсан ахиц:** Хувцсаа зөв харуулж өмсдөг болсон, үелэж унших чадвар эзэмшсэн, заримдаг болон эгшигт гийгүүлэгчийг ялгадаг болсон. Хуваах үйлдлийг сайн эзэмшсэн. Өөртөө итгэлтэй хүүхдүүдтэй харилцдаг болсон. **Сурагч Хувьтөгөлдөрийн бодит байдал:** Огт үг хэлдэггүй байсан ба гучин таван үсэгнээс зургаан үсэг мэддэг, эгшиг үсгийг чөлөөтэй нэрлэдэг, мөн нэрээ бичиж чаддаггүй, тооны хичээл дээр нэмэх, хасах үйлдэл мэддэг, харин үржих, хуваах үйлдэл мэддэггүй байсан. **Гарсан ахиц:** Тодорхой хэмжээгээр харилцан ярилцдаг болсон, гучин таван үсгийг үелж уншдаг болсон, нэрээ зөв бичиж сурсан. Үржих, хуваах үйлдэлтэй бодлого бодож чаддаг болсон. Өөртөө итгэлтэй болсон. |
| Цаашид хэлэлцэх асуудал | Сурагчдын өрөөг томруулах, ганцаарчилж ажиллах өдрийг нэмэгдүүлэх, анги ахиж байгаа учраас хэрэглэгдэхүүнийг өөрчилж нэмэгдүүлэх |

## 2-8. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 111 ДҮГЭЭР СУРГУУЛЬ

| Сонгосон хүүхэд | 4 анги эрэгтэй хүүхэд<br>3 анги эрэгтэй хүүхэд | |
|---|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | 1. Сургалтын хэрэглэгдэхүүн, тарааж өгөх материалыг ламинатордах<br>2. Хийсэн бүтээлийг нь гаргаж, ахицыг тооцох<br>3. Бичгийн цаас, өнгийн цаас ашиглан бүтээл хийх<br>4. Бүтээлийн самбарт сурагчдын бүтээл гаргах<br>5. Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном, карт, дасгал ажлын ном<br>6. Цагаан самбар | 1. Хүүхдийн ярих чадварыг хөгжүүлэх зорилгоор эхийн үйл явдлыг харуулсан зураг ламинатордаж хэрэглэгдэхүүн бэлдсэн. (6ш сэдэвт зураг)<br>2. Тоо тоолол, их багыг харьцуулсан тарааж өгөх материал хийж ашигласан. (10 ширхэг)<br>3. Өнгийн цаасаар цэцэг, дүрс хайчлан байшин, бөмбөг зэргийг хийж бүтээлийн самбарт байрлуулсан. (10 удаа)<br>4. Гарын жижиг булчин хөгжүүлэх буддаг номыг ашиглан сурагчийн бичих чадвар сайжирсан. (2ш ном)<br>5. Танин мэдэхүйн онцлогт тохирсон ном, зурган карт, дасгал ажлын ном авч ажилласан.<br>6. Цагаан самбарыг тоо тоолол, монгол хэлний хичээлээр ашигласан |
| Ашигласан худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | 1. “Эх хэл” монгол хэлний ном<br>2. Математик чадварын дэвтэр (1,2)<br>3. Тоо тоолол орон зайн баримжааг хөгжүүлэх дасгалууд<br>4. Буддаг ном<br>5. Бүтээлийн самбар<br>6. Эвлүүлдэг тоглоом соронзтой<br>7. Зурган карт | 8. Эвлүүлдэг модон тоглоом<br>9. Шидэт шоо<br>10. Уншаарай нүдлээрэй<br>11. Тоон болон үсгийн карт<br>12. Унших бичих дасгал<br>13. Би бодож бүтээж сурлаа<br>14. Математик 1 бие даах ажил |

| | |
|---|---|
|   |    |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | **Хүүхэд А**<br>1. Унших чадварт ахиц гарсан. Минутанд 20 үг уншдаг болсон<br>2. Богино эхийг багшийн дэмжлэгтэй ярьдаг болсон<br>3. 10 хэтрүүлэн нэмэх үйлдэл сайжирсан<br>4. 20 хэтрүүлэн хасах үйлдэл багшийн дэмжлэгтэй хасдаг болсон<br>5. Гэр бүл болон өөрийгөө танилцуулах чадвартай болсон<br>6. Анги хамт олны дунд биеэ зөв авч явах чадвар сайжирсан<br>7. Анги хамт олны дунд зохиогдсон ажилд идэвхтэй оролцдог<br><br>**Хүүхэд Б**<br>1. 1-10 дотор шугам ашиглан бусдын дэмжлэгтэй нэмэх, хасах, үйлдэл боддог болсон<br>2. Богино эгшгийг нүдэлж цээжээр бичдэг болсон<br>3. Бусдын дэмжлэгтэй бүтээл хийнэ<br>4. 1-10 цифр таньж цээжээр бичнэ<br>5. Дуурайн бичиж чадна |
| Цаашид хэлэлцэх асуудал | • Бие даан суралцах чадварт анхаарах<br>• Гэр бүлийн дэмжлэг оролцоог нэмэгдүүлэх<br>• Гэрийн даалгавар хийхэд анхаарах |

## 2-9. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ИРЭЭДҮЙ XXI ЗУУН” ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | Сонгосон 2 сурагч |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Сонгосон хүүхэдтэйгээ ажиллах зөөврийн самбартай болох |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Жижиг самбар, эсгий бал худалдаж авсан |
|  |  |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Самбарт өөрөө бичих сонирхолтой болохоор дуртайяа бичиж, зурдаг. [redacted] БАГШ болж тоглонгоо самбар дээрээ бичиж, боддог. Самбарыг ашиглах явцдаа анхаарлыг сарниулахгүйн тулд хаалт болгон байрлуулахад зөөврийн бага оврын самбар ач холбогдолтой байна. |
| Цаашид хэлэлцэх асуудал | Самбарыг зөвхөн төвдөө ашиглах биш, ангиуд хичээл дээрээ ашиглаж дадах хэрэгтэй байна. |

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | Сонгосон 6 хүүхэд |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Тулгуур эрхтний бэрхшээлтэй, саажилттай хүүхдүүд орох ариун цэврийн өрөөтэй болох |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | ариун цэврийн өрөөний бариул /ханын/<br>ариун цэврийн өрөөний тулгууртай бариул хийх труба худалдан авч, охидын ба хөвгүүдийн ариун цэврийн өрөөний 1 кабинд ханын болон тулгуурт бариул хийсэн. |

| | |
|---|---|
|  |  |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Сонгосон хүүхдүүд бие засахад бэрхшээлгүй болсон |
| Цаашид хэлэлцэх асуудал | Тусгай ариун цэврийн өрөөний хаалгыг засварлах, тавиур тавих ажил хойшлогдсоор байгаа. |

| Сонгосон хүүхэд | Сонгосон 1 хүүхэд |
|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | 3-р ангийн босго, спорт заал болон Хүүхэд хөгжлийн төвийн босгонд налуу хавтан хийх |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | 5-ын банз /4м-ээр/ 5-ын брус, хадаас, цагаан будаг худалдан авч, спорт заал, №102-3б анги, №101- ХСТөв гэсэн 3 танхимд налуу босго хийсэн. |
|   |  |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Тэргэнцэртэй хүүхдийн хөдөлгөөнд тус 3 танхимын хувьд бэрхшээлгүй болсон. |
| Цаашид хэлэлцэх асуудал | Заалны налуу хавтанг дахин сайжруулж хийх боломжтой |

| Сонгосон хүүхэд | Сонгосон 6 хүүхэд |
|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Зурган хаягийг анги танхим, сургууль дотор хийх |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Хананд бэхлэх хүрээ, наадаг фото цаас худалдан авч, 101 Хөгжүүлэн сургах төв,102-108 бага ангиуд, Дуу хөгжим, Сэтгэхүй хөгжүүлэх төв, Захирал, Сургалтын алба, Нийгмийн ажилтан /Хүүхэд хөгжлийн төв/, Санхүүгийн алба, Сургуулийн эмч, Номын сан, Бичиг хэрэг 1-р давхрын эмэгтэй ба эрэгтэй ариун цэврийн өрөө гэсэн 19 өрөө танхимын үүдэнд хөндлөн хаягийг ХБ хүүхдэд тохируулан хийсэн. |
|   |   |
|  |   |
| Үр дүн "Хүүхдийн байр байдал" | Хүүхдүүд болон эцэг эхчүүд очих өрөө, анги танхимаа төвөггүй олдог болоход нь тус дэм болж буй. |
| Цаашид хэлэлцэх асуудал | 2, 3-р давхрын ангиудад хаягжуулалт нэмж хийж болох боловч, дунд ахлах ангийн багш нар зурган хаяг бус, ангийн танилцуулга хийлгэхийг хүссэн тул хийгээгүй болно |

| Сонгосон хүүхэд | Сонгосон 2 хүүхэд |
|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал" | Хэрэглэгдэхүүн хийх шкафтай болгох |

| | |
|---|---|
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, тусгай хэрэглэгдэхүүн хийх арга зүйд суралцсан 3-р ангийн багш [redacted] ангид тусгай хэрэглэгдэхүүн хийж, сургалтандаа тогтмол ашиглан, бусдадаа үлгэр дуурайл үзүүлэхэд нь дэмжлэг өгөх зорилгоор шүүгээ авч тавьсан. |
|  |  |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Сонгосон 2 хүүхэд болон сэдэв агуулгаасаа хоцрох боломжтой хүхдүүдэд зориулсан хэрэглэгдэхүүнийг 3в ангийн багш өөрөө бэлтгэн хичээл сургалтаддаа ашиглаж байгаа нь хүүхдэд ээлтэй үйл ажиллагаа болж, хүүхдүүд сэтгэл хангалуун хичээлдээ дуртай болж байгаа. |
| Цаашид хэлэлцэх асуудал | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй анги бүрд тусгай хэрэглэгдэхүүний шүүгээ ач холбогдолтой болох юм байна. |

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | Сонгосон 8 хүүхэд |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Цифр, дүрс, өнгө, үсэг таниулах. Эвлүүлдэг тоглоом, зурагт карт, буддаг ном |
| Ашигласан худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Буддаг ном-5ш, Эвлүүлдэг хэрэглэгдэхүүн худалдан авсан. |
|  |  |

| | |
|---|---|
|  |  |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Сонгосон 4 сурагч бүгд буддаг номон дээр ажиллах маш дуртай байсан ба 1 эрэгтэй сурагч хүрээнээс хэтрүүлэлгүйгээр будаж сурч байгаа, харин өнгөний сонголтод сайн сураагүй. 1 эмэгтэй сурагч тоогоо бодонгоо будаж сурлаа. |

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | Сонгосон 8 хүүхэд |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Өөрсдөө хийх сургалтын хэрэглэгдэхүүн |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Бичгийн цаас А4,өнгийн цаас<br>өнгөт хэвлэгч EPSON L360 |

| | | | |
|---|---|---|---|
|  |  |  |  |
|  |  |  |  |

| | | | |
|---|---|---|---|
|  |  |  |  |
|  |  |  |  |
|  |  |  |  |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Хүүхэд нэг бүрт тохирсон зурган карт болон ажлын хуудсуудыг бэлтгэн хэрэглэх нь хүүхдийг сэдэлжүүлж, хичээлдээ идэвхтэй оролцож байна. | | |
| Цаашид хэлэлцэх асуудал | | | |

| | |
|---|---|
| Сонгосон хүүхэд | Хөгжүүлэн сургах төвд хамрагддаг хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчид, 1,2-р багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд, 1-р ангийн бүх сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид, |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Эцэг эх, асран хамгаалагч, 1. 2-р багийн оршин суугчдад зориулсан сургалт |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | Бичгийн цаас A4<br>Ус<br>Печень |

| | |
|---|---|
| <br> | <br> |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Ээж аавууд нь сургалтад хамрагдсан хүүхдүүдийн ирц оролцоо, биеэ авч явах байдалд эерэг өөрчлөлт ажиглагдсан |

| | | |
|---|---|---|
| Сонгосон хүүхэд | Сонгосон 11 хүүхэд | |
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Спортын чийрэгжүүлэх хэрэгсэл | |
| Ашигласан, худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн | • Конус<br>• Биеийн булчин хөгжүүлэх ханын татлага<br>• Гар, хөлийн булчин хөгжүүлэх пүрш<br>• Шүхэртэй бөмбөг<br>• Гар бөмбөг | • Сагсан бөмбөг<br>• Агаарын теннисний цохиур<br>• Теннисний цохиур<br>• Эмчилгээний биеийн тамирын өрөөтэй болсон |
|  | <br> |  |





| | |
|---|---|
| Үр дүн "Хүүхдийн байр байдал" | Саажилттай хүүхдийн булчинг хөгжүүлэх, алжаал тайлахад чийрэгжүүлэх хэрэгслүүд бүхий ЭМЧИЛГЭЭНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ӨРӨӨ онцгой ач холбогдолтой байв. Хариуцсан багш баасан гараг бүр спорт зааланд зөвхөн төвийн хүүхдүүд чөлөөт тоглолт хийдэг, үүндээ их дуртай, хувцсаа өмсөөд ирдэг. |
| Цаашид хэлэлцэх асуудал | ЭМЧИЛГЭЭНИЙ БИЕИЙН ТАМИРЫН багш Бие бялдрын хөгжлийн нарийвчилсан судалгаа гаргаж, ажлын хуваарь батлуулж ажиллах, мэргэжлийн эмчийн зөвлөгөө туслалцаа шаардлагатай |

## 2-10. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ТИТЭМ” ДУНД СУРГУУЛЬ

| Сонгосон хүүхэд | Сонгосон хүүхэд А Сонгосон хүүхэд Б |
|---|---|
| Хэрэгжүүлсэн ажлын агуулга /Шийдвэрлэх боломжтой сонгосон санал/ | Сонгосон сурагч болон ТХБ шаардлагатай бусад сурагчиддаа зориулан тохируулгат орчин бүдүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэн хичээл сургалтад хэрэглэгдэх сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг зэргийг худалдан авч сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Сургуулийн дотор орчинд тохируулга хийх зорилгоор А корпусын 2-р давхарын шатанд 150000 төгрөгийн өртөг бүхий нам бариулыг суурилуулж , анги танхимуудыг мэдээлэх 30 ширхэг зурган хаягийг ширхэг бүрийг 5000₮ -өөр нийт 150000₮ -ийн өртөгтэйгээр танхимуудаа хаягжуулсан ба ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлэхэд зориулж өрөөний хананд бариул суурилууллаа. “Шийдвэрлэх боломжтой сонгосон санал” –уудын жагсаалтыг хавсралт 1-ээр харуулав |

| №01 | Шийдвэрлэх боломжтой сонгосон санал | Хэрэглэгдэхүүний нэр |
|---|---|---|
| 1 | А корпусын 2-р давхарын шатанд нам бариул суурьлуулах | шатны бариул |
| 2 | оо-ын өрөөний хананд бариул суурьлуулах бариулыг тогтоох | том бариул |
| 3 | оо-ын өрөөний хананд бариул суурьлуулах бариулыг тогтоох | тэлэгч шруп |
| 4 | зөөж хэрэглэх самбар portable | хөлтэй самбар /дунд/ |
| 5 | Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүд ашиглах боломжтой | цагаан самбар /жижиг/ А/3 |
| 6 | Анги танимуудын хаягийн мэдээлэлэх карт | зурган хаяг |
| 7 | хичээл сургалтад ашиглах зурган карт | зурган карт |
| 8 | сургалтын хэрэглэгдэхүүнний тавиур | номын тавиур |
| 9 | хэрэглэгдэхүүн хийх зориулалтай сагс | хуванцар сагс |
| 10 | хичээл сургалтад ашиглах интернэт төхөөрөмж | гэр интернэт 9 сараар |
| №02 | | |
| 11 | хичээл сургалтанд ашиглах бичгийн цаас А/4 | бичгийн цаас А/4 |
| 12 | хичээл сургалтад ашиглах ламинаторын цаас | ламинаторын цаас |
| 13 | хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг | дуулдаг ном |

<table>
<tr>
<td>Ашигласан худалдан авсан сургалтын хэрэглэгдэхүүн</td>
<td>
<table>
<tr><td>14</td><td>хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг</td><td>хөгжүүлэх сургалтын ном</td></tr>
<tr><td>15</td><td>хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг</td><td>мэдэрдэг ном</td></tr>
<tr><td>16</td><td>хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг</td><td>үлгэрийн ном</td></tr>
<tr><td>17</td><td>хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг</td><td>"Яагаад" цуврал ном</td></tr>
<tr><td>18</td><td>хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг</td><td>харилцааны цуврал</td></tr>
<tr><td>19</td><td>хичээл сургалтад ашиглах бичгийн цаас А/4</td><td>өнгөт цаас</td></tr>
<tr><td>20</td><td>хичээл сургалтад ашиглах тоглоом</td><td>үддэг зураг / модон/</td></tr>
<tr><td>21</td><td>хичээл сургалтад ашиглах тоглоом</td><td>зураг шоо / эвлүүлдэг/</td></tr>
<tr><td>22</td><td>хичээл сургалтад ашиглах тоглоом</td><td>эвлүүлдэг тоглоом</td></tr>
<tr><td>23</td><td>сургалтын хэрэглэгдэхүүн хийх урлалын эсгий</td><td>урлалын эсгий 12 өнгө</td></tr>
<tr><td>24</td><td>хичээл сургалтад ашиглах самбарын үзэг</td><td>самбарын үзэг</td></tr>
<tr><td>25</td><td>хичээл сургалтад ашиглах зургийн дэвтэр</td><td>салдаг дэвтэр</td></tr>
<tr><td>26</td><td>хичээл сургалтад ашиглах будгийн харандаа</td><td>будгийн харандаа</td></tr>
<tr><td>27</td><td>хичээл сургалтад ашиглах хавчаар</td><td>модон хавчаар</td></tr>
<tr><td>28</td><td>хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг</td><td>буддаг ном</td></tr>
<tr><td>29</td><td>хичээл сургалтад ашиглах балын харандаа</td><td>балын харандаа</td></tr>
<tr><td>30</td><td>хичээл сургалтад ашиглах эсгий бал</td><td>12 өнгийн эсгий бал</td></tr>
<tr><td>31</td><td>хичээл сургалтад ашиглах өнгийн цаас</td><td>12 өнгийн цаас</td></tr>
<tr><td>33</td><td>хичээл сургалтын хөтөлбөр хэрэглэгдэхүүн бэлтгэх хэвлэгч</td><td>3-н үйлдэлт принтер</td></tr>
<tr><td>34</td><td>хичээл сургалтын хөтөлбөр хэрэглэгдэхүүн хэвлэх</td><td>принтерийн хор</td></tr>
</table>
6. Зөөврийн самбар: жижиг , дунд<br>
7. Хичээл сургалтад ашиглах ном, сурах бичиг: "Яагаад" цуврал, Хөгжүүлэх сургалтын дасгал ажил, дуулдаг ном, мэдэрдэг ном, үлгэрийн ном, харилцааны цуврал ном, буддаг ном,<br>
8. Цаас: бичгийн цаас, өнгөт цаас, 12 өнгийн цаас, ламинаторын цаас, өнгийн хуулга, хөөсөн цаас /урлалын эсгийний оронд/
</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td colspan="3">9. Тоглоом: эвлүүлдэг тоглоом 2 төрөл, үддэг зураг, домино/зурагт шооны оронд/, самбарын үзэг, эсгий бал, балын харандаа, будгийн харандаа, зургийн дэвтэр, модон хавчаар, хуванцар сагс, тоглоомын тавиур, 3-н үйлдэлт өнгөт хэвлэгч, принтерийн хор.<br>10. Орчин бүрдүүлэлт: Шатны нам бариул болон ариун цэврийн өрөөнд бариул хийхэд шаардлагатай нарийн хоолой, электрод, будаг, замаск</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

| | |
|---|---|
| Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэдтэй ажиллаж буй багш нарын мэргэжлийг дээшлүүлж, багшлах ур чадварыг сайжруулах зорилгоор дараах сургалт үйл ажиллагаануудыг төслийн багаас зохион байгуулсанд манай сургуулийн багш нар идэвхтэй хамрагдаж их зүйлсийг сурч мэдсэн. Үүнд:<br>1. 2017.9.7-нд “Сургууль дээрх тохируулгат орчин” сэдэвт сургалтыг Токио Гакүгэй ИС-ийн багш Оотомо Киошигийн сургалтад Титэм сургуулийн бага ангийн багш нар оролцсон.<br>2. 2017-10-23~25 хооронд БСШУС-н яам болон Жайка ОУ-н байгууллагын дэмжлэг санхүүжилтээр Монгол улсын гавьяат багш Д.Батсуурийн нэрэмжит Титэм ЕБС-н захирал С.Мөнхболд, бага ангийн сургалтын менежер Я.Дагвасүрэн, Тусгай хэрэгцээт боловсролын төвийн багш С.Болор-Эрдэнэ, сургуулийн эмч Л.Оюу-Эрдэнэ, бага ангийн багш Н.Мөнхбаяр нарын 5 хүний бүрэлдэхүүнтэй баг УБ хотод тусгай хэрэгцээт боловсролын талаарх мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж 3 өдрийн турш Нийслэлийн 6 тусгай сургууль, 2 ердийн сургуулийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судаллаа.<br>Энэ хугацаанд бага боловсролын жишиг сургалтын хөтөлбөр болон ганцаарчилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргазүйн зарим асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хичээлээр хөгжүүлэх аргазүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж хэн бэ, хэрхэн ажиллах вэ гэдэг аргазүйн сургалтууд авсан ба хараа, сонсгол, дауны хам шинж, оюуны хөгжлийн бэрхшээлтэй, аутизмтай, бие эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг сургууль, багш нарын аргазүй, хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагаа, арга туршлагыг үзэж сонирхлоо.<br>Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах арга зүйг олж харах зорилгоор хичээлд сууж зөвлөгөө аван, харилцан туршлага судаллаа. | 3.ХБХ-ний Эрхийн тухай хууль сурталчлах , хуулийн хэрэгжилтийг хангахад үүрэг хүлээгчдийн чадавх бэхжүүлэх Төвийн бүсийн 5 аймгийн хамтарсан чуулганыг ХНХЯ , JICA ОУХАН , Хөвсгөл аймгийн ЗДТГ -аас хамтран зохион байгуулсан. Тус чуулганд ТИТЭМ сургуулийн Захирал С.Мөнхболд , НА Т.Бурмаа , ХХТ-ийн багш С.Болор-Эрдэнэ нар хатрагдав.<br><br>3. 2018.4.2-7 ны өдрүүдэд Титэм ЕБС , Ирээдүй XXI зуун цогцолбор сургуулиудын багш нарт “Оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” , “Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” “Суралцах зан үйлийн өөрчлөлттэй хүүхдийн талаарх ойлголт ” , зэрэг сэдвүүвээр суралт хэлэлцүүлэг зохион байгуулагдсанд манай сургуулийн Бага боловсролын багш нар ,Монгол хэлний багш нар тус хамрагдсан. Мөн 25-р тусгай сургуулийн Согог зүйч багш Ч.Алтанцэцэг, М.Батмөнх нар ХХТ-ийн сурагчдад Хөгжлийн үнэлгээ хийж багш , эцэг эхчүүдэд зөвлөгөө өгсөн нь маш үр дүнтэй байлаа. |

| | |
|---|---|
| БМДИ-н мэргэжилтэн Ц.Цэвэгмидийн тусгай хэрэгцээт боловсрол шаардагдах хүүхэдтэй ажиллах сургалтын төлөвлөгөө, сурах бичиг, аргазүйн зөвлөмжийн талаар ойлголт, зөвлөгөө авсан бөгөөд БМДИ-н сургагч багш Ч.Жаргалын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах идэвхтэй сургалтын олон аргуудаас суралцсанаараа давуу талтай байлаа.Бид УБ хотын 8 сургуулийн үйл ажиллагаатай танилцан туршлагаас суралцсан бөгөөд сургууль бүрийн онцлог давуу талыг олж харж чадсан. | |
| Үр дүн “Хүүхдийн байр байдал” | Сурагч А-гийн хувьд зурж будах , танин мэдэхүй болон нийгэмшихүйн чадваруудад ахиц гарч байгаа. 15-20 минутын хугацаанд маш сайн төвлөрч сууж сурсан , үндсэн 3-н дүрс “дугуй, гурвалжин, дөрвөлжин” дүрсүүдийг таньдаг болсон. Сургуулийн үүднээс ангиа олоод орж ирдэг, бие даан бие засах газраар үйлчлүүлж чаддаг болсон. дуулдаг ном, зурагтай ном зэргийг маш их сонирхон үздэг, үддэг зургаар тоглох дуртай.<br>Сурагч Б-гийн хувьд хичээлийн бус цагаараа Хөгжүүлэх сургалтын танхимаараа үйлчлүүлдэг. Тус сурагчид зориулан тохируулгат орчин бий болгох үүднээс шатанд нам бариул, ариун цэврийн өрөөнд бариул зэргийг хийж өгснөөр тэр шатаар дээш доош явахдаа тус бариулын тусламжтайгаар өгсөж уруудаг ба мөн бага насны хүүхдүүд , ахмад хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй бусад хүүхдүүд болон жирийн хүмүүс ч уг бариулыг ашиглаж байгаа нь анзаарагдсан.<br>Японы ЖАЙКА ОУХАБ-аас бидэнд эд материалын болон арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласнаар хичээл сургалтын үйл ажиллагаагаа сонирхолтой,  илүү үр дүнтэй зохион байгуулагдаж байгаа. Жишээлбэл өнгөт хэвлэгч, интернэт төхөөрөмжөө ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, хүүхдэд зориулсан тэдний сонирхолыг татахуйц үлгэр, дуу, бүжиг, видео хичээл зэргийг татан авч сургалтаддаа хэрэглэж байна.<br>Сонгосон сурагчид төдийгүй Хөгжүүлэх сургалтын танхимаар үйлчлүүлж буй бусад сурагчид мөн багш миний бие ч эдгээр сургалтын хэрэглэгдэхүүнүүдээ өдөр тутмын сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг. |

# ХАВСРАЛТ МАТЕРИАЛ-1

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/155 дугаар тушаал

- “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар” /нэгдүгээр хавсралт/
- “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал” /хоёрдугаар хавсралт/





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/155 Улаанбаатар хот

Үлгэрчилсэн загвар, аргачлал
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 15.4 дэх хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчдын хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглах “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-ний үлгэрчилсэн загварыг нэгдүгээр, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх суралцагчдын хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх үүрэг бүхий сургуулийн комиссыг жил бүрийн 5 дугаар сард байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэсэн суралцагчдын талаархи тайланг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны ерөнхий боловсролын бодлогын газарт жил бүрийн 6 дугаар сард багтаан ирүүлж байхыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

САЙД Ц.ЦОГЗОЛМАА

Г000473

Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын 2018 оны 03 дугаар сарын 19 өдрийн А/155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАТЛАВ.Сургалтын менежер ....................................../....................................../

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| **1.Сурагчийн бодит байдлын судалгаа** | | | |
|---|---|---|---|
| Сургуулийн комиссын хуралдааны огноо<br>□□□□ □□ □□<br>Сурагчийн овог, нэр<br>Регистрийн дугаар: □□ □□□□□□□□<br>Сургуульд элсэн орсон огноо, (нас)<br>**Анги, бүлэг** / **Хүйс:** / Төрсөн огноо:<br>Ам бүлийн тоо / Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд | | Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт:<br>................................................................ **огноо:** □□□□ □□ □□<br>-Онош: □Оюуны хөгжлийн; □Харааны; □Тулгуур эрхтний; □Сонсголын; □Аутизм; □Даун; □Хэл яриа; □Суралцахуй; □Сэтгэл хөдлөл; □бусад ..........................................<br>-Дагалдах өвчин, эмгэгийн тухай мэдээлэл: | |
| Гэр бүлийн харилцааны төлөв байдал: | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэр: | |
| Цэцэрлэгт явсан эсэх (Тийм/ Үгүй).<br>-Хэрвээ тийм бол, цэцэрлэгийн нэр:<br>-Хэрвээ үгүй бол, яваагүй шалтгаан: | Эцэг, эх /асран хамгаалагч/-ийн нэр<br>Холбоо барих утас:<br>И-мэйл хаяг: | Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж, оношлуулсан эсэх (□Тийм/ □Үгүй)<br>-Хэрвээ тийм бол, Онош тавьсан эрүүл мэндийн байгууллагын нэр:<br>-Онош | Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх /□Тийм/ □Үгүй /:<br>-Хэрвээ тийм бол, Сорилын нэр:<br>-Үнэлгээ хийсэн байгууллагын нэр<br>-Үнэлгээний үр дүн: |
| Оршин суугаа хаяг: | | Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх: (□Тийм/ □Үгүй);<br>-Тийм бол тухайн эрүүл байгууллагын нэр, тавигдсан онош, хяналтын давтамж: | |

| | | |
|---|---|---|
| Төрсөний дараахь /0-24 сар хүртэл/ үеийн хөгжлийн түвшингийн онцлог байдал | | |
| Сургуульд бэлтгэгдсэн байдал /2-5 нас/: | | |
| ГСТ-д хамрагдах үеийн хөгжлийн түвшингийн байдал: | Өөртөө үйлчлэх энгийн чадварууд | |
| | Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | |
| | Нийгэмшихүй | |
| | Бие бялдар, хөдөлгөөн | |
| | Анги удирдсан багшийн тодорхойлолт | |
| Оролцогч талуудын хүсэл, зорилго | Сурагч: | |
| | Эцэг эх /асран хамгаалагч/: | |
| | Багш: | |

Тэмдэглэл хөтөлсөн Багшийн нэр, гарын үсэг ................................/....................................../ огноо: □□□□ □□ □□

Танилцсан эцэг (эх, асран хамгаалагч)-ийн
нэр, гарын үсэг ........................................../....................................../ огноо: □□□□ □□ □□

**2. Урт хугацааны зорилт** (Хичээлийн жил ................/..............)

Суралцагчийн овог, нэр .................................................... Анги, бүлэг ....... Хүйс ....... Төрсөн огноо (нас) ..........................

| Хөгжлийн ай | Урт хугацааны зорилт | Дэмжлэгийн орчин | | |
|---|---|---|---|---|
| | | Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг | Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг | Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг |
| Өөртөө үйлчлэх энгийн чадвар | | | | |
| Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | | | | |
| Нийгэмшихүй | | | | |
| Бие бялдар, хөдөлгөөн | | | | |

∗ Зөвхөн шаардлагатай гэж үзсэн хөгжлийн айн зорилтыг дэвшүүлнэ.

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн нэр, гарын үсэг ......................................./....................................../ огноо: □□□□ □□ □□

Танилцсан, эцэг (эх, асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг ......................................./..................................../ огноо: □□□□ □□ □□

### 3. Богино хугацааны зорилт

Суралцагчийн овог, нэр ....................................................... Анги, бүлэг ........ Хүйс ........ Төрсөн огноо (нас) ............................

Урт хугацааны зорилт ...............................................................................................................................................................

| Дэмжлэгийн орчин /хэзээ, хаана/ | Улирал | Богино хугацааны зорилт | Сурагчийн хийх үйл ажиллагаа | Багшийн дэмжлэг, арга зүй | Эцэг, эхийн дэмжлэг, туслалцаа | Улирлын үнэлгээ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сурагчийн үнэлгээ | Багшийн үнэлгээ | Үнэлгээ өгсөн хүний нэр |
| | 1-р улирал | | | | | | | |
| | 2-р улирал | | | | | | | |
| | 3-р улирал | | | | | | | |
| | 4-р улирал | | | | | | | |
| | 1-р улирал | | | | | | | |
| | 2-р улирал | | | | | | | |
| | 3-р улирал | | | | | | | |
| | 4-р улирал | | | | | | | |

* Зөвхөн урт хугацааны зорилтын дэмжлэгийн орчин хэсэгт тусгагдсан тохиолдолд ашиглана.

**4. Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж**

Суралцагчийн овог, нэр ...................................................... Анги, бүлэг ........ Хүйс ........ Төрсөн огноо (нас) ............................

| № | Урт хугацааны зорилт | Дүгнэлт | |
|---|---|---|---|
| | | Ололт, амжилт | Сайжруулах чиглэл, зөвлөмж |
| | | | |
| | | | |
| | | | |

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн
нэр, гарын үсэг ........................................./......................................./ огноо: □□□□ □□ □□

Танилцсан, эцэг (эх, асран хамгаалагч)-ийн
нэр, гарын үсэг ........................................./......................................./ огноо: □□□□ □□ □□

Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/155 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

### Удиртгал

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө /цаашид "ГСТ" гэх/, нь хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэгийг үзүүлэх хэрэглэгдэхүүн бөгөөд тухайн хүүхдэд чанартай боловсрол олгох нөхцөл боломжийг бүрдүүлэх арга зам юм.

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, хөдөлгөөний хөгжил үе тэнгийн хүүхдүүдтэй нь харьцуулахад харьцангуй удаан байх тохиолдол байдаг учраас тэдэнтэй нэг ижил агуулгаар суралцах, анги, хамт олноороо хийх үйл ажиллагаанд оролцоход бэрхшээл учирдаг. Энэхүү шалтгааны улмаас ГСТ боловсруулж, хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлж, тухайн хүүхдийг хөгжүүлэх боломжтой.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, хөгжлийн дэмжлэгийн тогтолцоог бий болгох, бэхжүүлэх "ЖАЙКА Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийг 2015 оны 8 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн. Тус төслийн хүрээнд 2015 оны 12 дугаар сараас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Нийслэлийн боловсролын газар, Монгол Улсын Боловсролын их сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Ерөнхий боловсролын оюуны бэрхшээлтэй хүүхдийн тусгай 4 сургуультай хамтран "ГТС"-ний үлгэрчилсэн загварыг боловсруулж, тэдгээр сургууль дээр туршин, сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

ГСТ нь сурагч бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, төлөв байдлын тухайн үеийн үнэлгээг багтаасан, тэрхүү үнэлгээнд суурилсан урт, богино хугацааны зорилт, сургалтын агуулга, багшийн дэмжлэг, арга зүй зэргийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ хийх үйл ажиллагааг нэгтгэн хөтлөх баримт бичиг юм. Тус ГСТ боловсруулах үйл ажиллагаанд анги удирдсан багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага, эмч зэрэг бусад холбогдох хүмүүс оролцож, хамтран боловсруулах шаардлагатай. Тэгснээр тухайн сурагчийн хөгжлийг илүү дэмжиж, чанартай боловсрол олгох үйл ажиллагааг зохих түвшинд зохион байгуулж чадна.

### ГСТ-ний зорилго

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, түүнд тохирсон тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг үзүүлэх

2. Хүүхдийн хөгжлийн бодит байдалд тулгуурлан сургуулийн болон гэрийн орчинд тухайн хүүхэдтэй ажиллах сургалтын агуулга, багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийн тогтолцоог тодорхойлж, хэрэглэх

3. Сурагчийн хөгжлийн ахицыг үнэлж, түүний ахуй амьдрал, суралцах үйлд тулгарч буй бэрхшээлийг арилгах

ГСТ-ийг боловсруулахад баримтлах зарчим:

- Суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, түүний хөгжлийг дэмжсэн байх;
- Зорилт биелэгдэхүйц байх;
- Хүүхдэд дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- Тогтоосон хугацаанд шинэчлэн боловсруулж байх;
- Оролцогч талууд харилцан хүлээн зөвшөөрсөн байх;
- Нууцлалыг чанд хадгалах.

ГСТ-өөр хичээллэх хүсэлтийг гаргах, шийдвэрлэх арга зам:

- ГСТ-өөр хичээллэх хүсэлтийг сурагч, эсвэл эцэг, эх, асран хамгаалагч, эсвэл анги удирдсан багш гаргаж болно.
- Хүсэлт гаргасан тохиолдолд гурван тал /сурагч, эцэг, эх, хариуцах багш/-ын уулзалтыг анги удирдсан багш зохион байгуулна.
- Сурагч, эцэг, эх ба асран хамгаалагч нь суралцагчийн ГСТ-г боловсруулахад санал, хүсэлтээ илэрхийлж, түүний агуулгад тусгуулж болно.
- Сонирхогч талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр ГСТ-өөр хичээллэхээр болбол холбогдох материалыг бүрдүүлэн сургуулийн комисст хандана.
- Сургуулийн комисс хуралдаж, эцсийн шийдвэрийг гаргана.
- Сургуулийн комисст тухайн сургуулийн захирал, сургалтын менежер, заах аргын нэгдлийн ахлагч, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш, судлагдахуун болон заслын багш зэрэг хүмүүсийн төлөөлөл орно.

ГСТ-ний үлгэрчилсэн загварын бүтэц:

1. Сурагчийн бодит байдлын судалгаа
2. Урт хугацааны зорилт, дэмжлэгийн орчин
3. Богино хугацааны зорилт, багш, мэргэжилтний дэмжлэг, арга зүй, үнэлгээ
4. Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж
5. ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлс

Тус ГСТ-г боловсруулах аргачлал нь ГСТ-ний үлгэрчилсэн загварыг хөтлөх арга зүй, цаашид тухайн хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, хувь хүний зан чанар, ур чадвар, чадамжийн түвшинд нийцүүлэн өөрчлөн боловсруулахад анхаарах зүйлсийг тус тус багтаасан болно.

Хөтлөх заавар

**Нэг**. "Сурагчийн бодит байдлын судалгаа" хэсэгт бичигдэх мэдээллийг сурагчийн эцэг, эх /асран хамгаалагч/-ээс асууж бөглөнө. Үүнд:

1.1. "Сургуулийн комиссын хуралдааны огноо" гэсэн хэсэгт Сургуулийн комисс хуралдаж, тухайн сурагчийг ГСТ-өөр хичээллүүлэх шаардлагатай гэсэн шийдвэр гаргасан бол тус хуралдааны огноог "он, сар, өдөр" гэсэн дараалын дагуу бичнэ.Жишээлбэл, 2000-05-12 гэх мэт.

1.2. "Сурагчийн овог, нэр" хэсэгт сурагчийн "Төрсний гэрчилгээ-нд байгаа овог, нэрийг бичнэ. Сурагчийн удам судрын овгийг хэрэглэхгүй болно. Жишээлбэл, Доржийн Бат

1.3. "Регистрийн дугаар □□ □□□□□□□□" хэсэгт бичигдэх мэдээллийг сурагчийн "Төрсний гэрчилгээ"-нээс харж бичнэ.Жишээлбэл: ХЕ 93050253 гэх мэт

1.4. "Сургуульд элсэн орсон огноо (нас)" хэсэгт тухайн сурагчийн ерөнхий боловсролын сургалтын байгууллагад анх элсэн орсон огноог "он, сар, өдөр" гэсэн дарааллын дагуу бичихээс гадна мөн "нас"-ыг хаалтад бичнэ. Харин тухайн сургуульд элсэн орсон, эсвэл шилжин ирсэн огноо болон насыг бичихгүй болно. Жишээлбэл: 2000-09-01 (7 нас) гэх мэт.

1.5. "Анги, бүлэг" хэсэгт хэддүгээр ангийн ямар бүлэгт сурч байгааг бичнэ. Жишээлбэл,"2б" гэх мэт.

1.6. "Хүйс" хэсэгт "эр", эсвэл "эм"хоёрын аль нэгийг сонгож бичнэ.

1.7. "Төрсөн огноо" хэсэгт сурагчийн төрсөн огноог "Он, сар, өдөр" гэсэн дараалаар бичнэ.Жишээлбэл, 1993-05-02 гэх мэт.

1.8. "Ам бүлийн тоо" хэсэгт сурагчийн өрх гэрт бүртгэлтэй хүний тоог бичнэ. Жишээлбэл, Аав, ээж, хүүхэд, түүний дүү байгаа бол ам бүлийн тоо 4болно.

1.9. "Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд" хэсэгт тухайн өрх айлын гишүүдээс гадна хамт амьдарч буй гэр бүлийн гишүүд, хамаатан, төрөл садангийн хамаарлын нэршлийг бичнэ. Жишээлбэл: аав, ээж, эрэгтэй дүү, би, өвөө, нагац ах гэх мэт.

1.10."Гэр бүлийн харилцааны төлөв байдал" хэсэгт хүүхэд маань айлын хэд дэх хүүхэд болох, тухайн гэр бүлийхэн тухайн хүүхэдтэй хэрхэн харьцдаг, ямар бэрхшээлтэй асуудал тулгардаг, хэрхэн шийддэг талаар дэлгэрэнгүй асууж лавлаж бичнэ.\хэт эрхлүүлэх, шоовдорлох, үл тоох, дохиогоор харилцдаг гэх мэт\

1.11."Цэцэрлэгт явсан эсэх"хэсэгт □Тийм/ □Үгүй гэсэн хариултын аль нэгийг сонгож, "√" тэмдэглэгээг ашиглан бөглөнө.

1.12.Хэрвээ "тийм" гэж хариулсан бол Цэцэрлэгийн нэрийг бичнэ. Хамрагдсан насыг

тодорхой бичнэ. Харин “үгүй” гэж хариулсан бол “яваагүй шалтгаан”-ыг сайтар асууж бичнэ. Цэцэрлэгт хамрагдаагүй шалтгааныг аль болох тодорхой асууж бичих хэрэгтэй. Жишээлбэл, -Зөөх хүн байгаагүй; -Цэцэрлэг олдоогүй гэх мэт

1.13.“Эцэг, эх /асран хамгаалагч/-ийн нэр” хэсэгт тухайн сурагчийн бодит байдлын үнэлгээ хэсгийн ярилцлагад орж мэдээлэл өгч байгаа эцэг, эх /асран хамгаалагч/-ийн нэрийг бичнэ. Мөн энэ хэсэгт тухайн эцэг, эх /асран хамгаалагч/ нь сурагчтай ямар төрөл саданэгийн холбоо хамааралттай болох (ээж, эсвэл аав гэх мэт)-ыг тодорхой бичихээс гадна түүнтэй холбоо барих утас, и-мэйл хаягийг асууж тэмдэглэнэ.

1.14.“Оршин суугаа хаяг” хэсэгт эцэг, эх/асран хамгаалагч/-ийн иргэний үнэмлэх дээр бичигдсэн эсвэл, шилжин ирсэн тэмдэглэл бүхий хуудсыг ашиглан хаягийг тодорхой бичнэ. Жишээлбэл, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, 34-р байр, 5 тоот гэх мэт.

1.15.“Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт” хэсэгт ерөнхий боловсролын тусгай сургуулийн “Эмнэлэг, сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт хийлгэж байсан бол тухайн хуралдаан зохион байгуулагдсан огноо, гаргасан шийдвэр буюу тавьсан оношийг бичихээс гадна бэрхшээлийн нэрийг сонгож, , “√” тэмдэглэгээг ашиглан бөглөнө.

- Сурагчид тавьсан онош бэрхшээлийн нэрсийн жагсаалтад байхгүй тохиолдолд “Бусад” гэдгийг сонгож, тухайн бэрхшээлийн нэрийг бичнэ.

- “Дагалдах өвчин, эмгэгийн тухай мэдээлэл” хэсэгт тухайн сурагч өөрийн хөгжлийн бэрхшээлээс гадна эрүүл мэндийн хувьд ямар нэг дагалдах өвчин, эмгэгтэй байх ахул дэлгэрэнгүй нэг бүрчлэн бичиж, тэмдэглэнэ.Жишээ нь: Уналт таталт, зүрхний өвчин, арьсны өвчин гэх мэт/-ийг бичнэ.

1.16.“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүгнэлт” хэсэгт тус комиссын хурлаар орж “Комиссын шийдвэр” гарсан бол агуулгыг бичнэ.

1.17.“Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж, оношлуулсан эсэх” хэсэгт сурагч өөрийн хөжглийн бэрхшээл, өвчин эмгэгийн улмаас эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж оношлуулж байсан бол “□Тийм/ □Үгүй” гэсэн хариултын аль нэгийг сонгож, “√” тэмдэглэгээг ашиглан бөглөнө.

- Хэрвээ “тийм” гэж хариулсан бол үзлэг, оношилгоонд орсон эрүүл мэндийн байгууллагын нэр болон тавьсан оношийг тус тус бичнэ.

1.18.“Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх” хэсэгт гадаад, дотоодын байгууллагын үзлэгт хамрагдаж, оношилгоо, үнэлгээ хийлгэж байсан бол тухайн үр дүнг нь бичнэ.

- Хэрвээ “тийм” гэж хариулсан бол сори ын нэр, үнэлгээ хийсэн байгууллагын нэр,

үнэлгээний үр дүнг тус тус бичнэ. Жишээ нь:

- Сурагч оюун ухааны сорил буюу “IQ”-гийн үнэлгээ хийлгэсэн бол тус IQ-гийн үнэлгээнд авсан оноог бичнэ.
- Хөгжлийн үнэлгээний сорил /“Векслерийн оюун ухааны сорил”, “Бэйлигийн нялхсын хөгжлийн сорил”, “Денверийн хөгжлийн тандалтын сорил” гэх мэт/-д хамрагдсан бол сорилын үнэлгээг бичнэ.
- Өөр бусад оношилгоо, үнэлгээний сорилд хамрагдаж байсан бол тухайн сорил, үнэлгээний үр дүнг бичнэ.

1.19.“Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх” хэсэгт тухайн сурагч өөрийн өвчин, бэрхшээлийн улмаас байнгын эмнэлгийн хяналтад байдаг бол “□Тийм/ □Үгүй” гэсэн хариултын аль нэгийг сонгож, “√” тэмдэглэгээг ашиглан бөглөнө.

- Хэрвээ “тийм” гэж хариулсан бол тус эрүүл мэндийн байгууллагын нэр, тавьсан онош, хяналтын дагуу ямар хугацаа, давтамжтай үзүүлдэг зэргийг тодорхой бичнэ.

1.20.“Төрсний дараахи /0-24 сар хүртэл/ хүүхдийн хөгжлийн түвшингийн онцлог байдал” хэсгийн мэдээллийг эцэг, эх, асран хамгаалагчаас асууж, эсвэл зарим мэдээллийг “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ээс харж бичиж болно. Гол нь эх, хүүхдийн эрүүл мэндийн байдал ямар байсан, ямар нэг хүндрэлтэй асуудал тулгарсан эсэх, оношилгоо, эмчилгээ хийлгэж байсан эсэх талаар дэлгэрэнгүй асууж тэмдэглэл хөтөлнө.

1.21.“Сургуульд бэлтгэгдсэн байдал /2-5 нас/” хэсэгт сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байх үедээ эзэмшсэн чадвар, чадамжийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/301 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас”-ыг ашиглан эцэг, эх, асран хамгаалагчаас асууж тэмдэглэхээс гадна эх хүүхдийн эрүүл мэндийн байдал, цэцэрлэгт хамрагдсан үеийн байдал, эсвэл гэрээр хүмүүжиж байх үеийн байдал зэргийг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн тэмдэглэлээс харах эсвэл эцэг эх, асран хамгаалагчаас асууж бичнэ. /Хавсралтаас үзнэ үү/. Жишээлбэл:

- 3 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бойжилтыг Биеийн хөдөлгөөнөө удирдах чадвар, Нийгэмшихүйн чадвар, Оюун ухааны чадварын байдлаар тодорхойлно.

- 3-6 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бойжилтыг Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж, Нийгэмшихүйн чадамж, хэл, ярианы чадамж, Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамжийн байдлаар тодорхойлно.

1.22.“ГСТ”-нд хамрагдах үеийн хөгжлийн түвшингийн байдал” хэсэгт сурагчийн ГСТ-өөр хичээллэх үеийн буюу хөгжлийн түвшингийн гарааны нөхцөл байдлын талаар дор дурдсан 5 үзүүлэлтийн дагуу түүний эцэг, эх /асран хамгаалагч/ -аас асууж тэмдэглэнэ.

- “Өөртөө үйлчлэх энгийн чадвар” хэсэгт гараа угаах, гутлаа өмсөх, тайлах чадварын талаар асуухаас гадна туслах хэрэглэгдэхүүн хэрэглэдэг эсэх /таяг, тэргэнцэр гэх мэт/, хэрэглэдэг бол сургуулийн орчинд ямар нэгэн хүндрэл учирдаг эсэхийг тодруулна.

- “Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол” хэсэгт үсэг, тоо тоолол,өнгө ялгах гэх мэт үйл ажиллагааг ямар түвшинд хийдэг талаар тодруулна.

- “Нийгэмшихүй” хэсэгт бусадтай харьцах, бусдыг дуурайх, өөрийгөө илэрхийлэх арга барил, дүрэм журмыг дагах гэх мэт байдлын талаар тодруулна.

- “Бие бялдар, хөдөлгөөн” хэсэгт алхах, гүйх, тэнцвэр, бөмбөг шидэх гэх мэт үйлийг хэрхэн хийж гүйцэтгэдэг талаар асууж тодруулна.

- “Анги удирдсан багшийн тодорхойлолт” хэсэгт тухайн сурагчийн зан төлөв, суралцахуйн бэрхшээл, харилцах чадвар, гэр бүлийн харилцааны тухай юуг анхаарах, түүнтэй харьцахад хэрэглэх арга зүйн талаар өөрийн ажигласан зүйлсийг анги удирдсан багш тэмдэглэнэ.

1.23.“Оролцогч талуудын хүсэл, зорилго” хэсэгт энэхүү ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэснээр сурагч\хүүхдийн сонирхлыг бичнэ\, эцэг эх,асран хамгаалагч, багш тус бүрийн юунд хүрэхийг зорьж буй хүсэл зорилгыг асууж тодорхой бичнэ.

- “Сурагчийн хүсэл” хэсгийг хоосон орхиж болохгүй. Сурагч өөрийн хүсэл, сонирхлоо илэрхийлж чадсан тохиолдолд бичих, эсвэл өөрийн хүсэл, сонирхлоо бие даан илэрхийлэх чадамжгүй тухай бичиж тэмдэглэнэ.

1.24.Энэхүү хэсгийн мэдээллийг бүрэн бөглөсөн гэж үзсэн тохиолдолд тэмдэглэл хөтөлсөн багш болон сурагчийн эцэг, эх /асран хамгаалагч/ нар танилцан гарын үсэг зурна.

**Хоёр.** “Урт хугацааны зорилт” хэсэгт сурагчийн тухайн хичээлийн жилд эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн хүрэх түвшинг тодорхойлж дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхэд үзүүлэх дэмжлэгийн орчинг сонгож бичнэ.

2.1. Тус хэсгийн хүснэгтийн дээд талд “Сурагчийн овог нэр”, “Анги, бүлэг”, “Хүйс”, “Төрсөн огноо” зэргийг дахин бичнэ.

2.2. “Урт хугацааны зорилт” хэсэгт сурагчийн тухайн хичээлийн жилд эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн хүрэх түвшинг хүүхдийн хөгжлийн айн түвшинд нийцүүлэн зөвхөн шаардлагатай “ай”-н хувьд зорилтыг тодорхойлж бичнэ. Бүх “ай”-г заавал хамрах албагүй.

- Сурагчийн урт хугацааны зорилтыг тодорхойлоход хүүхдийн хөгжлийн айн

ангиллыг ашиглана.

Жишээлбэл:“.......-г хийж чадна” гэж бичихдээ дэлгэрэнгүй, тодорхой бичнэ. “1-5 хүртэлх цифрийг мэднэ” гэх төдий биш харин “1-5 хүртэлх цифрийг бичдэг, уншдаг, тооны утгыг ойлгодог, цифр болон тоог харьцуулж, харгалзуулж чадна” гэх мэтээр хүүхдийн хөгжлийн бодит байдал, чадамжийн хүрэх түвшинг аль болох дэлгэрэнгүй, тодорхой зорилт болгон тодорхойлно.

**Өөртөө үйлчлэх энгийн чадвар**
- Хувцсаа солих
- Хооллолт
- Гар угаах
- Гутлаа өмсөж, тайлах
- Туслах
- Сургуульдаа өөрөө ирж, очих
- Дэлгүүр явах
- Автобусанд суух гэх мэт

**Хэд яриа, танин мэдэхүй, тоо тоолол**
- Хэлбэр
- Өнгө
- Тоо
- Хэмжээ
- Үсэг унших, бичих
- Төстэй зүйлээр орлуулан тоглох

**Нийгэмшихүй**
- Дуурайх
- Дохио зангаа ашиглан ярилцах
- Дүрэм журмыг дагах г.м

**Хөдөлгөөн**
- Бөмбөг шидэх
- Алхах, гүйх
- Модон шоо өрөх
- Товч товчлох
- Гутлаа үдэх
- Ямар нэг зүйлийг гаргах, хийх г.м

2.3. “Дэмжлэгийн орчин” хэсэгт “Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг”, “Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг”, “Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг” гэсэн 3 төрлийн дэмжлэгийн орчинг хэрхэн бүрдүүлж, хэзээ, ямар чиглэлийн дэмжлэг үзүүлэхийг тодорхойлж бичнэ. Тодруулбал,

**Сургуулийн амьдрал дахь хичээлийн бус цагийн үйл ажиллагаа**
- Сургуульд өөрөө ирж очих
- Хооллолт
- Бие засах г.м

**Засан сайжруулах, дэмжлэг үзүүлэх сургалтын цаг**
- Хэл яриа
- Эмчилгээний биеийн тамир

**Судлагдахуунаар**
- Монгол хэл
- Математик
- Ахуй засал
- Байгалийн ухаан
- Дуу хөгжим
- Биеийн тамир

Жишээлбэл, Б.Оргилын хувьд:

| Хөгжлийн ай | Урт хугацааны зорилт | Дэмжлэгийн орчин | | |
|---|---|---|---|---|
| | | Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг | Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг | Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг |
| Өөртөө үйлчлэх энгийн чадвар | Хувцасны шүүгээгээ олоод хувцсаа өөрөө хийх, авах | Хичээл эхлэхээс өмнө, хичээл дууссаны дараа | | |
| Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол | Үндсэн 3 өнгө, дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг ижлээр нь олох | | | Математик, |
| Нийгэмшихүй | Сууж сургах, уух хэрэгцээг нь зурган карт ашиглан илэрхийлж сургах | -Сургуульдаа ирэх, тарах үед багштайгаа<br>-Найз нөхөдтэй уулзахдаа | Ахуй засал | Нийгэм ахуйн баримжаа |
| Бие бялдар, хөдөлгөөн | | | | |

**Гурав:**“Богино хугацааны зорилт” хэсэгт өмнөх буюу “Урт хугацааны зорилт”-д хүрэх алхмыг хэд хэдэн богино хугацаанд хуваан 3 дэмжлэгийн орчин тус бүрээр зорилт болгон тодорхойлох бөгөөд багшийн хэрэглэх арга зүй, үзүүлэх дэмжлэг зэргийг тус тус тодорхойлж бичнэ. Жишээлбэл, богино хугацааны зорилт нь улирлаар эсвэл хагас жилээр тодорхойлогдож болно.



3.1. “Сурагчийн овог нэр”, “Анги, бүлэг”, “Хүйс”, “Төрсөн огноо” зэргийг дахин бичнэ.

3.2. Урт хугацааны зорилтыг өмнөх хуудаснаас хуулбарлан бичнэ. Учир нь урт хугацааны зорилт хэсэгт бичигдээгүй зорилтыг богино хугацааны зорилтын хүснэгтэд бичихгүй болно.

3.3. Богино хугацааны зорилтын дэмжлэгийн орчин \хэзээ, хаана\ гэсэн хэсэг дээр “урт хугацааны зорилт” хэсэг дээр сонгогдсон дэмжлэгийн орчинг “Урт хугацааны зорилт” хуудсаас шууд хуулбарлан бичнэ.

3.4. Богино хугацааны зорилт нь тухайн сурагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлага, чадамжтай уялдуулан урт хугацааны зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн үе шаттай хэрэгжүүлэх улирлын зорилтууд байна.

3.5. “Сурагчийн хийх үйл ажиллагаа” хэсэгт бичигдсэн “Өөртөө үйлчлэх энгийн чадвар”, “Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол”, “Нийгэмшихүй”, “Бие бялдар, хөдөлгөөн” гэсэн хөгжлийн айн хувьд харгалзах хүүхдийн зарим чадвар, чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн хүрэх зорилтыг бичнэ. Энэ хүснэгтэд бичигдэх сурагчийн үйл ажиллагааг нь ямагт “Сурагч” гэсэн үгээр эхэлбэл зохино.

3.6. “Багшийн дэмжлэг арга зүй” хэсэгт тухайн хүүхдийн тавьсан зорилгодоо хүрэхэд хэрхэн яаж туслах, хүүхдийн мэдлэг, ур чадварын ямар түвшинг яаж ахиулахын тулд, ямар агуулга судлах, ямар даалгавар хийлгэх, ямар үйлдэлд сургах,ямар арга зүй хэрэглэх, ямар дэмжлэг туслалцаа үзүүлэхийг тодорхой үе шатны дагуу бичнэ. Бичихдээ “Багш” гэсэн үгээр эхлүүлбэл зохино.

- Энэ хэсэгт багшийн арга зүйн нэрийг Тоглоомын арга, Хуулбарлан таниулах, Үлгэрлэн үзүүлэх, Дүрд тоглох, Тулгуур дохио, Эвлүүлдэг тоглоомын арга гэх бичих биш үйлдэл тус бүрээр нарийвчлан бичнэ.

3.7. “Эцэг эхийн дэмжлэг, туслалцаа” хэсэгт богино хугацааны зорилтыг хэрэгжүүлэхэд гэрийн орчин нөхцөлд эцэг, эх \асран хамгаалагч\ ямар дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг тодорхой бичиж, тэдэнд хлбогдох заавар зөвлөгөөг өгнө. Эцэг эх нь \асран хамгаалагч\ багштай хамтран төлөвлөнө.

3.8. “Улирлын үнэлгээ” хэсэгт суралцагчийн тухайн хугацаанд тавьсан зорилтоо биелүүлсэн явцад хийсэн багшийн ажиглалтын тайлан буюу сурагчийн суралцах үйл явцын үнэлгээ, түүний гаргасан ахиц амжилтыг бичиж богино хугацааны зорилт хэрхэн биелэгдсэнийг үнэлж бичнэ. Тус үнэлгээ нь 2 хэсэг бүхий мэдээллээс бүрдэнэ:

- Эхлээд “Суралцагчийн үнэлгээ” хэсэгт сурагчийн улирлын зорилт биелсэн эсэх, хөгжлийн ахиц, дэвшил гарсан эсэх, эсвэл урьдчилан таамагласан ахиц, дэвшил хангалттай гараагүй учир, шалтгааныг тодорхой бичиж, дараахь үнэлгээг ашиглан үнэлгээг хийнэ. Үүнд:

1. Маш сайн
2. Хангалттай
3. Сайжирч байгаа

- Дараа нь “Багшийн үнэлгээ” хэсэгт тухайн улирлын зорилт хүүхдийн хэрэгцээ шаардлагад хэр нийцсэн, багшийн сонгосон арга зүй тохирсон эсэх, хүүхдийн ахицыг сургуулийн орчинд төдийгүй гэрийн орчинд хэрхэн дэмжин ажилласан, цаашид анхаарах зүйлсийг тодорхой бичнэ.

3.9. Дэмжлэгийн орчин тус бүрээр хуудсыг нэмж бөглөнө.

3.10. Богино хугацааны зорилтыг биелүүлэхэд “Хичээл, судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг”-ийг тодорхойлохдоо хүүхдийн өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай, хэрэгтэй мэдлэг, чадварыг хичээлийн агуулгадаа сонгон оруулах хэрэгтэй.

- Энэ хэсгийн зорилтын сурагч Б.Оргилын хувьд хэрхэн бөглөсөн жишээг үзнэ үү.

**Богино хугацааны зорилт:**

| Дэмжлэгийн орчин /хэзээ, хаана/ | Улирал | Богино хугацааны зорилт | Сурагчийн хийх үйл ажиллагаа | Багшийн дэмжлэг, арга зүй | Эцэг, эхийн дэмжлэг, туслалцаа |
|---|---|---|---|---|---|
| Хичээл эхлэхээс өмнө хичээл дууссаны дараа | 1-р улирал | Хувцасны шүүгээгээ олох | Сурагч өөрийн хувцасны шүүгээн дээр байгаа таних тэмдгийг таних | Багш хувцасны шүүгээн дээр нь улаан дугуй дүрсийг нааж, өөрийнх нь хувцасны шүүгээ болохыг таниулж, таних тэмдгийг нүдлүүлнэ. Хувцасны шүүгээний харалдаа чиглүүлэх тэмдгийг байршуулах | Гэрийн хувцасны шүүгээн дээр улаан дугуй дүрсийг нааж өгөх, өөрийн шүүгээ гэдгийг мэдүүлэх |

**Дөрөв.** Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж хэсэгт “Богино хугацааны зорилт” хэсэгт бичигдсэн “Улирлын үнэлгээ” хэсгийн үнэлгээнд тулгуурласан дүгнэлтийг “Ололт амжилт” болон “Сайжруулах чиглэл, зөвлөмж” гэсэн үзүүлэлтийн дагуу анги удирдсан багш бичнэ.

4.1. “Сурагчийн овог нэр”, “Анги, бүлэг”, “Хүйс”, “Төрсөн огноо (нас)” зэргийг дахин бичнэ.

4.2. “Урт хугацааны зорилт” хэсэгт тухайн хичээлийн жилд сурагч биелүүлэх “Урт

хугацааны зорилт" хэсэгт бичигдсэн зорилт тус бүрийг нэг бүрчлэн хуулбарлан бичнэ.

4.3. "Ололт амжилт" хэсэгт Урт хугацааны зорилтыг биелэлтийн явцыг үнэлж, сурагчид гарсан эерэг өөрчлөлт, ололт, амжилт, ахицыг тус тус бичнэ.

4.4. "Сайжруулах чиглэл, зөвлөмж" хэсэгт урт хугацааны зорилт нь хүүхдийн суралцах чадвар, чадамжид нийцсэн эсэх, багшийн гаргасан алдаа, дутагдал зэрэгт тулгуурлан дараагийн хичээлийн жилд ГСТ-өөр хичээллэх эсэх, хичээллэх тохиолдолд сурагчийн хувьд тавих урт хугацааны зорилт, сургуулийн орчин болон гэрийн нөхцөлд үзүүлэх дэмжлэг, туслалцааны талаархи чиглэл, зөвлөмжийг тус тус бичнэ. Жишээлбэл:

**Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж :**

| Урт хугацааны зорилт | Дүгнэлт | |
|---|---|---|
| | Суралцагчийн үнэлгээ \ололт амжилт\ | Сайжруулах чиглэл, зөвлөмж |
| Хувцасны шүүгээгээ олоод хувцсаа өөрөө хийх, авах | Хувцасны шүүгээний таних тэмдэг болох "улаан дугуй" дүрсийг багшийн тусламжтай олдог болсон боловч өөрөө бие даан гүйцэтгэж чадахгүй байгаа учраас "сайжирч байгаа" гэж үнэлж байна. | Багшийн зааврын дагуу хувцасны шүүгээгээ өөрөө бие даан олж, хувцасны шүүгээ нээж хувцсаа хийдэг болсон. Харин бие дааж гүйцэтгэж чадахгүй байгаа тул тус зорилт нь сурагчийн чадвар, чадамжид ахадсан байна. Иймд тус чадварыг сурагч өөрөө бие дааж гүйцэтгэх зорилтыг дараагийн хичээлийн жилд ГСТ-өөр хичээллэх явцад олгох. Багшийн зүгээс тухайн хүүхдийн сонирхолд тулгуурласан аргыг ашиглах шаардлагатай. Эцэг, эхийг гэрийн нөхцөлд туслан дэмжих арга зүйд сургахад анхаарах. |

**Тав**. ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлс:

5.1. Зорилтыг эерэг хэлбэрээр бичнэ. Жишээ нь: "Завсарлагааны цагаар гүйхгүй" гэх биш харин "Завсарлагааны цагаар гүйлгүй, алхаж дараагийн үйл ажиллагаа руу шилжинэ" гэх мэт.

5.2. Ямар зүйлийг чаддаг болох тухай дэлгэрэнгүй тодорхой бичих

5.3. Богино хугацааны зорилт нь тавьсан хугацаандаа биелэгдэхүйц байхаар бичнэ.

5.4. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн давуу ба сул тал, онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзсан байх

5.5. Арга зүйн дэмжлэг үзүүлэх явцад тухайн хүүхдэд ахиц гарах бүрт урамшуулан дэмжих олон талт аргыг хэрэглэн итгэл төрүүлдэг байх

5.6. Хүүхдэд эзэмшүүлж буй мэдлэг, дадал чадварыг хэрэглээ болгон хэвшүүлэхэд гэрийн нөхцөлд яаж хамтран ажиллахыг тусгахыг эрмэлзсэн байх.

5.7. Хүүхдийн хүрч чадах түвшинг хэт ахиулан тавихгүй байх

5.8. Багш нар хамтарч ажилласан байх

5.9. Улирал бүрд хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэн ГСТ-нд өөрчлөлт оруулах эсэхийг нягталж байх

5.10.Хичээлийн явц дахь хүүхдийн байдалд ажиглалт хийн, цаашид анхаарах бусад анхаарах зүйлийн талаар бичих

5.11.Үнэлгээ хийх явцад, хичээлийн явц дахь хүүхдийн байдлыг нэмээд, хүүхдийн бүтээл, тарааж өгөх материал, тест, багшийн тэмдэглэл зэргийг ашиглан үнэлгээ хийх

5.12.Эцэг эх, асран хамгаалагчтай нь мэдээлэл солилцон, гэртээ байх үеийн байдалд нь дүн шинжилгээ хийж түүнийгээ мөн үнэлгээндээ тусгана.

5.13.Дэвшүүлсэн зорилт, арга зүй, багшийн дэмжлэгийн үнэлгээ нь дараагийн улирлын богино хугацааны зорилт болон арга зүйтэй холбох зорилготой үнэлгээ тул аль болох нарийвчлан тодорхой бичих

Хавсралт

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн
А/301 дугаар тушаалын хоердугаар хавсралт

# ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН АХИЦЫГ ҮНЭЛЭХ АЖИГЛАЛТЫН ХУУДАС

**ТАЙЛБАР:**

Хүүхэд тус бүрийн чадвараас хамааран "Чаддаггүй" бол 1, "Дэмжлэгтэй" бол 2, "Чаддаг" бол 3 гэсэн үнэлгээг хүснэгтэд тэмдэглэнэ. Нийт онооны дүнг тухайн хэсгийн чадварын тоонд хуваах "Гүйцэтгэлийн дундаж" гарна.

## 1. Биеийн хөдөлгөөнөө удирдах чадвар

| № | Чадвар | Чаддаг -гүй | Дэмж-лэгтэй | Чаддаг |
|---|---|---|---|---|
| 1.1 | Шалан дээр байгаа зүйлийг доош бөхийн барьж авна. | | | |
| 1.2 | Ор болон өндөр сандал дээр гарч, бууж чадна. | | | |
| 1.3 | Том хайрцагт юмсыг зөөж хийнэ. | | | |
| 1.4 | Хөтөвч, суултуурт бие засахдаа өөрөө сууж, босно. | | | |
| 1.5 | Шатаар өгсөж, уруудна. | | | |
| 1.6 | Аяга, халбагаа зөв барьж хэрэглэнэ. | | | |
| 1.7 | Зузаан (картонон) хуудастай номын хуудсыг нэг нэгээр нь эргүүлнэ. | | | |
| 1.8 | Бүдүүн харандаа, тосон харандаа ашиглаж, цаасан дээр зураас татна. | | | |
| 1.9 | Хувцсаа өөрөө тайлна. | | | |
| 1.10 | Гараа угааж, арчина. | | | |
| 1.11 | Цэвэрхэн хооллоно. | | | |
| 1.12 | "Болно", "Болохгүй" гэсэн энгийн зааврыг ойлгож биелүүлнэ. | | | |

## 2. Нийгэмшихүйн чадвар

| № | Чадвар | Чаддаг-гүй | Дэмж-лэгтэй | Чаддаг |
|---|---|---|---|---|
| 2.1 | Өөрийн эд юмсыг бусдынхаас ялгана. | | | |
| 2.2 | "Би өөрөө" гэж үйл хийхийг эрмэлзэнэ. | | | |
| 2.3 | Өөрийн хэрэгцээг дуу авиа, нүүрний хувирал, үгээр илэрхийлнэ. | | | |
| 2.4 | Ойр орчныхоо хүнтэй дотносоно. | | | |
| 2.5 | Тааламжтай байгаагаа илэрхийлнэ. (Жишээ нь: Хөгжим сонсоод инээмсэглэх, биеэрээ найгах) | | | |
| 2.6 | Өөртөө тааламжгүй байдлыг дуу авиа, үг, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлж, насанд хүрэгчдээс тусламж, чиглэл хүлээнэ. | | | |
| 2.7 | Юмсыг зориулалтаар нь хэрэглэнэ. (Жишээ нь: Харандаагаар зурах, халбагаар хоолоо идэх, хөтөвч хэрэглэх) | | | |
| 2.8 | Бусдын үйлдлийг ажиглана, дуурайна. (Жишээ нь: Хүүхэлдэй бүүвэйлнэ, хооллоно.) | | | |

## 3. Оюун ухааны чадвар

| № | Чадвар | Чаддаг-гүй | Дэмж-лэгтэй | Чаддаг |
|---|---|---|---|---|
| 3.1 | Хүн, амьтан, юмсыг зургаас таньж, асуухад зааж нэрлэнэ. | | | |
| 3.2 | Амьтдын дуу авиаг дуурайж дуугарна. | | | |
| 3.3 | Юмсыг төрлөөр нь ялгана. (Жишээ нь: Бөмбөг, машиныг тус тусад нь) | | | |
| 3.4 | Янз бүрийн хэмжээ, хэлбэртэй тоглоомоор тоглоно, асуухад "том", "жижиг"-ийг заана, хэлнэ. | | | |
| 3.5 | "Нэг", "Олон"-г ялгаж хэлнэ. | | | |
| 3.6 | Гэр болон цэцэрлэгт байгаа дуртай зүйлийнхээ байрлалыг мэднэ. | | | |
| 3.7 | Хогийг саванд нь хийнэ. | | | |
| 3.8 | Нэг үйлдэлт зааврыг дагана. (Жишээ нь: "Надад бөмбөг аваад ир" гэхэд авчрах) | | | |
| 3.9 | Богино өгүүлбэрээр ярина. (Жишээ нь: "Би явна", "Ээждээ өгнө") | | | |

**ТАЙЛБАР:**

Багш хүүхдийг тодорхой үйл гүйцэтгэх явцад ажиглаж, тухайн чадамжийг илрүүлэх асуултуудын ард дөрвөлжин буюу дугуй дотор байгаа 1-5 хүртэлх онооноос тохирох оноог сонгож тэмдэглэнэ. Дөрвөлжин доторх оноо нь хүүхдийн гүйцэтгэж буй үйлийн гүйцэтгэлийн чанар ямар байгааг ("тохирцоор"), дугуй дотор байгаа нь хүүхдийн сонирхол, сэдэл, дадал хэвшлийн эзэмшилт ямар байгааг (ажиглагдаж буй "давтамжаар" буюу хэр олон удаа "тохиолдож" байгаагаар) илрүүлнэ. Дөрвөлжин, дугуй доторх тооны аль аль нь ахих тутам хүүхдэд тухайн асуултын дагуу чанарын ахиц гарч байгааг илтгэнэ.

Багш оноо тус бүрийн ард буй тайлбарын утгыг маш сайн анхаарч, тохирох эсэхийг нягтлан тэмдэглэнэ. Бүх асуулт таглагдсаны дараа эхлээд тухайн чадамжийн хэсэг тус бүрийн онооны дүн, гүйцэтгэл (Онооны дүнг асуултын тоонд хуваана.)-ийг, дараа нь тухайн чадамжийн нийт оноог нэгтгэж, гүйцэтгэлийн дунджийг гаргана.

**Давтамж**

1. Огт тохиолддоггүй.
2. Хааяа нэг тохиолддог.
3. Байн байн тохиолддог.
4. Ихэнхдээ тохиолддог.
5. Дандаа / байнга тохиолддог.

**Тохироц**

1. Огт тохирохгүй байна.
2. Ховор тохирч байна.
3. Дундаж хэмжээнд тохирч байна.
4. Ихэнхдээ тохирч байна.
5. Яг тохирч байна.

## 1. ХӨДӨЛГӨӨН, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАДАМЖ

### 1.1. Биеийн хөдөлгөөнөө удирдах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.1.1 | Тэнцвэрээ хадгалан 20 см өргөн зураасан дундуур давж гишгэхгүйгээр аргаш ухарч явна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.2 | Дүүрэн устай ундааны шилэн аяга (стакан)-ыг нэг гартаа бариад усыг цалгиулахгүйгээр өрөөний нэг талаас нөгөө тал хүртэл алхана. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.3 | Тасалгаан дотор хурдаа тохируулж гүйнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.4 | Хөлийг салгалгүйгээр зураасны дагуу үсэрнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.5 | Шаланд ойлгож дамжуулсан бөмбөгийг алдахгүйгээр хоёр гараараа барьж авна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.6 | Хоёр гараараа дундаж хэмжээтэй (диаметр нь 10 см орчим) бөмбөгийг дээш шидээд, алдахгүй барьж авна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.7 | Нэг гараараа жижиг бөмбөгийг 1 метр орчим өндөрт шидээд, унагахгүй барьж авна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.8 | Байг алдахгүй ононо. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.9 | Цагаригийг нэг гараараа түрж өнхрүүлнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.10 | Налуу шатанд авирна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.11 | Хүүхдийн өндөрт тохирсон савлуураас нэг нэг гараараа ээлжлэн барьж, 1 метр зайд явна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.12 | Дээсэнд алдахгүйгээр 5 удаа үсэрнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1.13 | Өгсөн дохионы дагуу хөдөлгөөнөө эхэлж, дуусгана. | 1 | 2 | 3 | 4 | 5 |

### 1.2. Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.2.14 | Хувцсаа тайлж, өмсөнө. (Жишээ нь: Товчилно, цахилгаан татах, гутлаа үдэх.) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.2.15 | Гурваар жигд сүлжинэ. (олс, уяа) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.2.16 | Ирмэгүүдийг яг давхцуулан цаасан нугалбар хийнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.2.17 | Дүрсийг хүрээнээс гаргалгүй будна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.2.18 | Шагайг онож нясална. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.2.19 | Энгийн дүрсийг дууриалган зурна. (Жишээ нь: Гэр, мод, машин) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.2.20 | Дүрсийг хүрээний дагуу хайчилна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |

### 1.3. Эрүүл мэндээ хамгаалах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.3.21 | Гараа бохирдсон үед нь болон бие зассаны дараа сануулгагүйгээр угаана. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 1.3.22 | Хоолой, амаа бие даан зайлна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.3.23 | Бие зассаны дараа ариун цэврийн цаасыг бие даан зөв хэрэглэнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.3.24 | Хувцсаа орчин, үйл ажиллагаандаа тохируулан өмсөнө. (Жишээ нь: Гадаа тоглох, дасгал хөдөлгөөн хийхэд) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 1.3.25 | Сайн зажилж, тайван хооллоно. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 1.3.26 | Ямар хүнсний зүйл хүний биед сайн, мууг мэднэ. (Жишээ нь: Сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо; их хэмжээтэй чихэрлэг зүйл, хийжүүлсэн ундаа) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.3.27 | Хийж болохгүй, осолтой үйлдлүүдийг мэднэ. (Жишээ нь: Халуун зуухнаас хол байх, морь малын хөлд ойртохгүй байх) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 1.3.28 | Ангийн аюулгүйн дүрмийг мөрдөнө. (Жишээ нь: Хайчны амыг хаах, харандааны үзүүрийг доош харуулж өгөх) | ① | ② | ③ | ④ | ⑤ |

## 2. НИЙГЭМШИХҮЙН ЧАДАМЖ

### 2.1. Зан чанар

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Шинэ дасгал, даалгаврыг хийж үзэхдээ итгэлтэй байна. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.1.2 | Өөрийн хийх үйлээ сонгоно. (Жишээ нь: Сургалтын аль төвд ажиллах, ямар дүрд тоглох) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2.1.3 | Чадах зүйлээ бие даан гүйцэтгэнэ. (Жишээ нь: Тоглоомоо хураах, хувцсаа өмсөх, тайлах) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2.1.4 | Хийж бүтээсэн зүйлдээ баярлана. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.1.5 | Эхэлсэн зүйлээ хийж дуусгана. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.1.6 | "Болно, болохгүй", "Сайн, муу"-г ялгана. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2.1.7 | Шинэ зүйлд соргог хандаж сонирхоно, оролдож, туршиж үзнэ. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.1.8 | Бусад хүүхэд, томчуудаас өөр санал бодолтой байвал эмээхгүйгээр өөрийнхөө санааг хэлнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2.1.9 | Асуудал, зөрчлийг өөрийн хэр хэмжээнд шийдвэрлэнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |

### 2.2. Сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, удирдах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.2.10 | Тухайн нөхцөл байдалд тохирсон сэтгэл хөдлөлийг үзүүлж чадна. (Жишээ нь: Жүжгийн инээдэмтэй хэсгийг үзээд баясан инээх) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.2.11 | Магтаал, зэмлэлийг мэдэрч сэтгэгдлээ илэрхийлнэ. (Жишээ нь: Зэмлэхэд дуугаа хурааж дүнсийх, магтуулсан бол урамшин хийж буй зүйлдээ шамдах, нүүр царайд нь баясал тодрох) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.2.12 | Өөрийнхөө сэтгэл хөдлөлийн шалтгааныг тайлбарлана. (Жишээ нь: Яагаад уурласан, яагаад уйтгартай байгаа) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2.2.13 | Уур бухимдлаа тайван давж гарна. (Жишээ нь: Багшаараа аргадуулах, өөр зүйлд анхаарч хийх) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2.2.14 | Бусдыг мэдэрч, зохицон харилцана. (Жишээ нь: Нэгнийгээ уйлбал аргадах, найзынхаа тоглоомыг авахад дургүйцвэл буцаан өгөх) | 1 | 2 | 3 | 4 | 5 |

### 2.3. Бусадтай харилцах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.3.15 | Бусдын баяр баясгаланг хуваалцана. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2.3.16 | Цэцэрлэгтээ дуртай ирж, чөлөөтэй, таатай байдаг. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.3.17 | Өөрөө санаачилж, бусадтай харилцаа тогтооно. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.3.18 | Олны өмнө гарахаасаа айж сандрахгүй байна. (Жишээ нь: Үлгэр өгүүллэг ярих, дуулах, жүжигчлэн тоглох) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.3.19 | "Баярлалаа", "Уучлаарай" үгийг зохих тохиолдолд тогтмол хэрэглэнэ. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.3.20 | Бусдын тоглоом, эд зүйлсийг хэрэглэхдээ зөвшөөрөл авна. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.3.21 | Аливаа үйлийг гүйцэтгэхдээ өөрийн ээлжийг хүлээнэ. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.3.22 | Амлалтаа биелүүлнэ, бусдаас амлалтандаа хүрэхийг шаардана. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 2.3.23 | Дүрэм журам, зааврыг дагаж биелүүлнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |

## 3. ХЭЛ ЯРИАНЫ ЧАДАМЖ

### 3.1. Сонсох, ойлгох

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Байгалийн дуу чимээ, амьтдын дуу авиаг сонсож ялгана. (Жишээ нь: Усны чимээ, тэнгэрийн дуу, шувуудын жиргээ) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.1.2 | Урт, богино эгшигтэй үгийг ялгаж сонсоно. (Жишээ нь: сар-саар, ул-уул) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.1.3 | Ойролцоо дуудлагатай үгийг ялгаж сонсоно. (Жишээ нь: Энх мөнх, дэлгэр цэлгэр, яруу даруу) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.1.4 | Үлгэр зохиолыг анхааралтай, идэвхтэй сонсоно. (Жишээ нь: Ярьж байгаа хүний нүүр рүү харах, ойлгосон хэсгээ бусаддаа ярих, тайлбарлах, ойлгоогүй зүйлээ тодруулан асуух) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 3.1.5 | Үлгэр зохиолоос төрсөн мэдрэмжээ илэрхийлнэ. (Жишээ нь: Инээх, хөмсгөө зангидах, алга таших) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 3.1.6 | 2-оос цөөнгүй үйлдэл шаардах зааварчилгааг дагаж биелүүлнэ. (Жишээ нь: Эхлээд тоглоомоо хураана, дараа нь зурагтай номоо авч үзнэ) | 1 | 2 | 3 | 4 | 5 |

### 3.2. Ярих

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.2.7 | Бусдын асуултыг анхааралтай сонсож, тохирох хариулт өгнө. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.2.8 | Өөрийн санаа бодлоо ойлгомжтой илэрхийлнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.2.9 | Үлгэр, өгүүллэг, болсон үйл явдлыг бусдад ярина. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.2.10 | Ангиараа хийж буй ярилцлага, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоно. (Жишээ нь: Санаачилгаараа ярих, асуулт тавих) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 3.2.11 | Үлгэр, өгүүллэгийн өрнөл, төгсгөлийг гүйцээн зохиомжлон ярина. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.2.12 | Сайн мэдэх үлгэрийн агуулгыг зургийн дарааллын дагуу ярина. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.2.13 | Оньсого, түргэн хэллэг, зүйр цэцэн үг хэлнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.2.14 | Өөрөө зурагт ном бүтээж агуулгыг тайлбарлана. | 1 | 2 | 3 | 4 | 5 |

### 3.3. Унших, бичих бэлтгэл

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.3.15 | Номын зургийг тайлбарлан ярина. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.3.16 | Ойр орчиндоо буй тэмдэг, тэмдэглэгээг "унших" чадна. (Жишээ нь: Явган хүний гарц, автобусны зогсоол, түргэн тусламжийн машин) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.3.17 | Богино хэмжээний шүлэг уншина. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.3.18 | Зурган бүдүүвч ашиглан өгүүлбэр зохионо. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.3.19 | Өөрийн дуртай үлгэрийн баатрыг зурна. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3.3.20 | Төрөл бүрийн зураас зурна. (Жишээ нь: Цэг, ташуу, махир, тахир, нуман зураас) | 1 | 2 | 3 | 4 | 5 |

## 4. ОРЧНОО ТАНЬЖ МЭДЭХ, ОРЧИНТОЙГОО ХАРИЛЦАХ ЧАДАМЖ

### 4.1. Орчноо шинжлэн судлах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Байгаль орчинд болон туршилтын явцад ажигласан үзэгдлийн учир шалтгааны талаар асуулт тавьж, таамаглал дэвшүүлнэ. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 4.1.2 | Үйл явдал, учир шалтгааны талаар лавлана. (Жишээ нь: Яагаад ийм байдаг гэж?, Яагаад оройтсон бэ?) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 4.1.3 | Ургамлын ургалтад агаар, ус, гэрэл, дулаан яаж нөлөөлдгийг тайлбарлан ярина. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 4.1.4 | Байгаль шинжлэлийн туршилтад дуртай оролцоно. (Жишээ нь: Хөвөх, живэх, унах, хийсэх) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 4.1.5 | Юмсын шинж чанарыг сонирхоно, ялгана. (Жишээ нь: Хатуу-зөөлөн, хүнд-хөнгөн, гөлгөр-барзгар, гашуун-чихэрлэг, чанга-сул) | 1 | 2 | 3 | 4 | 5 |

### 4.2. Орчинтойгоо харьцах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.2.6 | Байгальд юу нь гоё сайхан байгааг илэрхийлэн ярина. | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 4.2.7 | Орчноо цэвэр байлгана. (Жишээ нь: Хогоо хогийн саванд хийнэ) | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 4.2.8 | Тоглосон, хэрэглэсэн зүйлээ буцааж байранд нь хураана. | ① | ② | ③ | ④ | ⑤ |
| 4.2.9 | Ургамлыг арчилж ургуулна. (Жишээ нь: Услах, арчих, хөрсийг сийрэгжүүлэх, хатсан навчийг түүх) | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 4.2.10 | Нутаг орныхоо гоё, сайхан зүйлийг дүрслэн зурна, тайлбарлана. | 1 | 2 | 3 | 4 | 5 |

# ХАВСРАЛТ МАТЕРИАЛ-2

Ээлжит хичээлийн хөтөлбөрийн загвар /хураангуй/





Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сйажруулах төсөл Хувилбар 1

“................................ хичээлийн” Ээлжит хичээлийн хөтөлбөр /Хураангуй/

........оны....... сарын.......өдөр .......цаг /......□.........□□.........□........./□□□□□□□□□ 1-р улирал□Эр..... □ Эм.......□Нийт.....

Хичээл заагч багш /МТ/ /Нэр/, Туслах багш /АТ/ /Нэр/

1. Ерөнхий агуулга /Бүлэг сэдвийн нэр:..................................... .. Нэгж хичээлийн нэр: .................................,

Ээлжит хичээлийн сэдэв “..........................................................”□□

2. Нэгж хичээлийн төлөвлөгөө /Нийт....цаг/□□□□□□□□□......-р цаг /Ээлжит хичээл/□

3. Хичээлийн агуулга

**(1) Ээлжит хичээлийн зорилго:**

| ХБ-ийн хэлбэр | Ээлжит хичээлийн зорилго |
|---|---|
| Хөнгөн хэлбэрийн ....хүүхэд | Анги дотор хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс хамааран өөр өөр зорилго тавих тохиолдолд бүлэг болгон хуваах, тус бүрээр нь “Ээлжит хичээлийн зорилгыг бичнэ. |
| Хүндэвтэр хэлбэрийн.....хүүхэд | |
| Хүнд хэлбэрийн......хүүхэд | |

Загвар

### (2) Ээлжит хичээлийн хөтөлбөр /Явц/

| Цаг төлөвлөлт | Сурагчийн үйл ажиллагаа /Ерөнхий явц/ | Хөнгөн хэлбэрийн хүүхдийн сургалтын агуулга /Сурагчийн үйл ажиллагаа/ | Хүндэвтэр хүүхдийн сургалтын агуулга /Хүүхдийн үйл ажиллагаа/ | Хүнд хэлбэрийн хүүхдийн сургалтын агуулга /Сурагчийн үйл ажиллагаа/ | Багшийн үйл ажиллагаа/хичээлийн явцад анхаарах зүйл | Бэлдэх зүйл /Сургалтын хэрэглэгдэхүүн, тарааж өгөх материал/ |
|---|---|---|---|---|---|---|
| Сэдэлжүүлэлт ....минут | Хичээлийн явцын тухайд гэвэл энэ цагийн хичээлээр ерөнхийдөө ямар үйл ажиллагаа явуулах талаар бичнэ. | | | | Багш юу хийх тухай бичнэ. Мөн хичээл явуулж байхдаа тусгайлан анхаарах зүйлийн талаар бичнэ. Үйлийн эзэн нь багш байхаар бичнэ. Хичээл заагч багш уу, туслах багш уу гэдгийг ялгаж бичнэ. | Сургалтын хэрэглэгдэхүүн болон тарааж өгөх материал зэрэг бэлдэх зүйлийн талаар бичнэ. Шаардлагатай тоо, хэмжээг тодорхой бичнэ. |
| Эхлэл .....минут | | Бүлэг тус бүрийн хүүхдийн хийх үйл ажиллагааны агуулгыг бичнэ. Үйлийн эзэн нь хүүхэд байхаар бичнэ гэдгийг анхаараарай. | | | | |
| Өрнөл ......минут | | | | | | |
| Дүгнэлт ..... минут | | | | | | |

### Ээлжит хичээлийн үнэлгээ болон дараагийн хичээлд бэлдэж бичсэн багшийн тэмдэглэл

| | |
|---|---|
| Мэдлэгийн ойлголт: Хичээл дууссаны дараа, хичээлийг эргэн харж үнэлгээ хийх шалгуурыг бичнэ. Бичихдээ дараах гарчгаар хуваавал ойлгомжтой. Мөн үнэлгээ нь дараагийн хичээлд бэлдэх тэмдэглэл болох юм. | Сонирхол-хүсэл эрмэлзэл, байр байдал: |
| Ур чадвар: | Бодол-шийдвэр-илэрхийлэх: |